

# Сайн мэдээг заах ба судлах нь

*Шашны семинар ба институтийн багш, удирдагч нарт зориулсан гарын авлага*

# Сайн мэдээг заах ба судлах нь

*Шашны семинар ба институтийн багш,*
*удирдагч нарт зориулсан гарын авлага*

Есүс Христийн Хожмын Үеийн
Гэгээнтнүүдийн Сүмээс хэвлэн гаргав.
Юта муж, Солт Лейк хот

Санал хүсэлт ба засвар оруулах хүсэлтийг баяртайгаар хүлээн авна. Санал хүсэлт болон алдаануудын талаар
Seminaries and Institutes of Religion Administration
50 E. North Temple Street, Floor 9
Salt Lake City, UT 84150-0009, USA хаягаар захидал илгээнэ үү.
Э-мэйл хаяг: ces-manuals@ldschurch.org

Нэр, хаяг, тойрог ба гадасны нэрээ бичнэ үү. Мөн номынхоо нэрийг
заавал бичээрэй. Дараа нь санал хүсэлтээ бичнэ үү.
© 2012 by Intellectual Reserve, Inc.
Бүх эрх хамгаалагдсан
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.
Англи эхийн зөвшөөрөл: 12/11
Орчуулгын эрх: 12/11
*Gospel Teaching and Learning*-ын орчуулга
Mongolian
10581 363

# Гарчиг


Удиртгал . . . . . V
Аврагчийн арга барилаар заах нь . . . . . V

Оршил . . . . . IX
Сүмийн боловсролын систем . . . . . IX
Шашны семинар ба институт . . . . . IX

1. Зорилго . . . . . 1
Бидний зорилго [1.1] . . . . . 1
Амьдрах [1.2] . . . . . 2
Заах [1.3] . . . . . 5
Удирдах [1.4] . . . . . 7

2. Сайн мэдээг заах ба судлах үндэс . . . . . 10
Сүнсээр зааж, суралцах нь [2.1] . . . . . 10
Хайр, хүндэтгэл болон зорилго агуулсан суралцах орчинг бүрдүүлэх [2.2] . . . . . 13
Судраас өдөр бүр судалж, хичээлийн материалыг унших [2.3] . . . . . 19
Судруудын болон бошиглогчдын үгсийн нөхцөл байдал, агуулгыг ойлгох [2.4] . . . . . 23
Сайн мэдээний сургаал ба зарчмуудын үнэн болоод чухал ач холбогдлыг ойлгож, танин мэдэрч, амьдралдаа хэрэгжүүлэх [2.5] . . . . . 26
Сайн мэдээний сургаал ба зарчмыг тайлбарлах, хуваалцах мөн гэрчлэх [2.6] . . . . . 31
Төгс эзэмших судрын хэсгүүд болон үндсэн сургаалууд [2.7] . . . . . 34

3. Шашны семинар ба институтэд судруудаас заах нь . . . . . 38
Сайн мэдээг заах ба судлах үндсийг хэрэгжүүлэх нь [3.1] . . . . . 39
Лук 5: Жишээ [3.2] . . . . . 42

4. Заахын тулд бэлтгэх нь . . . . . 47
Хувийн бэлтгэл [4.1] . . . . . 47
Суралцагчийн бэлтгэл [4.2] . . . . . 49
Хичээлийн бэлтгэл [4.3] . . . . . 51

5. Заах арга барил ба ур чадвар . . . . . 58
Асуултууд [5.1] . . . . . 58
Ангийн ярилцлага [5.2] . . . . . 63
Ангид судраас хамтдаа унших [5.3] . . . . . 64
Багшийн хичээлийн танилцуулга [5.4] . . . . . 65
Түүх [5.5] . . . . . 66
Жижиг бүлгийн ярилцлага ба даалгавар [5.6] . . . . . 67
Бичих дасгал [5.7] . . . . . 68
Самбар [5.8] . . . . . 69
Үзүүлэн ба зураг [5.9] . . . . . 70
Дүрс бичлэг ба компьютер дээр үзүүлэх танилцуулга [5.10] . . . . . 70
Дуу хөгжим [5.11] . . . . . 74
Нийтлэг зөвлөмж ба анхааруулга [5.12] . . . . . 76

6. Багшийн ур чадвараа үргэлж сайжруулах . . . . . 78
Их Эзэний амлалт [6.1] . . . . . 79

Индекс . . . . . 81



# Удиртгал

“Өөрсдөдөө дүгнэлт хийж, багшлах ур чадвараа сайжруулахыг эрэлхийлэх үед бидэнд хэн хамгийн сайн үлгэр жишээ болж чадах вэ? Өөрсдийн санаа, зорилт, арга барилыг Есүс Христийнхтэй харьцуулан дүгнэхээс илүү сайн судлах арга байдаг гэж үү?” (Боид К.Пакер, *Teach Ye Diligently,* [1991], 22).

## Аврагчийн арга барилаар заах нь

Аврагчийн тухай юу мэддэг болохоо хэсэгхэн зуур тунгаан бод. Та Түүнийг дагалдагч нараа тойруулан байгаагаар төсөөлөн харж чадах уу? Та Түүнийг Галил нуурын дэргэд маш олон хүнд зааж байгаагаар эсвэл худаг дээрх эмэгтэйтэй ярилцаж байгаагаар төсөөлж чадах уу? Та Түүний зааж мөн удирдаж байгаа байдлаас юуг харж байна вэ? Бусдад сурч, сүнслэгээр өсч, Түүний сайн мэдээнд хөрвөхөд Тэр хэрхэн тусалсан бэ?

Тэр тэднийг хайрлаж, тэдний төлөө залбирч, үргэлж тэдэнд үйлчилж байсан. Тэрээр тэдэнтэй хамт байх боломжийг үргэлж гаргаж, тэдэнд хайраа илэрхийлдэг байлаа. Тэр тэдний сонирхол, найдвар, хүслийг мөн амьдралд нь юу тохиолдож байгааг мэддэг байсан.

Тэр тэдний хэн болох мөн хэн болж чадахыг мэддэг байв. Тэднийг сурч мөн өсч хөгжихөд нь туслах, зөвхөн тэдэнд тохирсон онцгой арга замуудыг Тэрээр олсон юм. Зовж цөхрөх үед нь Тэрээр хэзээ ч тэднийг орхилгүй харин үргэлжлүүлэн хайрлаж, тэдэнд тохинуулсаар байлаа.

Тэрээр ганцаар залбирч, мацаг барин заахад Өөрийгөө бэлтгэдэг байв. Өдөр бүр Тэрээр хувиараа Тэнгэрлэг Эцэгийнхээ удирдамжийг эрэлхийлдэг байсан.

Тэрээр Өөрийн номлолыг зааж, гэрчлэхдээ судруудыг ашигладаг байлаа. Тэрээр хүмүүст өөрсдөд нь зориулсан судруудын талаар бодож, асуултынхаа хариултыг судруудаас олохыг заасан. Түүнийг хүч чадал, эрх мэдэлтэйгээр заахад Бурханы үгс хүмүүсийн зүрх сэтгэлд үнэний дөлийг ноцоож, тэд судрууд үнэн гэдгийг мэдсэн.

Тэрээр хүмүүст ойлгоход амархан энгийн түүх, сургаалт зүйрлэл ба амьдралын жишээнүүдээс хуваалцдаг байсан. Тэрээр тэдэнд сайн мэдээний сургаалуудыг хувийн туршлага болон эргэн тойронд буй ертөнцөөсөө олж мэдэхэд нь тусалдаг байв. Тэрээр загасчлах, хүүхэд мэндлэх мөн талбайд ажиллах тухай өгүүлсэн. Нэг нэгнээ харж хандах талаар Тэрээр заахдаа алдагдсан хонинуудыг аварсан тухай түүхийг хуваалцсан билээ. Тэнгэрлэг Эцэгийн өгөөмөр халамжинд итгэхийг дагалдагчиддаа заахдаа Тэрээр “талбай дахь сараана цэцгийн” талаар бодохыг тэднээс хүссэн.

Тэрээр тэднээс тунгаан бодож, ухаж ойлгох асуултуудыг асуудаг байв. Тэр тэдний хариултуудыг чин сэтгэлээсээ сонсож, тэдний итгэлтэй байдалд баясдаг байсан. Тэр тэдэнд хувийн асуултуудаа асуун, бодол санаагаа хуваалцах боломжийг олгож, асуултуудад нь хариулан, туршлагыг нь сонсдог байлаа. Тэр тэднийг хайрласан учраас тэд Түүнтэй бодол санаа, хувийн асуудлаа илэн далангүй хуваалцдаг байсан.



Тэрээр тэднийг гэрчлэхэд урьдаг байсан бөгөөд гэрчлэлээ хуваалцах үед нь Сүнс тэдний зүрх сэтгэлийг хөндддөг байв. “Та нар намайг хэн гэж хэлэх вэ?” гэж Түүнийг асуухад “Та бол Христ, амьд Бурханы Хүү мөн” хэмээн Петр хариулав. Түүнийг ийн хариулахад гэрчлэл нь хүчирхэгжэв.

Тэр тэдэнд итгэж, тэднийг бэлтгэж, тэдэнд заах, адислах мөн бусдад үйлчлэх чухал үүрэг хариуцлагуудыг өгсөн. “Бүх дэлхийгээр явж, сайн мэдээг бүх бүтээлд тунхаглагтун” гэж Тэрээр тушаасан. Түүний зорилго нь бусдад үйлчлэх үйлчлэлээрээ дамжуулан хөрвөгдөхөд нь тэдэнд туслах явдал байв.

Тэрээр тэднийг итгэлээрээ үйлдэж, Түүний заасан үнэний дагуу амьдрахыг урьсан. Өөрийн бүх сургаалдаа Тэр дагалдагчид нь бүх зүрх сэтгэлээрээ сайн мэдээний дагуу амьдрахад нь туслахад анхаардаг байв. Үүнийг биелүүлэхийн тулд Тэр тэдэнд зориулан үр нөлөөтэй туршлагуудаас суралцах боломжуудыг олсон. Тэрээр Нифайчуудад айлчлах үедээ тэднийг харж, мэдэрч, мэдэж болохын тулд Түүн рүү нэг нэгээрээ ирэхийг урьсан. Тэд Түүний



захиасыг бүрэн ойлгоогүйг мэдрээд тэднийг гэртээ очиж, өөрсдийгөө бэлтгэн ирж, илүү ихийг суралцахыг хүссэн.

Бүх зүйлд Тэрээр тэдний үлгэр дуурайл мөн зөвлөгч нь байсан. Тэдэнтэй хамтдаа залбирч мөн тэдэнд залбирахыг заасан. Тэднийг хайрлаж, үйлчилсэн шигээ тэдэнд хайрлаж, үйлчлэхийг Тэр заасан. Түүний заасан аргаар сайн мэдээгээ заахыг Тэрээр тэднээс хүссэн.

Аврагчийн заах арга зам нь дэлхийн заах аргаас өөр гэдэг нь тодорхой юм.

Тийм учраас Аврагчийн арга барилаар заах нь та нарын ариун дуудлага мөн. Та нар ийн заах аваас өсвөр үеийнхэн маань сайн мэдээний үрийг зүрх сэтгэлдээ суулган, өсч, хөгжих болно. Энэ нь та нарын заах гол зорилго болох тэрхүү хөрвөлт рүү тэднийг хөтлөх болно. Та нар өсвөр үеийнхэнд хөрвөгдөхөд нь тусалснаар Аврагчийг насан туршдаа дагаж, номлолд үйлчлэн, ариун сүмийн ёслолуудыг хүлээн авч, зөв шударга гэр бүлийг үүсгэн, Бурханы хаант улсыг дэлхий дахинаа байгуулахад нь тэдэнд туслах болно.



# Оршил

## Сүмийн боловсролын систем

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн боловсролын систем (СБС) нь Боловсролын хороо болон Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Итгэмжит төлөөлөгчийн зөвлөлүүдийн удирдлага дор үйл ажиллагаагаа явуулдаг. Тэргүүн Зөвлөлийн гишүүд, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын сонгогдсон гишүүд, Ерөнхий Эрх Мэдэлтнүүд болон Сүмийн ерөнхий албан тушаалтнууд нь Сүмийн боловсролын хорооны гишүүд юм.

Сүмийн Боловсролын Системийн салбаруудад Шашны семинар ба институт, Бригам Янгийн Их сургууль, Айдахо дахь Бригам Янгийн Их сургууль, Хавайн Бригам Янгийн Их сургууль болон ХҮГ-ийн Бизнесийн коллеж багтдаг.

## Шашны семинар ба институт

Шашны семинар ба институт нь ажлын өдрүүдэд өсвөр үеийнхэн болон залуу насанд хүрэгчдэд шашны боловсролыг олгодог. Нэгдсэн Улсаас гаднах зарим бүсүүдэд Шашны семинар ба институт нь бага болон дунд сургуулиудыг удирдан чиглүүлдэг.

Шашны семинар ба институтийн гол зорилго нь энгийн боловсрол бус шашны боловсрол олгох явдал юм. Шашны боловсрол нь мөнхийн утга учиртай бөгөөд энэ нь Их Эзэний Сүнсний нөлөөг шаарддаг билээ. Ерөнхийлөгч Ж.Рубен Кларк Бага семинар ба институтийн багш нарт хандан заахдаа: “Багш нар та нарт агуу үүрэг хариуцлага бий. Эгэл хүний үл хүрэх асар их нөлөөтэй өчигдрийн мөнхийн байдал, өнөөдрийн зуурдын амьдрал, маргааш үүрд мөнхөд байх ютай ч зүйрлэшгүй бөгөөд үнэлж баршгүй сургаалыг заагч багш нарын хувьд та нар боловсролын хамгийн оргилд нь зогсдог билээ” гэжээ (*The Charted Course of the Church in Education,* . хэвлэлт. 1994, 9).

Дэлхий даяарх мянга мянган семинар, институтийн багш, удирдагч нар Сүмийн өсвөр үеийнхэн болон залуу насанд хүрэгчдэд Есүс Христийн сайн мэдээг суралцаж, түүний зарчмуудын дагуу амьдрахад нь тусалж байна.

Энэхүү хүчин чармайлтанд тус дэм болохын тулд *Сайн мэдээг заах ба судлах нь* гарын авлагыг багш нарт зориулан гаргасан юм. Энэ ном нь судлах материал мөн. Багш нар үүний утга агуулгатай танилцаж сайтар судлан, байн байн лавлан эш татаж, суралцагчдад хамгийн их тустай байж болох хэсгүүд дээр анхаарлаа хандуулан, төвлөрөх ёстой. Энэхүү гарын авлагаас суралцаж, Их Эзэний удирдамжийг эрэлхийлэх аваас Тэрбээр багш нарыг бэлтгэн, суралцагсадтайгаа харилцаагаа гүнзгийрүүлэх, заах арга барилаа сайжруулах мөн Түүний ажлыг бүрэн гүйцэтгэхэд нь Сүнсээр адислах болно.

# Шашны семинар ба институтийн зорилго

Бидний зорилго нь өсвөр үеийнхэн болон залуучуудыг Есүс Христийн сургаал ба Цагаатгалыг ойлгон, үүнд найдаж, Ариун сүмийн адислалуудыг хүлээн авахад зохистой байж, өөрсдийгөө болон гэр бүлээ түүнчлэн бусдыг Тэнгэр дэх Эцэгтэйгээ хамт байх мөнхийн амьдралд бэлтгэхэд нь туслахад оршдог.

Зорилгодоо хүрэхийн тулд:

## Амьдрах

Бид Есүс Христийн сайн мэдээгээр амьдарч, Сүнсний нөхөрлөлийг эрэлхийлдэг. Бидний биеэ авч явах байдал болон зан харьцаа нь гэр орон, анги танхим мөн нийгэмд үлгэр жишээ болох ёстой. Бид амжилт, мэдлэг, хандлага болон зан төлөвөө үргэлж сайжруулахыг хичээдэг.

## Заах

Бид суралцагсдад сайн мэдээний сургаал ба зарчмуудыг бошиглогчдын үгс болон судрууд дээр байгаагаар нь заадаг. Энэхүү сургаал болон зарчмуудыг ойлгож, сэнхрэхэд нь чиглүүлэн заадаг. Бид суралцагсдад суралцах явцдаа өөрсдийн үүргээ биелүүлэхэд нь тусалдаг ба сайн мэдээг бусдад заахад бэлтгэдэг.

## Удирдах

Бид хөтөлбөр болон нөөц бололцоогоо зохистойгоор зохион байгуулдаг. Бидний хүчин зүтгэл эцэг эхчүүдэд гэр бүлээ хүчирхэгжүүлэхэд нь тусалдаг. Бид суралцагсаддаа хамтдаа суралцан нөхөрлөх сүнслэг орчинг бүрдүүлэхийн тулд санваартны удирдагчидтай нягт холбоотой ажилладаг.

# Зорилго

1

Есүс Христийн сайн мэдээг заах ариун итгэл багш нарт өгөгдсөн. Тэдний зорилго бол зүгээр нэг хичээл заахаас хавьгүй илүү утга учиртай. Ахлагч Даллин Х.Өүкс хэлэхдээ: “Сайн мэдээний багш зөвхөн захиасыг дамжуулж эсвэл сургаалыг номлосноор сэтгэл нь ханадаггүй. Агуу багш хүн Их Эзэний хүүхдүүдийг мөнхийн амьдралд авчрах мөн Түүний ажилд туслахыг эрэлхийлдэг” (“Gospel Teaching,” *Ensign,* 1999 оны 11-р сар, 80) гэжээ.

Багш болон удирдагчдад Их Эзэний ажилд туслах тэдний хүчин чармайлтанд нь тодорхой чиглэл өгөхөд Шашны семинар ба институтийн зорилго оршдог.

## Бидний зорилго [1.1]

**Бидний зорилго нь өсвөр үеийнхэн болон залуучуудыг Есүс Христийн сургаал ба Цагаатгалыг ойлгон, үүнд найдаж, Ариун сүмийн адислалуудыг хүлээн авахад зохистой байж, өөрсдийгөө болон гэр бүлээ, түүнчлэн бусдыг Тэнгэр дэх Эцэгтэйгээ хамт байх мөнхийн амьдралд бэлтгэхэд нь туслахад оршино.**

Хүүхдүүдээ мөнхийн амьдралд оруулахыг Тэнгэрлэг Эцэг маань хүсдэг (Мосе 1:39-г үзнэ үү). “Цорын ганц үнэн Бурхан Таныг болон Таны илгээсэн Есүс Христийг мэдэх нь мөнхийн амь мөн” (Иохан 17:3) хэмээн Аврагч заажээ. Иймээс шашны боловсролын анхаарлаа хандуулах гол зорилго нь суралцагсдад Тэнгэрлэг Эцэг ба Түүний Хүү Есүс Христийг мэдэж, хайрлан мөн Аврагчийн сургаал болон Цагаатгалыг ойлгон, үүнд найдахад нь туслах явдал юм.



Есүс Христийн Цагаатгал нь авралын төлөвлөгөөний гол цөм мөн. Сайн мэдээний бүх сургаал, зарчмуудыг үүсгэн бий болгосон суурь нь Цагаатгал бөгөөд энэ нь сайн мэдээг заах ба судлах хүн бүрийн зүрх сэтгэлд орших ёстой үнэн юм. Ахлагч Боид К.Пакер Цагаатгал “бол Христийн сургаалын үндсэн суурь мөн. Магадгүй та нар сайн мэдээний салбар мөчрүүдийн тухай ихийг мэддэг байж болох юм. Гэтэл та нарын мэдэх энэхүү мөчир нь үндэстэйгээ холбоогүй бол мөн мөчрүүд нь модноосоо, тийм ээ, энэ үнэнээсээ цавчигдсан бол тэдгээрт амьдрал үгүй бас гэтэлгэл ч үгүй юм” (“The Mediator,” *Ensign,*1977 оны 5-р сар, 56) хэмээн гэрчилсэн.

Есүс Христийн талаар суралцаж байгаа хүмүүс Түүний сургаал ба үлгэр жишээг дагаж, Цагаатгалыг нь амьдралдаа хэрэгжүүлэх аваас хүч чадлыг олж уучлал, эдгэрэлт, хөрвөлтийг хүлээн авч чадна. Ахлагч Хенри Б.Айринг заахдаа:

“Бид илүү тэнгэрлэг зорилтуудыг тавих хэрэгтэй. Бид семинар ба институтэд бүртгүүлэх, хичээлдээ тогтмол суух, төгсөх, судруудын мэдлэгээ сайжруулах, үнэнийг батлах Ариун Сүнсийг мэдрэх зэрэг

Тэмдэглэл

байнга тавьдаг зорилтуудаа сахих хэрэгтэй. Үүн дээр нэмээд бид номлолд үйлчлэх, ариун сүм рүү явахын төлөө тэмүүлэх хэрэгтэй. Тэд бидний шавь байх хугацаандаа илүү ихийг хүлээж авах ёстой. . . .

"Бид өсвөр үеийнхэнд Аврагч Есүс Христийг хайрлахыг заах аваас тэд Есүс Багшийн жинхэнэ дагалдагчид болох болно. Энэхүү үйл явц нь тэдний үнэнч шударга, хайраар дүүрэн нөхрүүд ба эцгүүд, эхнэрүүд ба ээжүүд, мөнхийн гэр бүлийн удирдагчид болоход нь бэлтгэдэг. Ариун сүм тэдний амьдралын илүү бодит, чухал хэсэг нь байх болно. Тэд залуу насанд хүрэгч байхдаа ч хожим нь ахмад хосууд болсон ч Их Эзэндээ үйлчлэх номлогчид байх болно. . . . Бид өсвөр үеийнхнийг Христ рүү чиглүүлэн хүчирхэгжүүлснээр гэр бүлүүд болон Сүмээ хүчирхэгжүүлдэг."



Диетер Ф.Угдорф, "A Teacher of God's Children" Ерөнхийлөгч Диетер Ф.Угдорфтой хийсэн уулзалт, 2011оны 1-р сарын 28, 3)

"Есүс Христийн цэвэр сайн мэдээ Ариун Сүнсний хүчээр суралцагсдын зүрх сэтгэлд нэвтрэн орох ёстой. . . . Бидэнтэй хамт байхад нь суралцагсдыг Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээнд бүрэн хөрвүүлэх нь бидний зорилго байх ёстой" ("We Must Raise Our Sights" Мормоны Номын талаарх СБС-ийн чуулган, 2001 оны 8-р сарын 14, 2) гэжээ.

Жинхэнэ хөрвөлт нь ариун сүмийн ёслолуудаар дамжуулан авах боломжтой Есүс Христийн сайн мэдээний хамгийн агуу адислалууд руу хөтөлдөг. Суралцагсад ариун сүмийн гэрээнүүдийг итгэлтэйгээр хийж мөн сахивал мөнхийн гэр бүл болон өргөмжлөлийг агуулсан адислалуудыг хүлээн авахад зохистой болно. Тэд сүнслэг хүч, амар амгалан байдал хийгээд хувийн илчлэлтийг илүү ихээр авах болно.

Аврагч ба ариун сүм дээр амьдралаа төвлөрүүлсэн суралцагсад дэлхийн уруу таталт, хууран мэхлэлтийг сөрөн зогсох агуу их хамгаалалтыг олж авдаг бөгөөд Тэнгэр дэх Эцэгийн тэднээс хүссэн бүхнийг биелүүлэх илүү сайн бэлтгэлтэй болдог. Тэд мөнхийн амьдрал руу хөтлөх зам дээр баттайгаар зогсох хүчтэй болж, гэр бүлийнхэн болон бусдыг Христийг дагагчийн жимийг олж, дагахад нь илүүтэйгээр тусалж чадна.

## Амьдрах [1.2]

### Бид Есүс Христийн сайн мэдээгээр амьдарч Сүнсний нөхөрлөлийг эрэлхийлдэг [1.2.1]

С ба И (семинар ба институт)-ийн Зорилгод дурдсан Есүс Христийн сайн мэдээнд туутай, итгэлтэй мөн дуулгавартай байх үүргээ биелүүлэхэд суралцагсдад туслах нь багшийн оруулж чадах хамгийн чухал хувь нэмрийн нэг юм. Багш нар Христтэй адил зан төлөвтэй болохыг, Тэнгэрлэг Эцэгийг танин мэдэхийг мөн Түүнийг амьдралдаа үргэлж эрэлхийлэхийг хичээх аваас суралцагсдад сайн мэдээг хүлээн авч, ойлгоход нь нөлөөлөх тэнгэрлэг хүч чадлаар адислагддаг.

Багш нар сайн мэдээний дагуу итгэлтэйгээр амьдарвал Ариун Сүнсний нөхөрлөлийг олох зохистой болдог. Ариун Сүнстэй нөхөрлөх энэхүү нөхөрлөл нь семинар ба институтийн багш нарыг амжилт гаргахад нэн чухал байдаг. Сургаал ба Гэрээнд Их Эзэн "хэрэв та нар Сүнсийг эс хүлээн авбаас та нар заах нь үгүй" (С ба Г 42:14) хэмээсэн байдаг. Ахлагч Роберт Д.Хейлс: "Шашны семинар ба институтийн багш нарын үүрэг хариуцлага маш өндөр юм. Гэхдээ эдгээр үүрэг хариуцлагыг биелүүлэхийн тулд багш нар юуны түрүүнд хувийн зөв шударга байдлын төлөө чармайх хэрэгтэй. Багш нар бид үргэлж Сүнстэй байхаар сайн мэдээний дагуу амьдрах ёстой" ("Teaching by Faith" Ахлагч Роберт Д.Хейлстэй хийсэн уулзалт 2002 оны 2-р сарын 1, 1) хэмээн зөвлөсөн.

Тэмдэглэл

## Бидний биеэ авч явах байдал болон зан харьцаа нь гэр орон, анги танхим, нийгэмд үлгэр жишээ болох ёстой [1.2.2]

Багш нар зөв шударга байж, өөрсдийн заадаг сургаал ба зарчмуудын зохистой жишээ болон амьдрах үүрэг хариуцлагатай. Ямар ч нөхцөл байдалд багш нар Их Эзэнд хайртай, Ариун Сүнстэй нөхөрлөдөг хүний хувиар ярьж, үйлчилж, үүний дагуу амьдрах ёстой.

Багш нар гэр орондоо хэрхэн амьдарч мөн эхнэр, нөхөр, үр хүүхдүүдтэйгээ ямаршуу харьцаатай байх нь маш чухал юм. Эдгээр хамгийн чухал харилцааг “сэнхрүүллээр, тэсвэр тэвчээрээр, элдэг зөөлөн хийгээд номхон дөлгөөнөөр, чин сэтгэлийн хайраар” харуулдаг байх хэрэгтэй (С ба Г 121:41). “Эхнэр, нөхрийн хувьд та нарыг хоорондоо маш сайхан харилцаатай гэдэгт бид итгэдэг. Та нарын гэр оронд амар амгалангийн сүнс, Аврагчийн хайр оршиж, танайд ирсэн хүмүүст энэ нь харагддаг гэдэгт бид итгэдэг. Танай гэр оронд хэрүүл маргаан байх ёсгүй. . . . Хосууд хийж байгаа зүйлс болон байгаа байдлаараа үргэлж Тэргүүн Зөвлөлийг төлөөлдөг юм шүү” (“The Gospel Teacher and His Message” СБС-ийн шашны багш нарт хандан хэлсэн үг, 1976 оны 9-р сарын 17, 7) хэмээн Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон мэдэгдсэн байдаг.

Багш нар өдөр бүр ангидаа энэрэл, тэвчээр, нинжин сэтгэл, хүндэтгэл, ариун нандин зүйлст бишрэлтэй байх зэргээр Христтэй адил зан төлөвийг харуулах боломжтой байдаг. Багш нар суралцагсадтайгаа зөв зохистой харилцаатай байж, хов жив буюу хоосон таамаглал дэгдээх эсвэл буруу ойлголт, ташаа бодол төрүүлэх, хэн нэгэнд хэтэрхий анхаарал хандуулах ёсгүй.

Багш нар сургууль, олон нийтийн газар, Сүмийн үйл ажиллагаан дээр Христтэй адил зан төлөвтэйгөөр биеэ авч явахыг эрэлхийлэх хэрэгтэй. Тэд эцэг эх, хамтран ажиллагсад, Сүмийн удирдагчид болон олон нийтийн газар хүмүүстэй зөв зохистой, тусалж дэмжсэн, талархалтай харилцааг хөгжүүлэх ёстой. Багш нар эдгээр зүйлсийг үргэлж хийснээр Есүс Христийн сайн мэдээгээр амьдрах хувийн амлалтаа нотлон харуулдаг бөгөөд бусдын амьдралд сайнаар нөлөөлөх тэдний хүч улам ихсэх болно.



**“Та нарын зааж байгаа зүйлс нь та нар өөрсдөө гэдгийг та бүгд аль хэдийнээ ойлгосон биз ээ. . . . Та нарын төрх байдал, үлгэр жишээ тухайн хичээл дээрх бодит үнэнээс илүүтэйгээр дурсагдан үлддэг. . . . Хэрэв бид үнэн дагалдагчид бол энэ нь ил тод харагддаг бөгөөд дурсагдан үлдэх болно. Та нарын тухай дурсамжууд мөн хувийн зөв шударга байдал тань суралцагсдынхаа амьдралд жинхэнэ дорвитой хувь нэмэр оруулах боломжийг олгодог.”**

**Нийл А.Максвелл, “But a Few Days” СБС-ийн шашны багш нарт хандан хэлсэн үг, 1982 оны 9-р сарын 10, 2).**

## Бид амжилт, мэдлэг, хандлага болон зан төлөвөө үргэлж сайжруулахыг хичээдэг [1.2.3]

Бурханы хүүхдүүдийн хувьд багш нарт сайжрах, өсөн дэвжих, Тэнгэрлэг Эцэг ба Есүс Христтэй адил болох хүслийг өдөөх тэнгэрлэг чанар байдаг. Багш суралцагчийнхаа уг хүслийг Их Эзэн болон бусдын тусламжтайгаар цаг ямагт хөгжин дэвшихэд нь хөтлөн чиглүүлэх ёстой. Ахлагч Гордон Б.Хинкли хувийн өсөлт хөгжилтийн талаар:

“Би сайжирч, дэвших ёстойд итгэдэг. Би өсч хөгжих ёстой гэдэгт итгэдэг. . . .

Ах эгч нараа, та нар гучтай эсвэл далан настай байсан ч үргэлж өсч хөгжсөөр байгаарай” (“Four Imperatives for Religious Educators” СБС-ийн шашны багш нарт хандан хэлсэн үг, 1978 оны 9-р сарын 15, 2) хэмээн хэлсэн.

*Тэмдэглэл*

Сайжралт нь хүсэл, тууштай байдал, тэвчээр болон тунгаан бодох, залбирлаар дамжуулан Их Эзэний тусламжийг эрэлхийлэхийг шаарддаг. Өөрийгөө сайжруулах чухал зарчмыг Ахлагч Хенри Б.Айринг ийн заасан: “Бидний ихэнх нь өөрийгөө сайжруулахын тулд хүчин чармайлт гаргаж байсан. Хүмүүс ба байгууллагууд хэрхэн сайжрах тухай өөрийнхөө туршлагаас харахад юуны түрүүнд үргэлж хийдэг зүйлүүдээ бага багаар өөрчлөх нь хамгийн үр дүнтэй байдаг. Тууштай байдал ба давтан үйлдэх нь чухал байдаг. Хэрэв бид жижигхэн зөв зүйлээ өөрчлөхөөр шийдэн сүнслэгээр өдөөгдвөл тууштай мөн дуулгавартай байдал нь агуу сайжралтыг авчрах болно” (“The Lord Will Multiply the Harvest” Ахлагч Хенри Б.Айрингтай хийсэн уулзалт 1998 оны 2-р сарын 6, 3).

Семинар ба институт дээр багш нар заах чадвар, мэдлэг, хандлага болон зан төлөвөө сайжруулахыг үргэлж эрэлхийлж байх хэрэгтэй.

**Заах чадвар.** Багш нар заах арга, удирдах үүрэг хариуцлагаа сайжруулахыг байнга эрэлхийлэх ёстой. Тэд үндсэн зарчмууд болон заах ур чадвараа ойлгож сайжруулахад тэнцвэртэй, тууштай чармайлт гаргах ёстой. Багш удирдагчид нь семинар ба институтийн материалууд, зохицуулагчид, хамтран ажиллагсад, суралцагсад, санваарын удирдагчид болон бусад хүмүүсээс тусламж эрэлхийлснээр өөрсдийн заах чадвартаа илүү оновчтой үнэлгээг өгч мөн сайжруулах шаардлагатай зүйлдээ удирдамжийг авах болно.

“Ах эгч нараа бидний хэн нь ч хангалттай их зүйлийг мэддэггүй. Суралцах үйл явцад төгсгөл гэж үгүй. Бид уншиж, ажиглаж, эзэмшиж мөн оюун санаандаа ирсэн зүйлийг тунгаан бодож байх ёстой.”



(Гордон Б.Хинкли, “Four Imperatives for Religious Educators,” 2)

“Хэрэв хүмүүс надад ирэх аваас би тэдэнд өөрсдийнх нь сул доройг үзүүлэх болно. . . . Миний өмнө өөрсдийгөө даруусгадаг бүх хүмүүст миний ач ивээл хангалттай; учир нь хэрэв тэд миний өмнө өөрсдийгөө даруусгаж мөн надад итгэлтэй байх аваас тэгвэл би тэдэнд сул дорой зүйлүүдийг нь хүчирхэг болгож өгнө.”



(Ифер 12:27)

**Мэдлэг.** Багш нар судрын мөн бошиглогчдын үгсийн утга, агуулга, сургаал, зарчмуудыг судлахыг үргэлж чармайх ёстой. Тэд үүнийг хийх аваас Аврагчийн сайн мэдээ болон Цагаатгалын тухай илүү ойлгож, суралцагсдынхаа амьдралыг илүү ихээр адислах боломжтой болно. Багш нар зарчмуудын талаарх мэдлэг ба ойлголтоо өсгөж, судрууд болон семинар, институтийн материалууд дахь үр нөлөөтэй арга зүйг сайтар эзэмших ёстой. Тэд зохистой удирдах зарчмуудыг суралцаж (1.4 хэсгийн, “Удирдах” –-г үзнэ үү), семинар ба институтийн тогтсон бодлого, журмыг ойлгосон байх ёстой.

**Багшийн зан авирын хандлага.** Багш хүний хандлага нь тэдний хувийн аз жаргал хийгээд суралцагсдад сайн нөлөө үзүүлэхэд нөлөөлдөг. Үргэлж өөдрөгөөр урамшуулан дэмжиж, (С ба Г 68:6-г үзнэ үү) бусдад үйлчлэхийг эрэлхийлж, нэгдмэл байдлыг бий болгон, хүнд хэцүү үед ч өөрөөсөө шалтгаалах бүхнийг хийдэг багш нар суралцагсад болон хамт олныхоо амьдралыг адисалдаг.

**Багшийн зан төлөв.** Сайн мэдээний дагуу амьдрахыг чармайж, өөрсдийн заах арга барил, мэдлэг ба зан төлөвөө сайжруулахыг чин сэтгэлээсээ байнга эрмэлздэг багш нар нь С ба И-ийн зорилгыг гүйцэлдүүлэхэд шаардлагатай зан чанарыг аяндаа төлөвшүүлэх болно. “*Бид* өдөр бүр *хичээснээр* ямар хүн *болохыг* хүсдэг *тийм хүн* болж чадна. Зөв шударга зан чанар нь та нарыг чимэх нэгэн шинж чанар юм. . . . Зөв шударга зан чанар бол таны эзэмшдэг аливаа материаллаг зүйлс, эзэмшсэн мэдлэг эсвэл тавьсан зорилтоос тань хавьгүй илүү үнэ цэнэтэй” гэж Ахлагч Ричард Г.Скотт заасан. (“The Transforming Power of Faith and Character,” *Ensign*, *Лиахона*, 2010 оны 11-р сар, 43).

Эцсийн эцэст өөрсдийн заах арга барил, мэдлэг, төрх байдал ба зан чанараа сайжруулах гол түлхүүр нь Есүс Христийн жишээг дагах юм. Ерөнхийлөгч Ховард В.Хантер ийн хэлсэн: "Их Эзэн Есүс Христийн сургаал ба үлгэр жишээ бидний төлөв байдал, зан авир амьдралын маань бүх талбарт тийм ээ, хувь хүний хувьд, гэр оронд, ажил мэргэжилд, нийгмийн амьдралд, тэр ч бүү хэл Түүний нэрээр нэрлэгдсэн Сүмийг шүтэн бишрэхэд нөлөөлдөг" ("Standing as Witnesses of God," *Ensign,*1990 оны 5-р сар, 60).

Тэмдэглэл

## Заах [1.3]

### Бид суралцагсдад сайн мэдээний сургаал ба зарчмуудыг бошиглогчдын үгс болон судрууд дээр байгаагаар нь заадаг [1.3.1]

Есүс Христийн сайн мэдээний сургаал ба зарчмуудын талаарх мэдлэг, ойлголт ба гэрчлэл нь суралцагсдад Тэнгэрлэг Эцэгийн таалалд нийцэх сонголтуудыг хийх удирдамж болон хангалттай эрч хүчийг өгдөг.

Сургаал нь Есүс Христийн сайн мэдээний үндсэн, хэзээ ч өөрчлөгдөшгүй үнэн юм. Ахлагч Боид К.Пакер сургахдаа:




"Үнэн сургаал ойлгомжтой байх юм бол хүмүүсийн зан төлөв, харьцаа хандлагыг өөрчилж чадна.

Сайн мэдээний сургаалуудыг судлах нь зан төлөвийн талаар судлан сайжруулахаас илүү хурднаар зан төлөвийг сайжруулна" ("Little Children," *Ensign,* 1986 оны 11-р сар, 17) гэжээ.

"Зарчмууд бол олон төрлийн нөхцөл байдалд тохирдог шалгарсан үнэн юм. Үнэн зарчим нь хамгийн эргэлзээтэй, хүнд нөхцөл байдалд ч шийдвэрүүдийг тодорхой болгодог" хэмээн Ахлагч Ричард Г.Скотт цохон тэмдэглэсэн ("Acquiring Spiritual Knowledge," *Ensign,* 1993 оны 11-р сар, 86).

Багш, суралцагсад сайн мэдээний сургаал ба зарчмуудыг багтаасан судрууд болон бошиглогчдын үгсийг ойлгож, зааж, хэрэгжүүлэхийг эрэлхийлэх ёстой. Хожмын үед сайн мэдээг заах тэдгээр хүмүүст Их Эзэн: "Сайн мэдээний бүрэн байдлыг агуулдаг Мормоны Ном болон Библи дэх миний сайн мэдээний зарчмуудыг заах ёстой" (С ба Г 42:12) хэмээн зааварласан. Хожмын үеийн бошиглогчдын сургаалыг ойлгож, дагахын чухлыг Их Эзэн мөн батлан хэлсэн. "Та нарт түүний өгөх түүний бүх үгсэд хийгээд зарлигуудад анхаарал тавигтун; . . . Учир нь түүний үгийг та нар миний амнаас гарсан мэтээр хүлээн авах ёстой" (С ба Г 21:4–5).

1938 онд Ерөнхийлөгч Ж.Рубен Кларк Бага Тэргүүн Зөвлөлийг төлөөлөн хэлсэн үгэндээ семинар ба институтийн багш нарт чухал ач холбогдолтой уриалга гаргажээ. Тэрээр уг уриалгадаа:

"Та нарын хамгийн гол сонирхол, амин чухал, цорын ганц үүрэг бол Их Эзэн Есүс Христийн сайн мэдээг хожмын энэ үед илчлэгдсэн байдлаар нь заах юм. Та нар энэхүү сайн мэдээг Сүмийн жишиг бүтээлүүдээс мөн хожмын энэ өдрүүдэд Түүний хүүхдүүдийг удирдахаар Бурханаар дуудагдсан хүмүүсийн үгсээс ашиглан заана. . . .

Та хэн ч байсан гэсэн Сүмийн сургаалуудыг өөрчлөх буюу Сүмийн жишиг бүтээлийг мөн Их Эзэний хүсэл, бодлыг Сүмд тунхаглах эрх мэдэлтэй

*Тэмдэглэл*

тэдгээрийн тунхгуудыг өөрчлөн засах ёсгүй" гэжээ (*The Charted Course of the Church in Education,* [1994], 10; мөн С ба Г 42:12–13-г үзнэ үү).

### Энэхүү сургаал болон зарчмуудыг ойлгож, сэнхрэхэд нь чиглүүлэн заадаг [1.3.2]

Багш нар сайн мэдээний сургаал ба зарчмуудыг хэрхэн заахаа шийдэхдээ суралцагсдаа эдгээр чухал үнэнийг ойлгож, Ариун Сүнсээр заалган, Ариун Сүнснээс урам зориг авах арга барилыг сонгох хэрэгтэй. Багш, суралцагсад сургаал ба зарчмуудыг тэдгээрийн мөн чанар, бусад сургаал ба зарчмуудтай хэрхэн холбогдох, авралын төлөвлөгөө болон өөрсдийнх нь амьдралд ямар үүрэг гүйцэтгэж байгааг мэдсэнээр илүү ойлгодог. Хүмүүний сайн мэдээний зарчмуудын дагуу амьдарч, оюун санаагаа Ариун Сүнсээр гэрэлтүүлэх үед л мөнхийн сургаал ба зарчмуудын жинхэнэ ойлголт ирдэг юм.

Сэнхрүүлэл нь судруудын ойлголттой хамт байх ёстой. *Сэнхрэх* гэдэг үг нь *aedes* гэдэг орон байр буюу ариун сүм гэсэн утгатай мөн *facere* гэдэг хийх гэсэн утгатай латин үгсээс гаралтай юм (*Collins English Dictionary—Complete and Unabridged* 2003, "edify" гэдэг үгийг үзнэ үү). Иймээс *сэнхрэх* гэдэг нь ариун сүм барих гэдэгтэй холбогдох ба сүнслэг байдлыг байгуулах буюу хүчирхэгжүүлэх гэсэн утгатай юм. Баяр баясгалан, амар амгалан, гэгээрэл ба зөв шударга амьдрах хүсэл нь сэнхрэлтэй холбоотой. Заах болон судлах явцдаа багш суралцагч хоёул Сүнсний удирдамжийг дагах аваас "номлодог тэр нь мөн хүлээн авдаг тэр нь бие биенээ ойлгодог, мөн хоёул сэнхэрч мөн хамтдаа баясдаг буюу" (С ба Г 50:22) хэмээн сударт амласан байдаг.

### Бид суралцагсдад суралцах явцдаа өөрсдийн үүргээ биелүүлэхэд нь тусалдаг ба сайн мэдээг бусдад заахад бэлтгэдэг [1.3.3]

Хөрвөлтийг дэмжиж, суралцагсдын зүрх сэтгэлд гүн шингэхэд туслах сайн мэдээг судлах нь дан ганц багшийн тууштай зүтгэлээс илүү зүйлийг шаарддаг. Сүнслэгээр судлахад суралцагч хичээл зүтгэл гаргаж мөн өөрийн сонгох эрх чөлөөг ашиглах шаардлагатай байдаг. Ахлагч Хенри Б.Айринг заахдаа: "Жинхэнэ хөрвөлт нь суралцагчийн хүслийнхээ дагуу итгэлтэйгээр гаргах агуу хичээл зүтгэлээс хамаардаг" гэжээ. Суралцагсад зүрх сэтгэлдээ Ариун Сүнсний нөлөөг урьж авчрах тухай Ахлагч Дэвид А.Беднар ийн онцлон тэмдэглэсэн байдаг:

"Багш агуу сүнслэг хүч, үр нөлөөтэйгөөр тайлбарлан үзүүлж, ухуулан гэрчилж чадна. Гэхдээ эцсийн эцэст зөвхөн хүлээн авагч захиасын утга учир болон Ариун Сүнсний гэрчлэлийг зүрх сэтгэлдээ хүлээн зөвшөөрсөн тохиолдолд энэ нь нэвтрэн ордог. . . .

"Зөв зарчмуудын дагуу өөрийн чөлөөт сонголтыг хийгч суралцагч нь өөрийн зүрх сэтгэлийг Ариун Сүнсэнд нээж, гэрчлэгч хүч ба батлагч гэрчийг урьдаг" ("Seek Learning by Faith" Ахлагч Дэвид А.Беднартай хийсэн уулзалт, 2006 оны 2-р сарын 3, 1, 3).

Сүнслэгээр судлахыг эрэлхийлдэг тэдгээр нь өөрсдийн зүрх сэтгэл, оюун санааг заавар хүлээн авахад бэлтгэдэг; мэдлэг болон ойлголтыг авахын тулд сурч, тунгаан бодож, залбирахыг тууштайгаар эрэлхийлдэг; мөн Ариун Сүнснээс

**"Энэ нь Тэнгэрлэг Эцэг, Түүний Хүү Есүс Христэд харуулах бидний суралцах хүсэл ба Ариун Сүнсний зааврыг хүлээн авах итгэлээр өдөөгдсөн чин сэтгэлийн тууштай үйлдэл юм."**



**(Дэвид А.Беднар, "Seek Learning by Faith," 3)**

хүлээн авсан сэтгэгдлүүдээ дагадаг гэдгийг судруудад заасан байдаг (Езра 7:10; 1 Нифай 10:17–19; С ба Г 138:1–11; Иосеф Смитийн түүх 1:10–20). Судруудаас судлахын тулд хүч чармайлт гаргах нь олон суралцагчийн хувьд ойлгомжгүй, ямар нэг байдлаар хэцүү санагдаж болох юм. Гэвч багш нар тэдэнд ойлгож, хүлээн авч, сайн мэдээг судлах үүргээ биелүүлэхэд нь тусалж чадна. Багш нар суралцагсад өөрсдийн сүнслэг байдлын мэдлэгийг олж авахад нь дараах байдлаар урамшуулан дэмжиж чадна:

Тэмдэглэл

- Өдөр бүр судраас суралцах дадлыг хөгжүүлэх.
- Тэдний оюун санаа, зүрх сэтгэлийг Сүнсний нөлөөг хүлээн авахад бэлтгэх.
- Тэдний амьдралтай холбоотой сургаал ба зарчмуудыг олж, илэрхийлэх.
- Хичээнгүй оролдого, эргэцүүлэл ба залбирлаар судрын ойлголтыг нь гүнзгийрүүлэх.
- Сайн мэдээ тэдний амьдралд хэрхэн хэрэгжихийг илүү сайн ойлгоход туслах асуултуудыг асууж, хариултуудыг эрэлхийлэх.
- Бодол санаа, туршлага болон сэтгэгдлээсээ хуваалцах.
- Сайн мэдээний сургаал ба зарчмуудыг бусдад тайлбарлаж, тэдгээрийн үнэнийг гэрчлэх.
- Судар дээр тэмдэглэгээ хийх, судрын эшлэл ашиглах, суралцагчийн гарын авлагуудыг ашиглах зэрэг судраас суралцах ур чадваруудыг хөгжүүлэх.

Сүнслэг байдлыг суралцах өөрсдийн үүргээ биелүүлснээр тэд Ариун Сүнсээр заалгах хүслээ баталдаг. Тэд илүү тууштай мөн судраас суралцах илүү хүсэлтэй байдаг. Тэд авралын сургаал ба зарчмуудыг тодорхой ойлгож, заалгасан зүйлсээ илүү хүсэлтэйгээр хэрэгжүүлдэг. Суралцагсад сайн мэдээний сургаал ба зарчмуудыг олж нээх үед тэднээс асуулт асууж, хариултууд дээр нь харилцан ярилц. Тэд өөрсдөө бие даан сурснаар үнэ цэнэтэй чадваруудыг сурдаг.

Ийм байдлаар суралцагсад гэр бүлийнхэн, найз нөхөд болон бусдад сайн мэдээг илүү үр дүнтэйгээр заах боломжтой болдог. Тэд ирээдүйн номлогч, эцэг эх, багш болон Сүмийн удирдагчдын хувьд сайн мэдээний сургаал ба зарчмуудыг заахад илүү сайн бэлтгэгдэх болно.



**"Суралцагсдын хичээлд оролцох шийдвэр нь тэдний хувийн хэрэгцээтэй нийцсэн Ариун Сүнсний нөлөөн доорх чөлөөт сонголт юм. Идэвхтэй оролцох уур амьсгалыг бүрдүүлэх нь өөрийн чинь зааж чадахаас илүү чухал хичээлүүдийг Сүнс заах магадлалыг нэмэгдүүлдэг.**

**Энэхүү оролцоо суралцагсдын амьдралд Сүнсний удирдамж чиглүүллийг авчирна."**

Ричард Г.Скотт, "To Learn and to Teach More Effectively," in *Бригам Янгийн Их сургууль 2007–2008 Хэлсэн үгс* 2008, 4–5)

## Удирдах [1.4]

### Бид хөтөлбөр болон нөөц бололцоогоо зохистойгоор зохион байгуулдаг [1.4.1]

*Удирдах* гэдэг үгийг хүмүүсийг удирдах, хүмүүст үйлчлэх, хөтөлбөр ба нөөц баялагийг удирдан зохицуулах гэж тодорхойлж болно. Бүх зүйл дээрх төгс жишээний хувьд Есүс Христ жинхэнэ удирдагчийн бурханлаг чанаруудын загвар юм. Одоогийн үүрэг даалгавар нь ямар ч байсан хамаагүй семинар ба институтийн бүх удирдагч, багш нар Христтэй адил зан чанараар удирдан, зохицуулах боломж мөн үүрэг хариуцлагатай.

*Тэмдэглэл*

Энэрэл, алсын хараа, даруу байдал нь бидэнд Их Эзэний ажлыг Түүний таалаар хийх боломжийг олгодог. *Энэрэл* буюу Христийн цэвэр хайр нь багшийн суралцагсад, санваарын удирдагчид, эцэг эх, хамтран ажиллагсад ба зохицуулагчидтайгаа харьцах харилцааны үндэс байх ёстой. Энэрэл бол зүгээр нэг мэдрэмж бус харин үйлдэх болон амьдрах арга зам юм (Моронай 7:45-г үзнэ үү). *Алсын хараатай* удирдагч нь сүнслэгээр өдөөгдсөн удирдамж өгч, зорилготой болгож, эргэн тойрныхоо хүмүүст өөдрөг үзлийг төлөвшүүлдэг. Судруудад "алсын хараа байхгүй бол ард түмэн дэг журамгүй" хэмээн заасан байдаг (Сургаал үгс 29:18). *Даруу* зан нь удирдагч, багш нарт Их Эзэнээс хамааралтай гэдгээ ойлгож, С ба И-ийн зорилгоо биелүүлэхийн тулд бусадтай хамтран ажиллахад нь урамшуулдаг. "Өөрийнх нь анхаарал халамжинд итгэж даалгасан бүх зүйлд даруу төлөв хийгээд хайраар дүүрэн, итгэл, найдвар, мөн энэрэлтэй, биеэ барьдаг байхаас бусдаар өөр хэн ч энэ ажилд тусалж эс чадна" хэмээн Их Эзэн айлдсан (С ба Г 12:8).

**"Мөн энэрэл бол удаан тэсвэрлэдэг, мөн сайхан сэтгэлтэй, мөн атаархаж жөтөөрхөх нь үгүй, мөн онгирч хөөрдөггүй, өөрийнхийгөө эрэлхийлдэггүй, амар өдөөн хатгагддаггүй, ямар ч хилэнцтийг боддоггүй, мөн алдаст баясах нь үгүй, харин үнэнд баясдаг, бүх зүйлийг хүлцдэг, бүх зүйлд итгэдэг, бүх зүйлд найддаг, бүх зүйлийг тэвчдэг."**



**(Моронай 7:45)**

Багш, удирдагч бүрт хөтөлбөр ба нөөцийг зөв зохистойгоор удирдан чиглүүлэх боломж мөн үүрэг хариуцлага бий. Удирдах үүрэг хариуцлага нь хувь хүмүүсийг адислах сүнслэг зорилготой билээ. "Төсөв ба тайлан гаргах, Сүмийн эд хөрөнгө, материалуудыг хайрлан хямгадах, аюулгүй байдлыг хангах, хөтөлбөрүүдийг хянах, . . . зөвлөлүүдэд оролцох мөн суралцагсад, эцэг эх, санваарын удирдагчидтай харилцах зэрэг нь удирдах үүрэг хариуцлагад онцгой чухал юм (*Зохистойгоор удирдах нь: БТС-н удирдагч болон багш нарын гарын авлага* 2003, 2). Ахлагч Хенри Б.Айринг: "Үйлчилж байгаа хүмүүсийнхээ төлөө хийх материаллаг зүйлсийн сүнслэг үнэ цэнийг хэзээ ч бүү дутуу үнэл" хэмээн заасан байдаг ("The Book of Mormon Will Change Your Life" CES symposium on the Book of Mormon,1990 оны 8-р сарын 17, 7).

### Бидний хүчин зүтгэл эцэг эхчүүдэд гэр бүлээ хүчирхэгжүүлэхэд нь тусалдаг [1.4.2]

Эцэг эхчүүд нь хүүхдүүддээ Есүс Христийн сайн мэдээг заах, тэдний нийгэмших байдал, бусадтай харилцах харилцаа, хувцаслалт, биеэ авч явах жишиг зэрэгт хяналт тавих үндсэн үүрэгтэй. Тэд хүүхдүүдийнхээ сургаалын талаарх асуултанд хариулах үүрэгтэй. Эцэг эхийн энэхүү үүрэгт Сүмийн удирдагчид тусална.

Семинар, институтийн удирдагч ба багш нар судруудад мөн бошиглогчдын хэлсэн үгсэд бичсэнчлэн Есүс Христийн сайн мэдээг зааж, гэр бүл, гэр бүлийн гишүүд ба гэр бүлийн үйл ажиллагаануудын сургаалын чухал ач холбогдлыг онцлон заасанаар эцэг эхчүүдэд тусалдаг (*Зохистойгоор удирдах нь гарын авлагыг,* үзнэ үү 4). Багш нар суралцагсдыг эцэг эхээ хүндэлж, тэдний зөвлөгөө ба удирдамжийг дагахад урамшуулах ёстой. Мөн багш нар ангид заасан зүйлсээ эцэг эхчүүдтэй хуваалцаж болно.

Тэмдэглэл

### Бид суралцагсдад хамтдаа суралцан нөхөрлөх сүнслэг орчинг бүрдүүлэхийн тулд санваартны удирдагчидтай нягт холбоотой ажилладаг [1.4.3]

Шашны институт ба семинарын бүх хөтөлбөр санваарын зохих түлхүүрүүдийг атгадаг ерөнхий болон орон нутгийн санваарын удирдагчдын хоёулангийнх нь удирдлага дор явагддаг.

Семинар ба институтийн удирдагчид, багш нар орон нутгийнхаа санваарын удирдагчидтай ойр дотно ажилласнаар өсвөр үеийнхэн, залуу насанд хүрэгчдийг адислах болно. Санваарын удирдагчдын удирдлага дор тэд өсвөр үеийнхэн ба залуу насанд хүрэгч бүр сургалтын зохих ангиудад бүртгүүлж, хамрагдаж мөн зохих хичээлүүдийг авч төгссөн байхыг урьж, урамшуулан дэмжсэн эсэхэд анхааран хамтран ажиллаж, зөвлөлдөнө. Багш, зохион байгуулагчид семинар ба институтийн суралцагсдыг бүртгэх, идэвхтэй үлдээх ажилд санваарын удирдагчидтай хамтран ажиллах ёстой. Тэд зөвхөн ангид ирсэн суралцагсдад заагаад сэтгэл хангалуун байж болохгүй.

Гаргасан журам, зааврын дагуу семинар ба институтийн багш, удирдагч нар санваарын удирдагчидтай хамтран ажиллаж, сайн мэдээний мэдлэгийг тэлж, гэрчлэлийг хүчирхэгжүүлэх сүнслэг уур амьсгалыг бүрдүүлэх ёстой. Багш, зохион байгуулагчид семинар, институтийн одоогийн дэг журмыг дагах ёстой. Тэд төлөвлөсөн, санваар болон туслах бүлгийн удирдагчдын удирдан явуулдаг үйл ажиллагаануудад саад бололгүй, тусалж дэмжих зорилгоор олон нийтийн болон үйлчлэлийн үйл ажиллагаануудын төрөл, давтамжийн талаар орон нутгийн удирдагчидтай зөвлөлдөх ёстой.

Мөн багш болон зохион байгуулагчид Залуу Эрэгтэйчүүд, Залуу Эмэгтэйчүүдийн удирдагчидтай хамтран ажиллаж, өсвөр үеийнхэн “Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь” ба “Хувийн хөгжил дэвшил” хөтөлбөрүүдэд оролцохыг зохистойгоор урамшуулан дэмжих ёстой. Боломжтой газруудад семинарын багш нар өсвөр үеийнхний хэрэгцээ шаардлагын талаар бусад багш, зөвлөгч мөн өсвөр үеийнхний удирдагчидтай зөвлөлдөх ёстой.

(Семинар ба институтийн удирдлагын зарчим ба үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүйг *Зохистойгоор удирдах нь гарын авлагаас* үзнэ үү.)



2

# Сайн мэдээг заах ба судлах үндэс

Шашны семинар ба институтийн зорилго нь уг зорилгыг гүйцэлдүүлэхэд нь багш, удирдагч нарт туслах дараах гурван заах аргыг санал болгодог.

1. Бид суралцагсдад сайн мэдээний сургаал ба зарчмуудыг бошиглогчдын үгс болон судрууд дээр байгаагаар нь заадаг.
2. Энэхүү сургаал ба зарчмуудыг ойлгож, сэнхрэхэд нь чиглүүлэн заадаг.
3. Бид суралцагсдад суралцах явцдаа өөрсдийн үүргээ биелүүлэхэд нь тусалдаг ба тэднийг сайн мэдээг бусдад заахад бэлтгэдэг.

Эдгээр зорилтод хүрэхийн тулд семинар, институтийн багш суралцагсдыг сайн мэдээг заах ба судлах үндсийг амьдралдаа хэрэгжүүлэхийг дэмжих ёстой.

### Сайн мэдээг заах ба судлах үндэс

Багш, суралцагсад нь:

- Сүнсээр зааж, Сүнсээр суралцах ёстой.
- Хайр, хүндэтгэл болон зорилго агуулсан суралцах орчинг бүрдүүлэх хэрэгтэй.
- Судраас өдөр бүр суралцаж, хичээлийн материалыг унших ёстой.
- Судруудын болон бошиглогчдын үгсийн түүх, агуулгыг ойлгох ёстой.
- Сайн мэдээний сургаал ба зарчмуудын үнэн болоод чухал ач холбогдлыг ойлгож, танин мэдэрч, амьдралдаа хэрэгжүүлэх ёстой.
- Сайн мэдээний сургаал ба зарчмыг тайлбарлах, хуваалцах мөн гэрчлэх хэрэгтэй.
- Төгс эзэмших судрын хэсгүүд болон үндсэн сургаалуудыг төгс эзэмших хэрэгтэй.

Эдгээр зарчим, дадлага ба үр дүнгүүд нь хоорондоо холбогддог. Эдгээрийг ухаалгаар нэг нэгэнтэй нь уялдуулан хэрэгжүүлэхэд, суралцагсдын судруудыг болон судруудад агуулагддаг зарчим, сургаалуудыг ойлгох чадварыг нэмэгдүүлдэг. Эдгээр нь суралцагсдыг сайн мэдээг судлахад урамшуулж, тэдний сайн мэдээний дагуу амьдрах мөн үүнийг бусдад заах чадварыг нэмэгдүүлдэг.

## Сүнсээр зааж, суралцах нь [2.1]

Сайн мэдээг заах ба судлах нь Ариун Сүнсний хүчээр хийгддэг. Ариун Сүнс үүргээ гүйцэтгэж байхад буюу Сүнс багштай, суралцагчтай эсвэл хоёулантай нь байх үед Сүнсээр зааж мөн сурч байна гэж ойлгож болох юм. Зөвхөн Сүнсээр зааж, суралцах үед л суралцагсад Есүс Христийн



Цагаатгалыг мөнхийн амьдралд орж тэнцэхүйцээр ойлгож мөн үүнд найдах болно.

Сүнсээр судлахад Ариун Сүнс маш чухал үүрэгтэй гэдгийг Ерөнхийлөгч Хенри Б.Айринг ийн онцлон хэлсэн байдаг: "Суралцагсад маань Ариун Сүнсээр заалгахгүй аваас Бурханыг танин мэдэж, Түүнийг хэрхэн хайрлах ёстойгоо мэдэрч чадахгүй. Сүнсээр л тэд Бурхан бидэнд маш их хайртай учраас Өөрийн Хүүг бидний гэм нүглийн зуучлагч болгон илгээсэн бөгөөд Бурханы Хүү Есүс тэрхүү Христ бидний нүглийн төлөөсийг төлсөн гэдгийг мэдэж чадна. Тэнгэрлэг Эцэг ба Түүний дахин амилж, алдаршсан Хүү Иосеф Смитэд үзэгдсэн гэдгийг тэд зөвхөн Сүнсээр л мэдэж чадна. Мормоны Ном Бурханы үнэн үг гэдгийг тэд гагцхүү Сүнсээр мэдэж авна. Эцэг ба Хүү тэдэнд хайртай учраас мөнхийн амьдралыг хүлээн авахад хэрэгтэй ёслолуудыг бидэнд өгсөн болохыг тэд зөвхөн Сүнсний өдөөлтөөр мэдрэх болно. Тэд эдгээр гэрчлэлийг хүлээн авч, Ариун Сүнсээр зүрх сэтгэлийнхээ гүнд суулгах аваас амьдралд тохиох аливаа уруу таталт, бэрхшээл сорилтуудыг зоригтойгоор давах үндэс нь болно" ("To Know and to Love God" Ерөнхийлөгч Хенри Б.Айрингтай хийсэн уулзалт 2010 оны 2-р сарын 26, 2).

Сайн мэдээг заах ба судлахад гүйцэтгэх Ариун Сүнсний зарим үүргийг доор жагсаав:

- Тэрээр Бурхан Эцэг мөн Түүний Хүү Есүс Христийг гэрчилдэг (1 Коринт 12:3; Ифер 12:41-г үзнэ үү).
- Тэрээр багш, суралцагч хоёуланг нь сэнхрүүлдэг (өргөн дэмждэг буюу сүнсээр хүчирхэгжүүлдэг) (1 Коринт 14:12; С ба Г 50:22–23; 84:106-г үзнэ үү).
- Тэрээр "Сүнсний үр жимс" болох баяр баясгалан, хайр, амар амгалан, тэвчээр ба дөлгөөн занг өгдөг (Галат 5:22–23; Ром 15:13; С ба Г 6:23; 11:12–13-г үзнэ үү).
- Тэрээр хүмүүнд ярих эрх мэдэл, итгэлтэй байдлыг өгдөг (1 Нифай 10:22; Алма 18:35; Моронай 8:16-г үзнэ үү).
- Тэр сайн мэдээний сургаал ба зарчмуудын үнэнийг гэрчилдэг (Иохан 15:26; С ба Г 21:9; 100:8-г үзнэ үү).
- Тэр үнэн, мэдлэг, ойлголт болон гэгээрлийг хайрладаг (Иохан 16:13; 1 Коринт 2:9–11, 14; С ба Г 6:14; 11:13–14; 76:5–10, 116-г үзнэ үү).
- Тэрээр багш, суралцагсдад санаа, ойлголт ба зарчмуудыг эргэн санахад нь тусалдаг (Иохан 14:26-г үзнэ үү).
- Тэр хүмүүнд юу хэлэх, юу хэлэхгүйг нь мэдүүлдэг (Лук 12:11–12; 2 Нифай 32:7; С ба Г 84:85; 100:5–6-г үзнэ үү).
- Тэрээр хүмүүсийн зүрх сэтгэлд үнэнийг хүргэдэг (2 Нифай 33:1-г үзнэ үү).
- Тэрээр хүмүүсийн зүрх сэтгэлийг зөөлрүүлдэг (1 Нифай 2:16; Алма 24:8-г үзнэ үү).
- Тэр тайтгарлыг өгдөг (Иохан 14:26; С ба Г 88:3-г үзнэ үү).
- Тэрээр зүрх сэтгэлийг ариусгаж, өөрчилдөг (Мозая 5:2; 3 Нифай 27:20; Моронай 6:4-г үзнэ үү).

*Тэмдэглэл*

Нэгэнт тэд сүнслэгээр суралцахад Ариун Сүнсний гүйцэтгэдэг чухал үүргийг ойлгосон тохиолдолд эдгээр үүргийг бүрэн гүйцэлдүүлэхийн тулд багш нар Сүнсийг урих бүхнийг хийх шаардлагатай. Үүнийг хийхийн тулд багш нар хувийн зохистой байдлын төлөө чармайх ёстой. Тэд "итгэлийн залбирлыг" хийж (С ба Г 42:14) мөн хичээл бүрт бүрэн бэлтгэлтэй байхыг хичээх шаардлагатай. Тэд суралцагсдынхаа суралцах үйл явцад анхаарч, аливаа бусад зүйлд санаа зовохгүй, зүрх сэтгэлдээ тайван байхыг эрэлхийлнэ. Тэд даруухан, хайгч сүнсийг илэрхийлэх ёстой. Тэд мөн өөрсдийн суралцагсдыг суралцах явцдаа Ариун Сүнсийг урихыг урамшуулан дэмжих хэрэгтэй.

Дараах зүйлсийг хийснээр багш, суралцагсад Ариун Сүнсийг мэдрэх уур амьсгалыг бүрдүүлж чадна:

- Үр дүн бүхий сүнслэг хэсгийг явуулах.
- Судар болон бошиглогчдын үгсээс уншиж, заах.
- Аврагчийн жишээнд төвлөрч мөн Түүний тухай ярилцаж, гэрчлэлээ хуваалцах.
- Сайн мэдээний сургаал ба зарчмуудыг энгийн, тодорхой арга замаар заах.
- Илэрхийлэлт хүлээж авахуйц чимээгүй агшинд тунгаан бодох цаг гаргах.
- Тохирох зохистой туршлагуудаасаа хуваалцаж, сургаал ба зарчмуудыг гэрчлэх.
- Сүнслэг дуу хөгжим ашиглах.
- Нэг нэгэндээ болон Их Эзэнд хайр, талархлаа илэрхийлэх.

Багш нар дараах асуултуудыг өөрсдөөсөө асууснаар ангид нь Сүнслэг мэдрэмж байгаа эсэхийг мэдэх боломжтой:

- Аврагчийг, сайн мэдээг мөн судруудаа хайрлах суралцагсдын хайр нь нэмэгдэж байна уу?
- Заасан зарчмуудыг суралцагсад сайн ойлгосон уу?
- Суралцагсад сэнхэрч суралцсан зарчмуудынхаа дагуу үйлдэхээр сүнслэгээр өдөөгдөж байна уу?
- Ангийн нэгдмэл байдал өсч байна уу?
- Гэрчлэлээ хуваалцаж мөн гэрчлэлээ өсгөж байна уу?
- Суралцагсад хичээлээ сонирхож мөн идэвхтэй оролцож байна уу?
- Ангид "хайр, баяр баясгалан, амар тайван, тэвчээр, энэрэл, сайхан сэтгэл, итгэлтэй байдал" (Галат 5:22) мэдрэгдэж байна уу?

**"Их Эзэний сүнсийг ангидаа байлгахыг хүсвэл яарч сандрахгүй байх нь нэн чухал юм."**



**Жеффри Р.Холланд, "Teaching and Learning in the Church" дэлхий даяарх удирдагчдын сургалт уулзалт, 2007 оны 2-р сарын 10, *Ensign*, 2007 оны 6-р сар, 91)**

Багш хэчнээн авьяастай, итгэлтэй байлаа ч Сүнсний үүргийг гүйцэтгэж чадахгүй гэдгийг санах нь чухал юм. Багш нар заримдаа сүнслэг байдал бий болгохыг хичээж болно. "Та сүнслэг зүйлсийг хүчээр бий болгож чадахгүй. . . . Та нар шош соёолохыг эсвэл өндөг хагарахыг цагаас нь өмнө хүчилж чадахгүйтэй адил Сүнсийг хүчлэн мэдэрч чадахгүй. Та ургах нөхцлийг бүрдүүлж, бордож мөн хамгаалж арчилж чадах боловч боловсрохыг нь хүлээх хэрэгтэй болдог" хэмээн Ахлагч Боид К.Пакер заасан ("Candle of the Lord," *Ensign,* 1983 оны 1-р сар, 53).

Тэмдэглэл

Сүнсээр заахыг хичээж буй багш нар өөрсдийн оюун ухаан, багшлах туршлага эсвэл хувийн шинж чанаруудаа бус харин Ариун Сүнсний нөлөөнд найдах ёстой (2 Нифай 4:34). Тэд Сүнслэг байдлаа харуулахын тулд аливаа сэтгэлийн хөдөлгөөн илэрхийлэх эсвэл хүчээр нулимс дусаахыг хичээх ёсгүй. Ерөнхийлөгч Ховард В.Хантер анхааруулан хэлэхдээ: “Бид багшийн хувьд өдөр бүр ангид заахдаа болгоомжтой байхгүй аваас Их Эзэний Сүнсний жинхэнэ нөлөөг зохисгүй, хуурамч байдлаар дуурайхыг хичээж эхэлдэг. Хүчтэй сэтгэлийн хөдөлгөөн эсвэл замбараагүй урсах нулимс нь Сүнслэг байдлын илэрхийлэл хэмээн хүмүүс андуурах вий хэмээн би эмээдэг. Мэдээж хэрэг Их Эзэний Сүнс хүчтэй сэтгэлийн хөдлөл үүний дотор нулимсыг авчирдаг. Гэвч үзэгдэх сүртэй байдлыг Сүнслэг байдалтай андуурч болохгүй” (“Eternal Investments” Ерөнхийлөгч Ховард В.Хантертай хийсэн уулзалт 1989 оны 2-р сарын 10, 4) гэж хэлжээ.

Багш нар “Сүнс надад . . . ийн хэлсэн” эсвэл “Сүнс намайг ингэ гэсэн” хэмээн ярихдаа болгоомжтой байх хэрэгтэй. . . . Санаатай эсвэл санаандгүй ч бай иймэрхүү өгүүлбэр нь өөрийгөө дөвийлгөж, сүнслэг байдлаа дэндүү товойлгон, тэднийг хүчилж байгаа мэт бусдад санагддаг. Ер нь бол багш нар Сүнслэгээр өдөөгдөн үйлдэж байгаагаа зарлах шаардлагагүй.

Ахлагч Хенри Б.Айринг дараах зөвлөгөөг санал болгосон юм: “Сүнслэг туршлагуудыг суралцагсдад өгөх нь үүний тухай ярихаас хамаагүй чухал юм. Хүн бүр Сүнсийг бага зэрэг өөр өөрөөр мэдэрдэг гэдгийг санаарай. . . . Энэ нь маш хувийн шинж чанартай зүйл гэж боддог тул би энэ талаар дэлгэрэнгүй ярихаас болгоомжилдог. Сүнслэг байдлыг зүгээр л мэдрэх нь чухал юм. “Та Сүнсийг мэдэрч байна уу?” хэмээн дахин дахин асуух нь сөрөг нөлөөтэй байж болно (“Ахлагч Ричард Г.Скотт, Ахлагч Хенри Б.Айринг Discussion” СБС-ийн сургалтын шууд дамжуулах нэвтрүүлэг, 2003 оны 8-р сар, 8).

Сүнслэгээр заах нь хичээнгүйгээр хичээлдээ бэлтгэх болон сургалтын хөтөлбөрийг ашиглах үүргээс чөлөөлдөггүй гэдгийг багш нар санах хэрэгтэй. Гэхдээ сургалтын төлөвлөгөөг залбирч, бодохгүйгээр эсвэл хянаж үзэхгүйгээр зүгээр л дагаж болохгүй. Сүнсээр заах нь үүнээс хавьгүй илүүг шаарддаг. Багш нар хичээлийн явцад хүлээн авах Сүнсний өдөөлтийг дагахын оронд хичээлийн төлөвлөгөөнд дэндүү баригдах ёсгүй.

## Хайр, хүндэтгэл болон зорилго агуулсан суралцах орчинг бүрдүүлэх [2.2]

Багш, суралцагсад Их Эзэнийг, бие биенээ бас Бурханы үгийг хайрлаж, хүндэлснээр амжилттай суралцах болно. Нэгдмэл зорилго нь хүч чармайлт, итгэл найдвар дээр төвлөрдөг бөгөөд ангийн суралцах үйл явцад удирдамж өгдөг. Хайр, хүндлэлтэй, зорилготой орчныг үүсгэх нь багш суралцагсдын хоёулангийнх нь үүрэг юм. Ийм орчин нь Ариун Сүнсний сэнхрүүлэх нөлөөг урьдаг.

### Хайр ба хүндлэл [2.2.1]

Хайр нь зүрх сэтгэлийг зөөлрүүлж, Ариун Сүнсний нөлөөг урьдаг билээ. Багш нар бусдыг Аврагчийн адил хайрлавал тэднийг Түүний нүдээр хардаг. Христтэй адил хайрлах хайр нь залуу эмэгтэй, залуу эрэгтэй бүрийг жинхэнэ ёсоор хөрвөхөд туслах ажилдаа багш хэзээ ч шантрахгүй байхаар урамшуулдаг. “Бид заахаар дуудагдахдаа Мөнхийн Эцэг Бурхан ба

*Тэмдэглэл*

Түүний Хүү Есүс Христийг хайрлах хайрынхаа улмаас дуудлагаа хүлээн авч, заадаг. Сайн мэдээний багш нар суралцагсдаа хайрлах хайраар дүүрэн заах ёстой. . . . Бурхан болон Түүний хүүхдүүдийг хайрлах хайр нь бидний үйлчлэлийн хамгийн агуу шалтгаан болдог. Хайраар заадаг тэдгээр нь өөрсдийн үйлчилдэг Бурханы зэмсэг болохоор өсч хөгждөг юм (“Сайн мэдээг заах нь” *Ensign*,1999 оны 11-р сар, 79).



Их Эзэнийг хайрладаг мөн өөрсдийг нь хайрлах Түүний хайрыг мэддэг багш, суралцагсад нь Түүнтэй ойр байж, Түүнтэй адил болохыг чин сэтгэлээсээ хүсдэг. Тэд Түүний үгс болон бошиглогчдын үгсийг хүндлэн биширдэг бөгөөд энэ нь тэднийг судраас эрчимтэйгээр судалж, сурсан зүйлсээ хэрэгжүүлж, үүнийгээ бусадтай хуваалцахад өдөөдөг.

Багш болон бусад суралцагсад нь өөрийг нь хайрлаж, хүндэлж байгааг мэдсэнээр тэд ангидаа илүү идэвхтэйгээр ирдэг. Бусдын хайр, нөхөрлөл тэдний зүрх сэтгэлийг зөөлрүүлж, айдсыг нь арилгаж, багш болон ангийн гишүүдтэйгээ туршлага, бодлоо хуваалцах хүсэл ба итгэлийг өгдөг.

Багш нар суралцагсдад Цагаатгалыг ойлгоход нь тусалж, Тэнгэрлэг Эцэг болон Түүний Хүүд тэд хэчнээн үнэ цэнэтэй бас тэд ямар тэнгэрлэг чанартай болохыг нь зааж, Их Эзэнийг хайрлах хайр болон хүндлэлийг нь өсгөж чадна. Багш нар Тэдний тухай заах буюу гэрчлэхдээ зөв зохистой, хүндлэл бишрэлтэй байх ёстой.

Багш нар суралцагсдаа хайрлаж, хүндэлж байх ёстой. Ингэснээр тэд Христийн цэвэр хайраар суралцагсдаа хайрлаж, тэдэнд тэвчээр, сайхан сэтгэлээр заах болно. Багш нар суралцагсдынхаа нэрсийг тогтоож, тэдний сонирхол, авьяас чадвар, тэдэнд тулгарсан сорилтуудыг нь мэддэг байх хэрэгтэй. Тэд нэг суралцагчийн төлөө эсвэл нийт суралцагсдынхаа төлөө залбирч болно. Багш нар суралцагч бүрийг ангидаа ирэхэд нь биечлэн угтаж мөн суралцагч бүрт хичээлд оролцох боломжийг өгдөг. Суралцагсад асуулт асууж, санал сэтгэгдлээ хуваалцахад багш нар анхааралтай сонсох хэрэгтэй. Багш нар суралцагсдынхаа оролцож буй спортын уралдаан тэмцээн, үйл ажиллагаанд очиж болно. Багш нар суралцагсдынхаа эцэг эх, санваарын удирдагчдыг орлох буюу тэдний хувийн зөвлөгч болохыг хичээх ёсгүй.

**“Хэрэв би хүмүүсийн болон тэнгэр элчийн хэлээр ярьсан ч надад хайр байхгүй бол би нүргэлэх харанга, хангинах цан болох байсан.**

**“Хэрэв би эш үзүүлэх чадвартай, мөн бүх нууцууд болон бүх мэдлэгийг мэддэг байгаад, уулыг нүүлгэх бүрэн итгэлтэй байлаа ч, надад хайр байхгүй бол би юу ч биш.”**

**(1 Коринт 13:1–2)**



Ихэнх багш нарын ангид биеийн болоод оюун ухааны хөгжил султай суралцагсад байдаг. Тэд ч бас Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүд бөгөөд сайн мэдээг суралцах шаардлагатай байдаг. Үүнд тэдний хувийн хүндрэл бэрхшээл, бие махбодын байдал нөлөөлөх ёсгүй. “Бурханы дэлхийд илгээсэн бүх оюун ухаан, сүнснүүд нь өсч хөгжих чадвартай” хэмээн Бошиглогч Иосеф Смит заасан байдаг (*Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* 2007, 210). Багш нар хичээлд бэлтгэх буюу хичээлээ заахдаа бүх суралцагсдынхаа хувийн хэрэгцээ шаардлага, чадварыг харгалзан үзэх хэрэгтэй.

Тэмдэглэл

Багш нар суралцагсдаа чин сэтгэлээсээ хайрлах хайрыг хөгжүүлэх шилдэг аргын нэг бол зүрх сэтгэлийн залбирлаар дамжуулан энэрлийн бэлгийг эрэлхийлэх явдал юм. Мормон "та нар түүний Хүү, Есүс Христийн үнэн дагалдагчид бүгдийн дээр түүний цутгасан хайраар дүүргэгдэж болохын төлөө зүрхнийхээ бүхий л эрч хүчээр Эцэгт хандан залбирагтун" хэмээн бидэнд заасан (Моронай 7:48).

## Зорилготой байх нь [2.2.2]

Багш, суралцагсдын нэгдмэл зорилго нь итгэлийг нь нэмж, удирдамж өгч мөн ангидаа сурсан зүйлсийг нь илүү ач холбогдолтой болгодог. Суралцагсад ангид Тэнгэрлэг Эцэг ба Түүний Хүү Есүс Христийн тухай мэдэхээр мөн судар болон бошиглогчдын үгсээс судлан, мөнхийн амьдралын төлөө өсч хөгжихөөр ирдэг гэдгээ ойлгох хэрэгтэй. Их Эзэн рүү залбирал болон суралцах хүсэл эрмэлзэлтэйгээр ирснээр Ариун Сүнсээр заалгаж чадна гэдэгт тэд итгэж найдах ёстой. Багш суралцагсад Сүнс болон нэг нэгнээсээ суралцах найдлагатайгаар судраас суралцах аваас илчлэлт хүлээн авах таатай орчныг бүрдүүлдэг.

Багш нар ангийг зорилготой болгохын тулд дараах зүйлсийг хийж болно:

- *Суралцагсдыг өөрсдийн үүргийг биелүүлэхийг хүс.* Суралцагсдаа өөрсдийн үүргийг биелүүлэх боломжийг олгодог, үүнд нь тусалдаг мөн тэдэнд зарим зүйлийг даалган, итгэдэг багшийн ангид зорилго оршдог. Зорилготой мөн суралцагсдаа чин сэтгэлээсээ хайрладаг багш нар тэдний өсөлт хөгжилтөд маш их санаа тавьдаг бөгөөд өчүүхэн хичээл зүтгэлд нь ч сэтгэл хангалуун байдаг. Ийм багш нар нь суралцагсдаа хайраар урамшуулж, суралцагч буюу Есүс Христийн шавь болоход нь дэмжих болно.
- *Судар болон сайн мэдээнд чин үнэнч, хүсэл эрмэлзэлтэй, эрч хүчтэй бай.* Ярьж хэлэлцсэн зүйлдээ багш нь итгэлтэй, хүсэл эрмэлзэлтэй байгааг мэдэрсэн суралцагсад зорилготойгоор суралцах илүү их хүсэлтэй болдог.
- *Хичээлээ судлан бэлтгэх.* Багш нар хичээлдээ ирэхдээ заах хичээлээ сайн бэлтгэж, өөртөө итгэлтэй ирэхэд суралцагсад тэдний зорилгыг шууд ойлгодог.
- *Хэрэгтэй сургалтын материал болон хэрэгслийг бэлтгэ.* Багш нар суралцагсдыг ирэхээс өмнө ангидаа ирж хичээлд шаардлагатай сургалтын материал, хэрэгслийг бэлтгэнэ. Ингэснээр тэд хичээлд ирсэн суралцагч бүртээ мэндлэх боломжтой болно. Суралцагсад хичээлдээ цагтаа ирж, судрууд, тэмдэглэх харандаа, тэмдэглэлийн дэвтэр зэрэг шаардлагатай бүх материалыг хичээл эхлэхэд ширээн дээр гарган тавьсан байна.
- *Цагаа дэмий үрэхээс зайлсхий.* Хичээл яг цагтаа эхэлж, дэмий үрэх цаг байхгүйг суралцагсад хараад зорилгоо ухаардаг.
- *Ангид тогтсон дэг журамтай бол.* Ангид дэг журам тогтоосноор ангийн тогтмол хийдэг үйл ажиллагаануудыг дэг журамтай, зорилготой болгодог. Ангид дэг журмыг тогтоосноор суралцагч бүрийн оролцоог дэмжиж, хичээлийн үнэ цэнэтэй цагийг багш, суралцагсад илүү үр дүнтэй ашиглахад тусалдаг. Судрууд болон сургалтын материалуудыг хураан, далд хийх, илэрхийлэлт бүхий сүнслэг хэсгийг явуулах, цаас болон сургалтын материалуудыг тараах, цуглуулахад тодорхой дэг журмыг тогтоож болно. Зарлал

Тэмдэглэл

хэлэх, суралцагсдын ирцийг бүртгэх, даалгавар шалгах зэрэг бусад ажлыг сүнслэг хэсэг ба хичээл эхлэхээс өмнө хийвэл сайн.

## Суралцах таатай орчинг бүрдүүлэх нэмэлт удирдамжууд [2.2.3]

Сайн мэдээг суралцах төгс орчныг бүрдүүлэхэд хайр, хүндэтгэл, зорилготой байхаас гадна бишрэлтэй, сахилга баттай, амар амгаланг мэдэрч байх хэрэгтэй. Ахлагч Боид К.Пакер заахдаа: “Сүнслэг өдөөлт нь амар амгалан орчинд илүү хурдан ирдэг бөгөөд бишрэл хүндэтгэлтэй байдал нь илчлэлтийг урьдаг юм” гэжээ (“Reverence Invites Revelation,” *Ensign,* 1991 оны 11-р сар, 21–22). Сайн мэдээг суралцах таатай уур амьсгалыг бүрдүүлэх зарим нэмэлт санаануудыг доор өгөв.

### *Ангийг тохижуулах*

Ангийн тохижилт нь суралцагсад сайн мэдээг судлахад нөлөөлдөг. Суралцагсдад тухтай байж, хичээлдээ анхаарах боломжийг олгох ангийг бэлтгэхийн тулд багш нар өөрсдийн чадах бүхнийг хийх ёстой. Зарим анхаарах зүйл:

**Суудал.** Маш ховор онцгой нөхцөл байдлаас бусад үед суралцагч бүрт суух сандал, сургалтын материал ба судраа тавьж, хичээлээ бичих ширээ байх шаардлагатай. Ширээ сандлыг байрлуулахдаа багш болон багшийн үзүүлэнгүүдийг харах боломжтой байдлаар байрлуулна. Боломжтой бол суралцах үйл ажиллагаануудад зориулан өөрөөр байрлуулж болно. Суралцагсдыг суудалд хувиарлан суулгах нь багш нарт тэдний нэрсийг хурдан тогтооход, ангийг бүлэг болгон хуваахад буюу судраас суралцах дасгал хийхэд мөн хичээлийн дундуур хоорондоо ярьдаг суралцагсдыг салган суулгахад тусалдаг. Багш нар хараа муутай, хөгжлийн бэрхшээлтэй суралцагсдын хичээлийн оролцоог дэмжихийн тулд ширээ сандлын байршлыг тохируулж, анхааралтай хандах ёстой.

**Анхаарал сарниулах зүйлс.** Багш нар заах ба суралцах үйл явцад саад болох аливаа зүйлсийг хязгаарлахыг хичээх ёстой. Айлд заадаг бол зарим нэг хүндрэлүүд байж болох ч сайтар төлөвлөх аваас саад болох зүйлсийг багасгах боломжтой байдаг.



**Ангийн тохижилт.** Сайн мэдээтэй холбоотой зураг, чимэглэл, зурагт хуудас, үзүүлэн зэрэг нь суралцах орчинг сайжруулдаг. Цэвэр, сайхан, эмх цэгцтэй анги нь хүндэтгэл бишрэлийг дэмжиж, Сүнсний нөлөөг ихэсгэх орчинг бүрдүүлдэг юм.

**Багшийн гадаад байдал.** Багш даруухан, зохистойгоор, сайн мэдээний захиасын нандин чанарыг харуулан хувцаславал суралцагсад судлах хичээлийнхээ үнэ цэнийг илүү ойлгодог.

### *Үр дүнтэй сүнслэг хэсгийг явуулж Сүнсийг урь*

Хичээлийг богино хугацааны сүнслэг хэсгээр эхлэх хэрэгтэй. Сүнслэг хэсэг нь суралцагсдын бодол санаа, зүрх сэтгэлийг сүнслэг зүйлс рүү хандуулж, тэднийг нэгдмэл байлгах үр дүнтэй арга юм. Энэ нь багш, суралцагсдыг Сүнсийг мэдэрч мөн судлахад бэлтгэхэд тусалж чадна. Сүнслэг хэсэгт сүмийн дуулал, залбирал болон судруудаас

Тэмдэглэл

хуваалцах зэрэг орно. Суралцагсад өөрт тохиолдсон зүйлс болон гэрчлэлээ хуваалцвал сүнслэг хэсэг илүү үр дүнтэй болдог. Сүнслэг хэсэгт дэндүү их цаг зарах нь хичээлийн цагийг багасгаад зогсохгүй Сүнсийг ч үргээж болох юм. Сүнслэг хэсгийн үеэр хөнгөн зууш өгөх нь сүнслэг байдлыг бууруулна. Багш нар суралцагсадтай ялангуяа ангийн удирдагч нартай цаг гарган, сүнслэг хэсгийн зорилгыг ярилцаж, яавал илүү сайн хийж болох мөн хүн бүрийн оролцоог хэрхэн дэмжих талаар ярилцах ёстой.

### *Сүнслэгээр судлах үйл явцын зарчмуудыг ярилц*

Хичээлийн жилийн эхэнд багш нар ямар нөхцлүүд сүнслэгээр судлахад нөлөөлдөг болохыг ярилцахдаа суралцагсдыг оролцуулж болно (1 Коринт 2:10–11; С ба Г 50:17–22; 88:121–126-г үзнэ үү). Эдгээр ярилцлага нь сайн мэдээг суралцахад Их Эзэний Сүнсийг урих зан чанарууд мөн Сүнсийг үргээдэг зан чанаруудын талаар байж болно. Багш, суралцагсад санал нийлсэн зүйлсээ тогтмол хэрэгжүүлэхэд бие биенээ урамшуулан дэмжих хэрэгтэй ба энэ нь Сүнсийг урих болно. Эдгээр хүчин чармайлт нь багш, суралцагсдад суралцах явцдаа Сүнсийг урих үүргээ ойлгон, биелүүлэхэд тусалдаг.

### *Суралцах үйл ажиллагаануудыг анхааралтайгаар сонго*

Суралцах ялгаатай үйл ажиллагаанууд нь суралцагсдын байдал ба хандлагыг өөрчилдөг гэдгийг багш нар мэддэг байх ёстой. Жишээлбэл нэгэн багш хичээлийнхээ эхэнд хөдөлгөөнт тоглоом тоглуулаад эцэст нь хичээлээ сүнслэг байдлаар төгсгөж чадаагүй учраас бухимдсан байна. Өөр нэгэн багш хичээлийнхээ дундуур суралцагсдад зууш өгснөөс болж анги нь эмх замбараагүй байдал үүсчээ.

### *Суралцагсдынхаа зан байдалд анхааралтай хандаж, тэдэнд зохих ёсоор ханд*

Багш нар хичээлийн дундуур юу болж байгааг анзаарч, асуудлыг зөв зохистойгоор шийдвэрлэх хэрэгтэй. Суралцагсад уйдаж залхсан мэт санагдвал энэ нь тэд хичээлд идэвхтэй оролцоогүй эсвэл заалгасан зүйл нь тэдэнд ямар хамаатай болохыг сайн ойлгоогүйгээс болсон байж магадгүй юм. Суралцагсдыг анхааралтай байхад нь туслахын тулд багш нар хичээлээ арай өөр аргаар зааж болно. Хэрэв суралцагсад зүй бус авирлаж, Сүнсийг ангиас үргээж байвал багш нар үүнийг тоохгүй өнгөрөөж болохгүй. Харин асуудлыг шийдвэрлэхийн тулд сүнслэг өдөөлтийг эрэлхийлэх хэрэгтэй. Багш нар бусадтайгаа харилцдаггүй, ганцаардсан суралцагсдад анхаарал хандуулах шаардлагатай. Эдгээр суралцагсдад багшийн эсвэл ангийн бусад суралцагсдын анхаарал халамж хэрэгтэй байж болно. Иймэрхүү тохиолдолд багш нар тэдний эцэг эх, санваарын удирдагчидтай ярилцаж, ямар нэг учир шалтгаан эсвэл өвчин зовлон байгаа эсэхийг нь тогтооно.

### *Эмх замбараагүй буюу зүй бус зан авирыг засч залруулах*

Багш нар зарим нэг зарчмуудыг санаж байснаар ангидаа дэг журам ба хүндэтгэлтэй байдлыг урихад тусалдаг. Дэг журамтай байна гэдэг нь таг чимээгүй байх эсвэл ангид зугаатай хөгжилтэй байж болохгүй гэсэн үг биш. Гэхдээ дэг журамгүй, хүндэтгэлгүй нэг буюу хэсэг

*Тэмдэглэл*

суралцагсад нь суралцах явцад сөргөөр нөлөөлж, Ариун Сүнсний нөлөөнд саад учруулах болно.

Ангийн нэг эсвэл хэсэг суралцагч сахилгагүйтэхэд багш болон бусад суралцагсдад хэцүү байдаг. Ийм үед багш нар сэтгэлийн хөдөлгөөнөө хянаж, Сүнсний нөлөөг эрэлхийлэх нь маш чухал юм. Аливаа нөхцөл байдалд багш хэрхэн хариулах нь маш чухал бөгөөд энэ нь суралцагсдын итгэл, хүндэтгэлийг өсгөж эсвэл бууруулж болно. Багш нар зүй бус зан авирыг хатуу чандаар гэхдээ нөхөрсөг, шударгаар засч залруулаад хичээл рүүгээ анхаарлаа хандуулна. Суралцагчийг бусдын өмнө эвгүй байдалд оруулах нь уг суралцагчийн зан авирыг түр зуур засч болох ч энэ нь багш болон суралцагчийг цааш хөгжихөд тус болохгүй. Энэ нь бусад суралцагсад багшаас эмээж эсвэл үл итгэн хөндийрөх шалтгаан болж болно. Сэнхрүүлэл, тэвчээр, элдэг зөөлөн, номхон дөлгөөн, чин сэтгэлийн хайрын зөв шударга нөлөөг санаж байх ёстой (С ба Г 121:41–42-г үзнэ үү).

**"Шийдэх ёстой асуудлаа хайрлах ёстой хүнээсээ хэзээ ч дээгүүр бүү тавь."**



**Томас С.Монсон, "Finding Joy in the Journey,"** ***Ensign*****,** ***Лиахона*****, 2008 оны 11-р сар 86)**

Асуудал тулгарахад шийдвэрлэх хэд хэдэн тодорхой шат дараалал байдаг. Сахилгын асуудлуудад хандах эдгээр аргуудыг суралцагч бүрт эсвэл нөхцөл байдал бүрт хэрэглэхэд тохирохгүй байж болно.

- *Нүд рүү нь эгцлэн хар.* Ихэнх тохиолдолд суралцагсад багшийгаа сонсохгүй гэж бодоод нэг нэгэнтэйгээ хичээлийн бус сэдвээр ярьдаг. Энэ үед багш нар тэдгээр суралцагсдын нүд рүү харж, сонсож байгаагаа мэдэгдэх хэрэгтэй.
- *Ярихаа зогсоо.* Суралцагсад багшийг ярьж байхад хоорондоо ярих хэрэгтэй бол өгүүлбэрийн дундуур ч гэсэн яриагаа тасал. Тэднээс давж ярьснаар асуудлыг шийдвэрлэхгүй.
- *Ойртож оч.* Өөр нэг хийж болох зүйл бол дүрсгүйтэж байгаа суралцагчийн хажууд очин зогсох юм. Багш хажууд нь зогсоод хичээлээ үргэлжлүүлэн заахад дүрсгүйтсэн суралцагч хийж байсан зүйлээ зогсоох болно.
- *Асуулт асуу.* Дүрсгүйтэж байгааг нь дурдалгүйгээр харин хичээлтэй холбогдолтой асуулт асууж болно. Энэ нь түүнийг ичээх гэсэнд бус харин түүнийг хичээлдээ эргээд анхаарлаа хандуулахад туслах болно.

Зарим үед эдгээрийг хийсэн ч суралцагсад үргэлжлүүлэн үймүүлсээр байдаг. Багш нар дэг журмыг тогтоох нэмэлт аргуудад дараах зүйлс орж болно:

- *Суралцагчтай биечлэн уулзаж ярилц.* Хэрэв хүн нэгнийгээ гомдоовол, гомдсон нэг нь "түүнтэй ганцаарчлан уулзах ёстой" хэмээн Их Эзэн айлдсан (С ба Г 42:88). Багш нь уг суралцагчтай уулзаж сахилгүйтэж байгаа учрыг нь лавлаж, түүнд зан авираа засах хэрэгтэйг мөн үгүй бол шаардагдах арга хэмжээ авна гэдгийг хэлж болно. Багш нар суралцагсдын ялгаатай байдал нь хувийн үнэ цэнэ, зохистой байдлаас шалтгаалдаг гэдгийг ойлгох ёстой. Багш нар "бодгалийн үнэ цэнэ Бурханы мэлмийд агуу гэдгийг" (С ба Г 18:10) санаж байх нь чухал юм. Буруу зан авирыг хүлээн зөвшөөрч болохгүй ч багш нар тухайн суралцагч үнэ цэнэтэй гэдгийг санаж тэдэнтэй харилцах хэрэгтэй. "Та нар шүүмжилсэн түүнийг хайрлах хайраа дараа нь нэмэгдүүлснээ харуул"

Тэмдэглэл

хэмээсэн Бурханы зөвлөгөөг дагах ёстойг багш нар санаж байх хэрэгтэй (С ба Г 121:43).

- *Сахилгүйтэж байгаа суралцагсдыг тусгаарлах.*
- *Тэдний эцэг эхтэй эсвэл санваарын удирдагчидтай зөвлөх.* Хэрэв тэд үргэлжлүүлэн буруу авир гаргаж байвал эцэг эхтэй нь зөвлөх нь зүйтэй. Эцэг эхчүүд тэднийг засч залруулахад тустай санааг өгдөг. Зарим тохиолдолд тухайн суралцагчийн бишоп нь тусалж болох юм.
- *Суралцагчийг ангиас гарга.* Ерөнхийлөгч Дэвид О.МкКей багш нарт хандан дараах зөвлөгөөг өгсөн: "Хичээл зүтгэл тань үр дүнгүй өнгөрвөл та эцэг эхчүүдэд нь "хэрэв танай хүүхэд үргэлжлүүлэн буруу зүйлс хийвэл бид түүнийг хасна" гэж хэлж болно. Энэ бол маш хатуу арга хэмжээ юм. Багш суралцагчийг хасахаасаа өмнө өөрийн чадах бүх зүйлсийг хийсэн байх ёстой. Гэхдээ бид дэг журамтай байх *ёстой*! Сүнс өсч хөгжих нь зайлшгүй хэрэгтэй бөгөөд хэрэв нэг, хоёр суралцагч үүнийг эсэргүүцэж байвал тэд тэнд байх шаардлагагүй. Бүх л ангиараа хордож байснаас нэг суралцагч өлссөн нь дээр" ("Guidance of a Human Soul—The Teacher's Greatest Responsibility," *Instructor,* Sept. 1965, 343).

Багш суралцагчийг ямар нэг хугацаагаар чөлөөлөхдөө эцэг эх, семинар, институтийн зохицуулагч болон санваарын удирдагчидтай нь зөвлөх ёстой. Ийм нөхцөлд багш нь суралцагч болон тэдний эцэг эхэд семинарыг орхих шийдвэр нь зохисгүй зан авиртай байж болно гэсэн үг биш гэдгийг ойлгоход туслах нь чухал юм. Суралцагчийг биш харин дэг журамгүй байдлыг хүлээн зөвшөөрөх аргагүй юм. Хэрэв тухайн суралцагч зөвийг сонговол ангидаа буцаж ирж болно.



**"Хэрэв тэдгээр суралцагсад өөрчлөгдөхгүй бол та тэдэнд зааж чадахгүй. Гэвч та тэднийг хайрлаж чадна. Та өнөөдөр тэднийг хайрлаж байвал магадгүй маргааш тэдэнд зааж болох юм."**

**Жеффри Р.Холланд, "Teaching and Learning in the Church," 102)**

## Судраас өдөр бүр судалж, хичээлийн материалыг унших [2.3]

### Судраас өдөр бүр судал [2.3.1]

Хувиараа судраас өдөр бүр суралцах нь багш, суралцагсдад тогтмол сайн мэдээнээс сурч, гэрчлэлээ хөгжүүлж, Их Эзэний дуу хоолойг сонсох боломжийг олгодог. Сургаал ба Гэрээнд Их Эзэн "ариун судрууд нь та нарын зааврын тул надаас өгөгдсөн авай" хэмээн мэдэгдсэн байдаг (С ба Г 33:16). "Христийн үгнээс зооглон, мөн эцсээ хүртэл тэвчих аваас, . . . та нарт мөнх амьдрал байх болно" гэж бошиглогч Нифай заасан (2 Нифай 31:20) мөн "Христийн үгс та нарын хийвэл зохих бүх зүйлийг та нарт хэлэх болно" (2 Нифай 32:3).

Хожмын үеийн бошиглогчид өдөр бүр судраас суралцахын чухлыг онцолсон байдаг. Ерөнхийлөгч Харольд Б.Лий "бид өдөр бүр судраас суралцахгүй бол бидний гэрчлэл багасаж, сүнслэг байдал маань өсөхгүй" гэж бидэнд анхааруулсан (*Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Харольд Б.Лий* 2000, 66). Ахлагч Ховард В.Хантер мөн ийн заасан: "Өдөр бүр судраас суралцдаг хүн нэг өдөр их уншаад дараагийн өдрүүдэд уншихгүй явдаг хүмүүсээс илүү их зүйлийг бүтээдэг юм" ("Reading the Scriptures," *Ensign,* 1979 оны 11-р сар, 64).

*Тэмдэглэл*

Ахлагч Ричард Г.Скотт: "Залуу хүн бүрийн зүрх сэтгэл, оюун бодолд судруудыг хайрлах галыг асааж өгөөрэй. Өсвөр үеийнхний Их Эзэний үгсийг илүү ихээр мэдэж авах, Түүний заасан зүйлсийг ойлгож, хэрэгжүүлэн, бусадтай хуваалцах хүслийг өдөөх тэрхүү унтаршгүй галын дөлийг асаахад нь тэдэнд тусал. . . .

Юуны өмнө суралцагсадтайгаа Их Эзэний нандин үгсийн замаар алхам алхмаар урагшлаарай. Таныг судруудыг хайрлаж хүндэлж явдгийг мэдэхэд нь тэдэнд тусал.

Хоёрдугаарт хувиараа судруудаас уншиж, тунгаан бодож, залбиран судруудаас ундрах тэрхүү эрч хүч, амар амгаланг нээж олоход нь туслахыг" биднээс хүссэн байдаг ("Four Fundamentals for Those Who Teach and Inspire Youth" CES symposium on the Old Testament, 1987 оны 8-р сарын 14, 5).

**Суралцагсдаа хүчирхэгжүүлэхээсээ өмнө та өөрөө итгэл, хичээл зүтгэлээр сайн мэдээнээс мөн хаант улсын сургаалуудыг судлах нь нэн чухал юм.**



**Эзра Тафт Бенсон, "The Gospel Teacher and His Message" СБС-ийн ажилчдад хандан хэлсэн үгсээс 1976 оны 9-р сарын 17, 3)**

Багш суралцагсдаа судрыг хайрлаж, өдөр бүр судраас суралцдаг болгож сургахаас илүү үр нөлөөтэй, хүчтэй зүйл ховор юм. Энэ нь багш нар өөрсдөө өдөр бүр судраас судлан үлгэр жишээ үзүүлснээр эхэлдэг. Хувиараа үр дүнтэйгээр өдөр бүр судраас суралцсанаар багш нар амьдралд нь судар ямар их үнэ цэнэтэй суралцагсдад гэрчлэх боломжтой болдог. Ийм гэрчлэл нь суралцагсдыг бие даан судраас тогтмол суралцах шийдвэр гаргахад нь тусалж болох юм.

Багш нар бие даан судраас судлахын ач холбогдол буюу зарчмыг үргэлж зааж байх ёстой. Багш нар суралцагсдаа судраас бие даан суралцахыг нь дэмжихийн тулд өдөр бүр тусгайлан цаг зарцуулж болно. Тэд судраас бие даан хэрхэн сурч байгааг нь хянаж байхын тулд зохистой хяналтын систем ашиглаж болно. Түүнчлэн тэдэнд судраас бие даан судалсан зүйлсийнхээ талаар бусадтайгаа хуваалцах боломж олгох хэрэгтэй. Багш нар суралцагсдыг өдөр бүр судраас суралцахыг дэмжихдээ бие даан судраас суралцах чадваргүй суралцагсдыг эвгүй байдалд оруулж, урам зоригийг нь мохоохгүйн тулд болгоомжтой хандах хэрэгтэй.

**"Амьдралын үгсийг оюундаа ямагт нөөцөл."**

**(Сургаал ба Гэрээ 84:85)**



Хөгжлийн бэрхшээлтэй суралцагсдад дуу бичлэгээр, дохионы хэлээр эсвэл хараагүй хүмүүст зориулсан номыг ашиглан судраас суралцах боломжийг олгох ёстой. Уншиж чадвар султай суралцагсдад чангаар уншиж буй хэн нэгнийг дагаж унших нь тустай байдаг.

### *Судраас суралцах арга барил*

Суралцагсад бие даан судраас үр дүнтэй суралцахад нь туслахын тулд багш нар судраас суралцах арга барилыг хөгжүүлэхэд нь тусалж чадна. Доор дурдсан болон энэхүү гарын авлагад ороогүй арга барилууд ч суралцагсдыг Сүнсээр сурч, судруудыг ойлгоход мөн сайн мэдээг сурч, амьдралдаа хэрэгжүүлэхэд чиглүүлдэг.

**Судраас судлахад туслах материалуудыг ашигла.** Сүмээс судраас судлахад туслах маш олон материалыг бэлтгэсэн бөгөөд тэдгээрийг зарим хэлээр жишиг бүтээлд оруулсан. (Судруудын удирдамж бол бусад хэлнүүдэд зориулж бэлтгэн гаргасан судлахад туслах материал юм.) Эдгээр туслах материалуудад мөрийн тайлбар, хэсгийн гарчиг, сэдвийн индекс, Библийн толь бичиг болон газрын зургууд багтдаг. Эдгээр нь

Тэмдэглэл

багш, суралцагсад судраас суралцахдаа ашиглаж болох хамгийн чухал хэрэгсэл юм. Багш нар туслах материалуудыг ангид зөв ашигласнаар суралцагсдыг эдгээрийг мэддэг болоход нь тусалж чадна. Сүмээс интернет дээр бусад олон туслах материалуудыг тавьсан байдаг.

**Зурж мөн бичиж тэмдэглэх.** Багш суралцагсад сурсан зүйлээ санах үр дүнтэй аргуудын нэг нь судрын үгсийг тодотгож мөн бичиж тэмдэглэх юм. Тодотгож тэмдэглэх гэдэг нь ялгаж зааглах, тодорхойлох, анхаарал хандуулах гэсэн утгатай. Үүнийг судар дээр доогуур нь зурж, өнгөөр будаж эсвэл түлхүүр үгс буюу чухал үгсийн доогуур тэмдэглэж хийдэг. Бичиж тэмдэглэх гэдэг нь тайлбар нэмэх эсвэл сэтгэгдлээ бичихийг хэлнэ. Судар дээр бичиж тэмдэглэх жишээнд хувийн сэтгэгдэл, бошиглол, солбилцсон эшлэлүүд, үгийн утга санаа эсвэл тодорхой судрын эшлэлүүдийн талаарх ангийн гишүүдийн санал сэтгэгдэл зэргийг тэмдэглэн бичих зэрэг багтана.



Судрууд дээр зурж мөн бичиж тэмдэглэх нь багш суралцагсдад дараах аргуудаар тусалдаг:

- Чухал үг, хэллэг, санаа, үнэн зүйлс, хүмүүс болон үйл явдлыг судраас олж мөн санаж байхад хялбар дөхөмтэй болгодог.
- Судрын хэсгийн утгыг ойлгож, олж нээдэг.
- Өөрийн болон бусдаас ирсэн санаануудыг хадгалж үлдэх.
- Сайн мэдээг заахад бэлтгэх.

Багш нар суралцагсдад “та нар эдгээр шүлгийг хайж байх зуур би та нарыг энд өгүүлсэн түлхүүр зарчмуудыг тэмдэглэхийг хүсч байна” эсвэл “Энэ бол маш чухал солбилцсон эшлэл байна. Та нар судрынхаа хажуу талд үүнийг бичиж тэмдэглэж болох юм” гэх мэтээр судар дээрээ тэмдэглэхэд нь дэмжиж болно. Судрууд дээр тэмдэглэх энгийн аргуудыг жилийн турш зааж, үзүүлж, дадлага хийх нь тэмдэглэгээ хийх нарийн системийг заахаас илүү үр дүнтэй.

**Тунгаан бодох.** Тунгаан бодох гэдэг нь бясалгах буюу ямар нэгэн зүйлийн тухай нухацтайгаар бодохыг хэлдэг ба үүнийг ихэвчлэн залбиралтайгаар хийдэг. Суралцагсад бие даан судраас суралцахдаа тунгаан бодож судлах аваас Сүнс тэдэнд үнэнийг илчилж, Есүс Христтэй хэрхэн илүү адил болохыг мэдэхэд нь тусалдаг.

Нифайчуудад зааж дуусаад Аврагч тэдэнд “миний хэлсэн зүйлийг эргэцүүл” хэмээн хэлсэн (3 Нифай 17:3). Суралцагсдыг хичээлд сүнслэгээр идэвхтэй оролцож, сурч байгаа зүйлээ ойлгох ойлголтоо гүнзгийрүүлэн, амьдралдаа хэрэгжүүлэхэд дэмжих нэг арга бол тэдэнд сурсан зүйлээ тунгаан бясалгах цаг гаргах юм. Ийм үед багш нар суралцагсдыг Их Эзэнээс тусламж гуйхад дэмжих ёстой.



**"Суралцагсдаа илүү удаан, анхааралтайгаар, дотроо асуулт тавьж уншихыг хүс. Тэднийг судрын үг, чухал хэсэг бүрийг судалж, тунгаан бодоход нь тусал. Үнэт чулууг гэрэлд барин эргүүлж тойруулан шалгадаг хүн шиг судрын чухал хэсэг бүрийг нягтлан судалж байхыг тэдэнд заа. Зарим суралцагчийн хувьд өгөгдсөн өдөр өгөгдсөн цаг мөчид ийн шалгах нь талбайд нуусан эрдэнэсийг: агуу үнэт сувд буюу ямар ч зүйлээс үнэтэй сувдыг олохтой адил байж болох юм."**

**(Жеффри Р. Холланд "Students Need Teachers to Guide Them" СБС-ийн шууд дамжуулах нэвтрүүлэг 1992 оны 6-р сарын 20, 4)**

**Асуулт асуу.** Судраас судалж байхдаа асуулт асууж, хариулт эрэлхийлэх нь суралцагсдын хөгжүүлэх ёстой маш чухал чадвар юм. Асуулт асуусанаар суралцагсдыг судрын агуулга, нөхцөл байдлыг түүнчлэн сайн мэдээний чухал сургаал ба зарчмуудыг илүү сайн ойлгоход хөтлөн чиглүүлэх болно. Суралцагсад сурч байгаа зүйлийнхээ үнэн бөгөөд чухал гэдгийг мэдрүүлэх, сурсан зүйлээ хэрхэн хэрэгжүүлэх тухай асуултуудыг асууж суралцах болно.

**Хэцүү үг хэллэгийг тайлбарлах.** Толь бичиг, суралцагчийн гарын авлага, мөрийн тайлбар ба судраас судлах тусламж зэрэг нь суралцагсдад хэцүү үг хэллэгийг ойлгоход тусалдаг.

**Оюун ухаандаа төсөөлөх.** Суралцагч оюун бодолдоо судруудын үйл явдлыг дүрслэн харахыг төсөөлөх гэнэ. Жишээлбэл суралцагсад усан дээр Аврагч руу алхаж яваа Петрийг (Матай 14:28–29-г үзнэ үү) эсвэл Шадрах, Мешах, Абед-него нарыг галтай зуух руу хаясныг төсөөлөн харж болох юм (Даниел 3:19–25-г үзнэ үү ). Төсөөлөн бодох нь суралцагсдад судрын үйл явдлыг илүү бодит болгодог.

**Судруудыг харьцуулах.** Судруудыг харьцуулахдаа өөрийн амьдралыг судруудтай харьцуулдаг. Суралцагсад "Надад тохиолдсон ямар нөхцөл байдал судрын энэ хэсэгт өгүүлж буй нөхцөл байдалтай *адил төстэй* байна вэ?" эсвэл "Судалж байгаа судрын энэ баатартай би юугаараа *адил төстэй* вэ?" гэж өөрсдөөсөө асууж болно. Өөрсдийн туршлага ба судар дахь үйл явдлуудын ижил төстэй байдлыг хараад суралцагсад сайн мэдээний сургаал ба зарчмуудыг илүү сайн ойлгодог. Тэд ижил төстэй нөхцөл байдалд эдгээр зарчмыг хэрхэн хэрэгжүүлэх вэ гэдгийг харж чадна.

**Солбилцсон эшлэл.** Солбилцсон эшлэл гэдэг нь судалж буй судрын хэсэгт нэмэлт мэдээлэл болон ойлголтыг өгдөг судрын өөр нэгэн хэсэг юм. Солбилцсон эшлэл буюу "холбоос" гэдэг нь суралцагсдад судрын хэсэг, сургаал, зарчмыг ойлгоход туслах хоорондоо холбоотой судрын эшлэлүүд юм. Хэрэгтэй солбилцсон эшлэлүүдийг мөрийн тайлбар, багш ба суралцагчийн гарын авлагууд, ерөнхий чуулган дээр хэлсэн үгс зэргээс олох боломжтой. Багш, суралцагсад холбогдох солбилцсон эшлэлүүдийг өөрөө судлан олж болно.

**Харьцуулан жиших.** Судар, сургаал, зарчмуудын хэсгийг бусад зүйлтэй харьцуулан жишвэл илүү ойлгомжтой байдаг. Сургаал, хүмүүс, үйл явдлуудын тухай бичсэн ижил төстэй буюу ялгаатай зүйлс нь сайн мэдээний үнэнүүдэд илүү анхаарал төвлөрүүлэхэд хүргэдэг. Жишээлбэл Бенжамин хааны хаанчлалыг Ноа хааны хаанчлалтай харьцуулсанаар суралцагсад зөв шударга удирдагчийн адислалыг хорон санаат удирдагчийн сүйрэлтэй харьцуулан маш тодоор харах боломжтой болно. Иаков, Алма нарын амьдрал, заасан зүйлс, гэрчлэлийг Шерем ба Корихор нарын амьдрал, үзэл санаатай харьцуулах нь суралцагсдыг дэлхийн хуурамч үзэл санааг таньж, үүнтэй хэрхэн тэмцэх ёстойг ойлгоход нь тусалдаг. Амлагдсан нутаг руу аялсан Израилын хөвгүүд, Лихай болон түүний гэр бүлийнхэн, Жаредчуудын аяллуудыг харьцуулах нь амьдралын аянд хэрэгтэй зарчмуудыг багш суралцагсдад заадаг.

*Тэмдэглэл*

**Жагсаалт гарга.** Хоорондоо холбоотой бодол, санаа буюу зааврuudыг дэс дараалалд оруулан бичихийг жагсаалт гэнэ. Судруудаас жагсаалтыг хайх нь багш суралцагсдад чухал санаануудыг олж харахад тусалдаг. Арван зарлиг бол жагсаалтын нэг жишээ мөн (Египетээс гарсан нь 20-г үзнэ үү). Ерөөлүүд мөн жагсаалт байж болно (Матай 5:3–12; 3 Нифай 12:3–11 ). Сургаал ба Гэрээний 4-р бүлэгт Их Эзэнд үйлчлэхээр дуудагдсан тэдгээрийн зохистой байдлын талаар жагсаалт байдаг.

**Уялдаа холбоо, загвар, сэдвүүдийг эрж хай.** Суралцагсдыг судраас суралцаж байхдаа уялдаа холбоо, загвар, сэдвүүдийг хайж олохыг дэмж. Ахлагч Дэвид А.Беднар хэлэхдээ: "Илчлэлтүүдээс уялдаа холбоо, загвар, сэдвүүдийг *хайх нь* бидэнд сүнслэг мэдлэг олгож, үүнийг нэмэгдүүлдэг. Энэ нь авралын төлөвлөгөөний талаарх бидний ойлголт, үзэл бодлыг тэлдэг юм" гэжээ ("A Reservoir of Living Water" СБС-ийн залуу насанд хүрэгчдэд зориулсан галын дэргэдэх ярилцлага, 2007 оны 2-р сарын 4, 2).

Багш, суралцагсад хичээлийн жилийн турш ангидаа эдгээр чадвар, арга барилыг ашигладаг. Үүнийг хийхдээ багш нар байн байн түр зогсож, суралцагсадтайгаа энд ашигласан арга барил, чадварын талаар товчхон ярилцаж, уг арга барил, чадварыг бие даан суралцахдаа ашиглахад нь тэднийг урамшуулан дэмж.

### Хичээлийн материалыг унш [2.3.2]

Хуучин Гэрээ, Шинэ Гэрээ, Мормоны Ном, Сургаал ба Гэрээ болон Агуу Үнэт Сувд гэсэн бүх жишиг бүтээл нь сайн мэдээний сургаал ба зарчмуудыг агуулсан сүнслэгээр өдөөгдөн бичсэн бичвэрүүдийг агуулдаг. Эдгээрт Бурхан хүмүүстэй харьцсан харьцааг дүрсэлдэг ба Есүс Христийн Цагаатгалын тухай заадаг. Эдгээр нь сайн мэдээ болон Тэнгэр дэх Эцэгийн маань бэлдсэн авралын төлөвлөгөөний тухай агуу ойлголтыг бидэнд өгдөг.

Багш, суралцагсад хичээл бүрийн холбогдох судрын бүх номыг уншиж судлах ёстой (Сургалтын материалд тэмдэглэсэн Хуучин Гэрээний зарим нэг хэсгээс бусад хэсгийг).



"Бүх л үеийн туршид Тэнгэр дэх Эцэг сонгосон эрэгтэй ба эмэгтэйчүүддээ амьдралын хамгийн адармаатай асуудлуудад ч Ариун Сүнсээр дамжуулан шийдэл олоход нь сүнслэгээр тусалж байсан. Тэрээр эдгээр эрх мэдэл бүхий үйлчлэгч нартаа тэдгээр шийдлүүдийг Түүний аз жаргалын төлөвлөгөө ба Түүний Хайрт Хүү Есүс Христэд итгэдэг хүүхдүүдэд нь зориулан гарын авлага болгон бичихийг сүнслэгээр өдөөж өгсөн. Бидний жишиг бүтээл хэмээн нэрлэдэг Хуучин Гэрээ, Шинэ Гэрээ, Мормоны Ном, Сургаал ба Гэрээ болон Агуу Үнэт Сувд гэсэн судруудаар дамжуулан энэхүү удирдамжийг авахад бидэнд хялбар байдаг."

(Ричард Г.Скотт, "The Power of Scripture," *Ensign*, *Лиахона* 2011 оны 11-р сар, 6)

## Судруудын болон бошиглогчдын үгсийн нөхцөл байдал, агуулгыг ойлгох [2.4]

Судрууд болон бошиглогчдын үгсийн нөхцөл байдал, агуулгыг ойлгох нь багш суралцагсдыг сүнслэгээр өдөөгдөн бичсэн зохиогчийн захиасыг ойлгоход бэлддэг. Нөхцөл байдал агуулга нь үйл явдал мөн бусдын заасан зүйлсийн тухай тэмдэглэсэн сайн мэдээний сургаал ба зарчмуудыг тодруулж, тайлбарлаж өгдөг. Доор өгүүлсэн зүйлс нь судрын агуулга болон нөхцөл байдлыг хэрхэн тайлбарлах тухай заасан хэдий ч эдгээр зарчмууд ба санааг хожмын үеийн бошиглогчдын үгс захиасыг судлахад ашиглаж болно.

Тэмдэглэл

## Нөхцөл байдал [2.4.1]

Нөхцөл байдал гэдэг нь (1) судрын хэсгийн өмнө эсвэл хойно нь ордог шүлэг эсвэл бүлэг шүлгүүд буюу (2) тухайн судрын хэсгийн түүхэн орчин эсвэл тухайн судрын захиас, үйл явдал эсвэл түүхийн далд байдлыг тодруулах учир шалтгаан нь юм.

Нөхцөл байдал нь судрын агуулгыг ойлгоход тусалдаг. Энэ нь судрын бичвэрүүдийн нөхцөл байдлын мэдээллийг агуулж уг түүх, заасан зүйлс, сургаал ба зарчмуудыг гүнзгий ойлгоход тусалдаг. Судрын бүх зохиогчид нь Ариун Сүнсээр удирдагдан бичсэн боловч бичвэрүүдэд уг зохиогчийн төсөөлөл болон өв соёл нөлөөлсөн байдаг. Зохиогчдын бичвэрүүдийг ойлгохын тулд багш, суралцагсад оюун бодлоороо "тэдний ертөнц рүү нэвтэрч" тухайн зохиогчийн нүдээр харах хэрэгтэй болдог. Нөхцөл байдлын өөр өөр жишээг доор өглөө.

"Судруудын заадаг зүйлсийг сайн мэддэг бол. Эзэний сургаалт зүйрлэл ба бошиглогчдын сэрэмжлүүлгийн шалтгаан, нөхцөл байдал зэргийг та бүхэн судлах нь зүйтэй. Тэд тэдгээр нь үнэн юм гэдгийг танд хандан ярьж байгаа мэтээр судал."



Томас С.Монсон, "Be Your Best Self," *Ensign*, *Лиахона* 2009 оны 5-р сар, 68)

**Түүхэн орчин.** Бошиглогч Иосеф Смит Сургаал ба Гэрээний 121, 122, 123-р хэсгүүдийг хүлээн авч бичихдээ Либерти шоронд байсан гэдгийг мэдэх нь эдгээр хэсэгт заасан саад тотгор болон эрх мэдэл, хүч чадлаа ашиглах тухай сургаал зарчмуудыг улам гүнзгий утгатай, хүчтэй болгож өгдөг.

**Соёл иргэншил.** Эртний Израилын баяр ёслолуудын тухай мэдсэнээр эдгээр нь Аврагч болон Түүний номлолтой бэлэгдлийн байдлаар хэрхэн холбогддог болохыг харж чадна. Самаричуудын үндэс угсааг болон Христийн үед еврейчүүд тэдэнд хэрхэн ханддаг байсныг мэдсэнээр сайн санаат самари хүний сургаалт зүйрлэл, Аврагч Самариар аялж байхдаа худаг дээр нэг эмэгтэйтэй уулзсан зэрэг түүх нь бидэнд улам гүн гүнзгий утгатай болдог.

**Сургаалт зүйрлэл, үйл явдал, сургаал буюу зарчмуудад нөлөөлсөн нөхцөл байдал ба асуулт.** Сургаал ба Гэрээний 9-р хэсгийг Оливер Каудерид орчуулах боломжгүй байхад нь хариу болгон өгсөн гэдгийг ойлгох нь уг хэсэгт заасан илчлэлттэй холбоотой зарчмуудыг тодорхой болгож өгдөг.

"Надад судруудыг ойлгох түлхүүр байдаг. Хариултыг гаргаж ирсэн асуулт нь юу байсныг би мэдмээр байна. . .?"



(Иосеф Смит, *Сумийн Түүх* 5:261)

**Хэн хэнтэй, яагаад ярьж байна.** Алмагийн Цагаатгал, Амилуулалт, Шүүлт, нигүүлсэл болон шударга ёсны тухай сургаалууд нь үйлдсэн ноцтой гэм нүглийнхээ улмаас санаа зовж байсан хүү Кориантон дээрээ зочлох үеэрээ үүнийг заасан болохыг бид нөхцөл байдлаас нь олж мэдсэнээр эдгээр нь илүү гүн гүнзгий утгатай болдог.

**Газар зүйн байршил.** Канааны газар зүйн байршлыг мэдэх нь Лот болон Абрахам хаана суурьшиж, ямар сонголт хийж, тэдгээр сонголт нь гэр бүлд нь хэрхэн нөлөөлсөн талаарх бидний мэдлэгийг гүнзгийрүүлдэг.

Судар ба судраас суралцахад туслах материалууд, Сургалтын материал нь багш, суралцагсдын судрын мэдлэгийг дээшлүүлэхэд туслах мэдээллүүдийг хангалттай агуулсан байдаг.

## Агуулга [2.4.2]

Агуулга гэдэг нь судрын бичвэрийг бүрдүүлж бүтээдэг түүх, хүмүүс, үйл явдал, ёслол болон сүнслэгээр өдөөгдөн бичигдсэн тайлбаруудыг хэлнэ. Судрын хэсгүүд дэх сургаал ба зарчмуудыг амьд бөгөөд хамааралтай болгодог зүйл бол судрын агуулга юм. Жишээ нь гуулин ялтсуудыг олж авсан Нифайн түүх бидэнд *Их Эзэнд итгэлтэй байх, Сүнсийг сонсох нь хувь хүнд дааж давшгүй мэт санагдах сорилт бэрхшээлийг даван туулахад тусалдаг гэсэн зарчмыг заадаг.* Египетээс гарсан нь дээр бичигдсэн үйл явдлуудыг ойлгох нь бидэнд *Их Эзэнд итгэж, бошиглогчдыг дагаснаар хүмүүс мөн ард түмэн Их Эзэний амласан адислалуудыг авч чаддаг бөгөөд харин дуулгаваргүй бас гомдоллодог хүмүүст адислалууд өгөгддөггүй* гэдгийг ухааруулдаг.

Судруудад дүрсэлсэн хүмүүсийг мэддэг болсноор суралцагсад сорилт бэрхшээлүүдийг давж, итгэлтэйгээр амьдрах урам зоригтой болдог. Мормоны Номын тухай Ахлагч Ричард Г.Скоттын амласны дагуу:

“Энэ номын хоёр хавтасны дундаас та нар Нифай, Иаков, Енос, Бенжамин, Алма, Аммон, Хиламан, Мормон, Моронай болон бусад олон хүний зохистой жишээ болон нөхөрлөлийг олох болно. Тэд итгэлтэй мөн дуулгавартай байдлын замыг зааж, урам зоригийг бадраах болно. . . .

Гэхдээ хамгийн чухал нь та нарын харааг төгс төгөлдөр найз, бидний Аврагч, Гэтэлгэгч Есүс Христийн зүгт чиглүүлэх болно” (“True Friends That Lift,” *Ensign,*1988 оны 11-р сар, 77).

Агуулгын бас нэгэн чухал хэсэг нь судруудад онцгойлон бичиж үлдээсэн бошиглогчдын номлосон сургамжууд байдаг. Паулын номлол эсвэл Бага Алма нь гэм нүглээсээ болж зовж байгаа суралцагсдад итгэл, урам зоригийн эх сурвалж болж чадна. Хаан Бенжамин ард түмэндээ хандан хэлсэн сүүлчийн үгс нь Аврагч ба Түүний Цагаатгалын хүч чадал, үнэ цэнэ, үйлчлэлийн утга учир, дуулгавартай байдлын адислалууд болон тусламж хэрэгтэй хүмүүст туслахын чухлыг чадварлагаар заадаг. Есүс Христийн шавь болохоор хичээж байгаа суралцагч Аврагчийн Уулан дахь номлолоор хэлсэн үгсийг судалж, үүнийг амьдралдаа хэрэгжүүлэхийг эрэлхийлснээр ойлголтыг авч чадна.

Агуулгыг ойлгоно гэдэг нь хэцүү үг, хэллэг түүнчлэн сургаалт зүйрлэлийн тайлбар, бэлэгдэл зэргийн утгыг сурч ойлгох багтана. Жишээлбэл *давс* (Матай 5:13), *нэгдэн нийлэгтүн* (С ба Г 11:19; 45:48) мөн “хормойгоо шууж” (С ба Г 75:22), “хэтэвч, богц (Лук 10:4-г үзнэ үү) зэрэг үг хэллэгийг мэддэг байх нь судрыг ойлгоход тусалдаг. Аврагчийн сургаалт зүйрлэлээр заасан зарчмуудын бэлэгдлийг нь ойлгох аваас илүү амархан ойлгож чадна. Жишээлбэл агуу үнэт сувд (Матай 13:45–46-г үзнэ үү), үр тариа ба зэрлэг өвс (Матай 13:24–30-г үзнэ үү), алдагдсан хурга (Лук 15:4–7-г үзнэ үү).

Зааж мөн суралцах бүх зүйлсээ судалж үзээд багш нар нөхцөл байдал агуулгыг судлахад, сайн мэдээний сургаал ба зарчмуудыг суралцахад хэдэн цаг зарцуулахаа ухаалгаар шийднэ. Багш нар судрын бичвэрүүд дэх мөнхийн үнэнийг ойлгоход нь суралцагсдад туслахын тулд нөхцөл байдал ба агуулгыг сайн заах ёстой. Гэхдээ нөхцөл байдал болон нарийн ширийн зүйлүүдийг дэндүү онцолж хичээлийн чухал хэсэг болгож болохгүй.

*Тэмдэглэл*



Тэмдэглэл

## Сайн мэдээний сургаал ба зарчмуудын үнэн болоод чухал ач холбогдлыг нь ойлгож, танин мэдэрч, амьдралдаа хэрэгжүүлэх [2.5]

Сайн мэдээний сургаал ба зарчмуудыг таньж мэдэн, ойлгох нь багш, суралцагсдад судар болон бошиглогчдын үгсийг амьдралдаа хэрэгжүүлж, шийдвэр гаргахдаа тэдгээрийг удирдамжаа болгоход тусалдаг. Сайн мэдээний сургаал ба зарчмуудын үнэн баттай хийгээд чухал гэдгийг мэдрэх нь сурсан зүйлсээ амьдралд хэрэгжүүлэх хүслийг нэмэгдүүлдэг. Сайн мэдээний зарчмуудыг хэрэгжүүлэх нь амлагдсан адислалуудыг авчирч, ойлголт ба хөрвөлтийг гүнзгийрүүлж мөн багш суралцагсдыг Аврагчтай илүү адилхан болоход тусалдаг.

Сургаал нь Есүс Христийн сайн мэдээний үндсэн, хэзээ ч өөрчлөгдөшгүй үнэн юм. Эдгээр үнэнд *Тэнгэрлэг Эцэг яс махан биетэй, Бурханы хаант улсад орохын тулд баптисм хийлгэх шаардлагатай* ба *бүх хүмүүн дахин амилах болно* гэсэн сургаалууд багтана.

Зарчим гэдэг нь мөнхийн үнэн буюу хувь хүмүүс шийдвэр гаргахдаа ашиглах журам юм. Сайн мэдээний зарчмууд нь бүх дэлхийнх бөгөөд сайн мэдээний сургаалуудыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлэхэд хүмүүст тусалдаг. Ахлагч Ричард Г.Скотт: "Зарчмууд нь нөхцөл байдал бүрт тохирсон шигшигдсэн үнэнүүд юм" хэмээн заасан ("Acquiring Spiritual Knowledge," *Ensign,* 1993 оны 11-р сар 86). Энэ бол сайн мэдээний зарчим нь ихэвчлэн үйлдэл хийхийг сануулж мөн үр дүнг дагуулдаг гэсэн үг юм. Жишээлбэл: *залбирал уруу таталтуудыг давахад тусалж чаддаг* (С ба Г 10:5-г үзнэ үү) мөн *хэрэв бид Ариун Сүнсний өдөөлтийг дагавал Тэр бидэнд Их Эзэний тушаасан зүйлсийг биелүүлэхэд туслах болно* (1 Нифай 4-г үзнэ үү).

Зарим үед сургаал ба зарчмуудын ялгааг олж харахад хэцүү байж болно. Ахлагч Хенри Б.Айринг дараах зүйлсийг хуваалцсан байдаг: "Сургаал ба зарчмын хоорондын ялгааг олохын тулд би их цаг үрэхгүй. Би иймэрхүү төрлийн харилцан яриаг сонсож байсан ба энэ нь тийм ч үр дүнтэй бус байсан" ("Training Guidelines and Resources: Ахлагч Ричард Г.Скотт ба Ахлагч Хенри Б.Айрингийн ярилцлага" СБС-гийн шууд дамжуулах сургалт нэвтрүүлэг 2003 оны 8-р сар, 10).

### Сургаал ба зарчмуудыг тодорхойлох [2.5.1]

Судруудын нэг гол зорилго бол сайн мэдээний сургаал ба зарчмуудыг заах юм. Ерөнхийлөгч Марион Ж.Ромни тайлбарлахдаа: "Хүн сайн мэдээний зарчмуудыг судлахгүйгээр судруудыг сайн судална гэж үгүй юм. Учир нь зарчмуудыг бидний тусын тулд судруудад бичсэн байдаг" гэжээ ("The Message of the Old Testament" СБС-ийн Хуучин Гэрээний симпиозум 1979 оны 8-р сарын 17, 3). Ахлагч Боид К.Пакер заахдаа: "Зарчмууд нь судруудад байдаг. Тэдгээр нь илчлэлтийн нэг хэсэг бөгөөд илчлэлтийн зорилго мөн" гэсэн байдаг ("Principles," *Ensign,*1985 оны 3-р сар, 8). Энэхүү эрин үед Их Эзэн Түүний Сүмийн багш, удирчдагч нарт сайн мэдээний зарчмуудыг судруудад бичигдсэн байдлаар нь заахыг ийн тушаасан: "Мөн дахин, энэ сүмийн ахлагчид, санваартнууд хийгээд багш нар Библи хийгээд сайн мэдээний бүрэн байдал байгаа Мормоны Номон дахь, миний сайн мэдээний зарчмуудыг заах ёстой" (С ба Г 42:12).

Тэмдэглэл

Судрууд дахь сайн мэдээний сургаал ба зарчмуудыг тодорхойлж, судлахын тулд хичээл зүтгэл гаргаж, дадлага хийх хэрэгтэй. Ахлагч Ричард Г.Скотт хичээл зүтгэлийн талаар хэлэхдээ: "Зарчмуудыг эрж хай. Зарчмуудын тухай тайлбарыг зарчмуудаас нь анхааралтайгаар ялгаж салга" гэжээ ("Acquiring Spiritual Knowledge," 86).

Ангид заримдаа сургаал ба зарчмуудыг багш нар өөрсдөө заадаг. Заримдаа багш нар суралцагсдыг өөрсдөө тодорхойлох боломж олгон, чиглүүлэн дэмждэг. Багш нар суралцагсдыг бие даан өөрсдөө сургаал ба зарчмуудыг таньж мэдэх чадвартай болоход нь шаргуу туслах ёстой.

Сайн мэдээний зарим сургаал ба зарчмуудыг таньж мэдэхэд хялбар байдаг. Учир нь эдгээр нь тодорхой бичигдсэн байдаг. Ийм *тодорхой зарчмууд* нь ихэнхдээ "бид ийн үзэж болох ажгуу", "тиймийн тул", "тиймээс" эсвэл "болгоогтун" гэх мэт хэллэгээр эхлэж зохиогч өөрийн захиасыг төгсгөж байгааг эсвэл дүгнэлтэнд хүрч байгааг харуулдаг.

Жишээ нь Хиламан 3:27 -д "Зүрх сэтгэлийнхээ гүнээс, түүний ариун нэрийг дуудах бүгдэд Их Эзэн нигүүлсэнгүй байдгийг *бид ийн үзэж болох ажгуу*.

Алма 12:10 -д, "*Мөн тиймийн тул* зүрх сэтгэлээ хатууруулах тэр нь, мөнхүү тэр нь үгийн багахан хувийг хүлээж авдаг; мөн зүрх сэтгэлээ хатууруулахгүй, түүнд тэдгээрийг бүрэн дүүрэн мэдэх хүртэл нь үгийн илүү их хэсэг өгөгддөг болой."

Ефес 6:13 -т "*Тиймээс* бүхнийг хийсний дараа, бузар муу өдөрт эсэргүүцэн бат зогсох чадвартай байхын тулд Бурханы бүрэн зэвсгийг ав."

Алма 41:10 -т "*Болгоогтун,* би чамд хэлнэ, ёс бус явдал хэзээ ч аз жаргал байгаагүй." гэж тус тус тэмдэглэжээ.

Олон зарчмыг судрын зохиогч нар шууд бичээгүй харин битүү сануулсан байдаг. *Битүү сануулсан зарчмууд* нь судрын бүтэн ном, бүлэг эсвэл нэг өгүүлбэрээс иржь болно. Магадгүй судрын түүх, үйл явдал эсвэл сургаалт зүйрлэл дунд ч байж болно. Битүү сануулсан зарчмуудыг тодорхойлоход судрын үйл явдалд дүрсэлсэн үнэнийг олж таних, тэдгээрийг тодорхой мөн товчхоноор тэмдэглэх зэрэг орно. Үүнд цаг хугацаа хэрэгтэй бөгөөд энэ нь тунгаан бодохыг шаарддаг. Ахлагч Ричард Г.Скотт: "Өөрсдийн олж авсан үнэн зүйлсээ зарчмын энгийн тодорхойлолт болгоход их хүчин чармайлт гаргах нь чухал ач холбогдолтой юм" хэмээн заажээ ("Acquiring Spiritual Knowledge," 86).

Битүү сануулсан зарчмуудыг судрын хэсэг дэх "шалтгаан-ба-үр дагавар" холбооноос хайх аргаар олж болох юм. Судар дээр гардаг хувь хүн ба бүлэг хүмүүсийн үйлдэл, зан авир, харьцаанд дүн шинжилгээ хийж, адислалууд буюу үр дагавруудыг ойлгож мэдсэнээр сайн мэдээний зарчмуудыг илүү тодотгодог.

Битүү сануулсан зарчмуудыг асуулт асуун мэдэж болно:

- Түүхийн сургамж буюу гол санаа нь юу вэ?
- Энэ үйл явдал эсвэл үйлийн өрнөлд зохиогч юу багтаасан гэж бодож байна вэ?
- Зохиогч үгээрээ бидэнд юу заахыг хүссэн бэ?
- Энэ хэсэгт ямар чухал үнэнийг заасан вэ?

*Тэмдэглэл*

Битүү сануулсан зарчмуудын жишээнд:

Залуу Алма эсвэл Паулын амьдралын үйл явдлуудаас: *Үнэнийг хүлээн зөвшөөрч, нүглээ наманчлах нь бусдыг сайн мэдээний адислалууд руу хөтөлдөг* (Алма 36:10–21; Үйлс 9:4–20-г үзнэ үү).

Арван охины тухай сургаалт зүйрлэлээс: *Бид итгэлтэйгээр өөрсдийгөө сүнслэгээр бэлтгэх аваас Их Эзэнийг ирэхэд бэлэн байх болно;* эсвэл *Өөрсдийгөө сүнслэг байдлаар бэлдэггүй хүмүүс Их Эзэний ирэлтээр Түүгээр хүлээн авагдахгүй* (Матай 25:1–13-г үзнэ үү).



Давид ба Голиатын түүхээс: *Бид Бурханд итгэлтэй мөн зоригтой байвал амьдралд тулгарах бэрхшээл сорилтуудыг даван туулж чадна* (1 Самуел 17:40–51-г үзнэ үү).

Суралцагсад сургаал ба зарчмуудыг таньж судлахад туслах зарим аргууд:

- Суралцагсдыг судалж буй зүйлстэйгээ холбоотой "хэрвээ-амлалт" гэсэн тодорхойлолт дээр төсөөллөө бичихийг хүс.
- Сурсан үнэнүүдээ дүгнэн "бид ийн үзэж болох ажгуу" гэсэн тодорхойлолт бичих даалгавар өг.
- Суралцагсдыг судрын хэсгээс хувь хүмүүсийн хийсэн үйлдлүүдийг тогтоож, уг үйлдлийн учир хүлээн авсан адислал буюу үр дагавруудыг олуул.
- Сургаал ба зарчмуудын тодорхойлолтыг илтгэсэн судрын түлхүүр үгс буюу өгүүлбэрүүдийн доогуур зурж тэмдэглэхэд нь суралцагсдыг дэмж.
- Судрын хэсгийн сургаал эсвэл зарчмыг самбар дээр бич. Уг зарчмыг батлахын тулд судрын хэсгээс эрж олохыг суралцагчдаас хүс.

Сургаал ба зарчмуудыг олсны дараа тэдгээрийг энгийн, тодорхойгоор тайлбарлах нь чухал. "Үнэнийг мэдүүлэхийн тулд үүнийг тодорхой тайлбарлах ёстой бөгөөд ингэснээр Ариун Сүнс нь хүмүүний бодгальд тухайн ажил үнэн гэдгийг гэрчлэх илүү боломжтой болдог *New Witnesses for God,* 3 vols. , 2:vii" (Б.Х.Роберт, Жеймс И.Фауст "What I Want My Son to Know before He Leaves on His Mission," *Ensign,* 1996 оны 5-сар, 41; *Миний сайн мэдээг номло* 2004, 182).

Тодорхойлсон зарчмыг самбар дээр бичих, суралцагсдаар бичүүлэх эсвэл судар дээрээ доогуур нь зурж тэмдэглэхийг хүсэх нь тэдэнд эдгээр үнэнийг оюун ухаандаа тогтооход тусалдаг.

## Сургаал ба зарчмуудыг ойлгох нь [2.5.2]

Сайн мэдээний сургаал ба зарчмуудыг ойлгох гэдэг нь суралцагсад үнэнийг, Их Эзэний төлөвлөгөөн дэх бусад сургаал ба зарчмуудыг амьдралтайгаа холбох мөн хэзээ эдгээр зарчмыг хэрэгжүүлж болохыг таньж мэдэн, ойлгохыг хэлнэ. Багш, суралцагсад сургаал ба зарчмыг ойлгосноор *эдгээр үгс нь ямар утгатай болохыг ойлгоод зогсохгүй* эдгээр зарчим болон сургаал нь *тэдний амьдралд хэрхэн нөлөөлж чадахыг мэддэг болно.* Сургаал ба зарчмыг таньж мэдэн, ойлгосон үед тэдгээрийг хэрэгжүүлэхэд илүү хялбар болдог.

Тэмдэглэл

Багш, суралцагсад судраас холбогдох сургаал болон нэмэлт чухал санаануудыг хайж, хожмын үеийн бошиглогчид, төлөөлөгчдийн үгс болон сургаалуудад анхаарлаа хандуулж, судалж буй сайн мэдээний үнэнүүдийг бусдад тайлбарлаж мөн Ариун Сүнсний тусламж эрэлхийлэн залбирч сайн мэдээний сургаал ба зарчмын талаарх ойлголтоо өсгөж болно. Зарчмуудыг амьдралдаа хэрэгжүүлэх үед ойлголт үргэлжлэн гүнзгийрсээр байдаг.

Багш нар сургаал ба зарчмуудыг ойлгуулахын тулд суралцагсдыг эдгээрийн утга санаанд дүгнэлт хийхэд хөтлөх асуултуудыг тавьж болно. Жишээлбэл Мормоны Номонд гардаг 2,000 залуу дайчдын түүхээс *бид хэрэв эргэлзэхгүй аваас Бурхан биднийг чөлөөлөх болно* гэдэг зарчмыг сурч болно (Алма 56:47–48-г үзнэ үү). Энэ зарчим нь ямар утгатай болохыг илүү сайтар ойлгохын тулд багш, суралцагсад эдгээр асуултын тухай тунгаан бодож болох юм:

- Залуу дайчид юунд эргэлзээгүй вэ?
- Эдгээр залуу дайчид эргэлзээгүй гэдгийг юу баталж байна вэ?
- Бурхан залуу дайчдыг хэрхэн аварсан бэ?
- Өнөө үед Сүмийн өсвөр үеийнхэн ямар төрлийн "тэмцэл" хийж байна вэ?
- Ийм тэмцлээс Бурхан тэднийг аварч болох ямар арга замууд байна вэ?
- Абинадай, Иосеф Смит, Шадрах, Мешах, Абед-него нарын туршлагууд нь бидэнд аврагдсан байх гэдэг нь юу гэсэн утгатай болох тухай юу зааж байна вэ?



Хуучин Гэрээнд гардаг Нааман, Елиша нарын түүхээс бид *хэрэв бид даруу төлөв, бошиглогчдын зөвлөгөөг дагах хүсэлтэй байх аваас эдгээгдэж чадна* гэсэн зарчмыг сурдаг (2 Хаадын дэд 5:1–14). Энэ зарчим нь ямар утгатай болохыг ойлгохын тулд багш, суралцагсад эдгээр асуултуудын тухай тунгаан бодож болох юм:

- Даруу байдал бидэнд бошиглогчдын зөвлөгөөг дагахад хэрхэн тусалдаг вэ?
- Нааман эцэстээ "долоон удаа угаахад" бэлэн болсон нь бошиглогчдын зөвлөгөөг *үнэхээр* дагах гэдэг нь юу гэсэн үг болохыг ойлгоход бидэнд хэрхэн тусалж байна вэ?
- Бие махбодыг эдгээхээс гадна өнөө үед өөр юуг эдгээх хэрэгтэй гэж бодож байна вэ?
- Дэлхийнхэнд ойлгомжгүй санагдаж болох ч биднийг сүнслэгээр эдгээх ямар зүйлсийг хийхийг бошиглогчид биднээс хүсдэг вэ?

## Сургаал ба зарчмуудын үнэн хийгээд чухал гэдгийг мэдрэх нь [2.5.3]

Суралцагсад сайн мэдээний сургаал ба зарчмуудыг ойлгож болох хэдий ч тэдгээрийн үнэн хийгээд чухал гэдгийг Сүнсээр мэдэрч, амьдралынхаа нэг хэсэг болгохыг хүсэх хүртлээ эдгээрийг амьдралдаа хэрэгжүүлэхгүй байх нь олонтоо. "Жинхэнэ багш бол сайн мэдээний үнэнийг заагаад дараа нь . . . , суралцагсдад сүнслэг гэрчлэлийг хүлээн авч, үйлдэл хийх тухай ойлголтыг тэдний зүрх сэтгэлд суулгадаг юм" хэмээн Ахлагч Роберт Д.Хейлс тайлбарласан байдаг ("Teaching by Faith" Ахлагч Роберт Д.Хейлстэй хийсэн уулзалт, 2002 оны 2-р сарын 1, 5).

Тэмдэглэл

Ариун Сүнс сургаал ба зарчмын чухал болохыг суралцагсдын зүрх сэтгэлд мэдрүүлж чадах бөгөөд тэдэнд зарчмыг хэрэгжүүлэх хүсэл мөн хүчийг өгч чадна. Багш нар ангийн суралцагч бүрт үүнийг хийхэд нь туслахын тулд бүх хүчин чармайлтаа дайчлах ёстой. Ахлагч Ричард Г.Скотт багш нарт хандан: "Та нар суралцагсдынхаа оюун бодол, зүрх сэтгэлд үнэнийг баттай суулгаж, тэднийг үүнийг амьдралынхаа турш ашиглаж байхын тулд удирдамж хүсч залбирах уу? Та нар үүнийг залбиралтайгаар эрэлхийлэх аваас Их Эзэн та нарыг чиглүүлэх болно гэдгийг би мэднэ" гэжээ ("To Understand and Live Truth," Ахлагч Ричард Г.Скоттой хийсэн уулзалт 2005 оны 2-р сарын 4, 2).



**"Бид сайн мэдээг заахдаа Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний үнэн мөн чанар, уялдаа холбоо хийгээд чухал гэдгийг урьд өмнөхөөсөө илүүтэйгээр чухалчилж үзэх хэрэгтэй. Ийн заах арга барил нь хөрвөлтийг түргэсгэдэг учраас маш чухал юм."**

**(Нийл А.Максвелл, "Those Seedling Saints Who Sit before You" Хуучин Гэрээний тухай СБС-ийн симпозиум, 1983 оны 8-р сарын 19 , 2)**

Сурсан зарчмынхаа дагуу үйлдэхэд тэднийг бэлтгэх мөн Сүнсний нөлөөг зүрх сэтгэлдээ урьж авчрахад нь туслах хамгийн үр дүнтэй аргуудын нэг бол уг зарчимтай холбоотой хувийн туршлагуудынхаа талаар бодохыг хүсэх юм (5.1.3 "*Мэдрэмж ба гэрчлэлийг авчирдаг* асуултууд" хэсгийг үзнэ үү). Энэ нь суралцагсдыг тэдний өөрсдийн болон бусад хүмүүсийн амьдралд уг зарчим хэрхэн нөлөөлсөн болохыг ухаарахад нь тусалдаг юм. Жишээлбэл аравны нэгийн хуулийг заасны дараа багш тэднээс: "Аравны нэгийн хуулийг дагаснаар та нар ямар адислал авч байсан бэ? Мөн бусад хүмүүс ямар адислал авч байхыг та харж байсан бэ?" гэж асууж болно. Суралцагсад ийм асуултын тухай бодож тунгаан мөн хувийн туршлагаасаа ангийнхантайгаа хуваалцах аваас Ариун Сүнс тэдэнд сайн мэдээний сургаал ба зарчмуудыг дагаснаар хүлээн авсан адислалуудаа илүү тодоор харахад нь тусалж чадна. Суралцагсдыг эдгээр үнэнийг амьдралдаа хэрэгжүүлэх илүү их хүсэлтэй болоход нь Сүнс туслах болно. Багш нар суралцагсдад өөрийн болон бусдын туршлагаас хуваалцаж, ярилцсан зарчмын дагуу амьдрахын чухал хийгээд үнэн болохыг мэдрэхэд нь тэдэнд тусалж чадна.

Багш нар сургаал ба зарчмууд үнэн болох талаар гэрчлэлээ хуваалцах боломжийг суралцагсдад олгох ёстой. Багш нар өөрсдөө гэрчлэлээ хуваалцах боломжийг мөн эрэлхийлж байх ёстой. Багш нар сургаал ба зарчмуудын үнэн хийгээд чухал болохыг мэдрэхэд нь суралцагсдад туслахын тулд судруудад гардаг хүмүүсийн гэрчлэлийг онцлон тэмдэглэж мөн хожмын үеийн бошиглогч, төлөөлөгчдийн гэрчлэлийг унших буюу сонсгож болно.



**". . . Ангийн гишүүдийн оюуныг мэдээллээр дүүргэх нь сайн мэдээг заах гол зорилго биш ээ. . . . Харин хүмүүсийг сайн мэдээний зарчмуудаар амьдрах тухай бодож, хүсч, үйлдэхэд нөлөөлөх нь гол зорилго мөн."**

**(Томас С.Монсон, Conference Report, 1970 оны 10-р сар, 107)**

## Сургаал ба зарчмуудыг хэрэгжүүлэх нь [2.5.4]

Суралцагсад сурсан зарчмуудынхаа дагуу бодож сэтгэн, ярьж мөн амьдрах аваас энэ нь хэрэгжиж байна гэсэн үг. Хэрэгжүүлэх нь хэчнээн чухал болох талаар Ахлагч Ричард Г.Скотт тайлбарлахдаа: "Ангид заасан зүйлс хэр зэрэг үр дүнтэй байгааг хэмжих хамгийн сайн хэмжүүр бол суралцагсад заасан үнэнүүдийг ойлгож, амьдралдаа хэрэгжүүлж байгааг нь харах юм" гэжээ ("Үнэнийг ойлгож, үүгээр амьдрах нь" 3).

Суралцагсад сайн мэдээний зарчмуудыг амьдралдаа хэрэгжүүлснээр амлагдсан адислалуудыг хүлээн авах болно. Тэд хэрэгжүүлсэн зарчим, сургаалынхаа тухай илүү гүнзгий ойлголтыг авах болно. Жишээ нь Ариун өдрийг ариунаар сахидаг суралцагсад нь

ариунаар сахидаггүй суралцагсдаас хамаагүй илүү баттай ойлголттой болдог. Их Эзэнд бүхий л сэтгэл зүрхээрээ итгэж найддаг (Сургаалт үгс 3:5-г үзнэ үү) мөн уруу таталт, сорилт бэрхшээлтэй тулгарсан үедээ хүч чадал хийгээд тайвшралыг авч байсан суралцагсад ийм туршлагыг хүлээн авч байгаагүй тэдгээрээс илүү сайн ойлголттой байдаг.



Багш нар суралцагсдад хичээл дээр тунгаан бодож, ойлгосон зүйлийнхээ талаар бичиж тэмдэглэн, үүнийгээ амьдралдаа хэрэгжүүлэхийн тулд хийх ёстой алхмуудын талаар бодох цаг өгөх ёстой. Энэ үедээ Их Эзэнээс удирдамж чиглүүлэл хүсэхэд нь суралцагсдыг дэмж. Багш нар суралцагсдад тохиолдож болох нөхцөл байдлын талаар ярилцаж, тийм үед сайн мэдээний зарчмуудыг хэрэгжүүлснээр тэдний амьдрал хэрхэн адислагдаж болох талаар хуваалцаж болно. Заалгасан зарчмуудаа хэрэгжүүлэхэд нь туслах зорилт тавихыг тэд суралцагсдад санал болгож болно. Багш нар суралцагсдыг гэртээ хариад заалгасан зарчмаа санаж байхад нь туслахын тулд судар, эшлэл, шүлэг найраг эсвэл сүмийн дууллын бадгуудыг бичсэн тараах материал бэлтгэн өгч болно.

Заримдаа багш, суралцагсдад сайн мэдээний зарчмуудыг хэрхэн хэрэгжүүлэх талаар санал тавьж болох юм. Иймэрхүү жишээнүүд нь суралцагсдад өдөр тутмынхаа амьдралд сайн мэдээний зарчмуудыг хэрэгжүүлэх хэрэгтэй санааг өгдөг. Гэхдээ багш нар суралцагсдад яг таг нарийн заавар өгөхөөс болгоомжлох ёстой. Гэвч хэрхэн хэрэгжүүлэх талаарх хамгийн чухал удирдамж нь хувь хүн бүрт Их Эзэнээс Ариун Сүнсээр дамжуулан хувийн илчлэлтээр ирдэг гэдгийг санаарай. Ахлагч Даллин Х.Өүкс заахдаа: “Сайн мэдээний зарчмууд ба хаант улсын сургаалыг (С ба Г 88:77) заахаар тушаагдсан багш нар нь ерөнхийдөө тодорхой дүрэм эсвэл хүсэлт тавихаас зайлсхийх ёстой. . . . Багш сургаал ба үүнтэй холбоотой зарчмуудыг судраас, амьд бошиглогчдоос заана. Харин үүнтэй холбоотой тодорхой дүрэм эсвэл хүсэлт гаргах нь хувь хүн, гэр бүлүүдийн үүрэг юм” гэжээ.

## Сайн мэдээний сургаал ба зарчмыг тайлбарлах, хуваалцах мөн гэрчлэх [2.6]

Сургаал ба зарчмуудыг тайлбарлах, энэ талаарх бодол, туршлагаасаа хуваалцах, тэнгэрлэг үнэнийг гэрчлэх нь сайн мэдээний сургаал ба зарчмуудын талаарх хүмүүний ойлголтыг тодорхой болгож, сайн мэдээг бусдад заах тэдний чадварыг нэмэгдүүлдэг. Суралцагсад тайлбарлаж, хуваалцаж, гэрчилж байхдаа ихэвчлэн Ариун Сүнсээр удирдагдаж, илэрхийлж байгаа зүйлсийнхээ талаар илүү гүнзгий гэрчлэлийг хүлээн авдаг. Ариун Сүнсний хүчээр тэдний үгс ба илэрхийлж байгаа зүйлс нь сонсож байгаа үе тэнгийнхэн болон бусад хүмүүсийн зүрх сэтгэл, оюун бодолд хүрч чадна.

Тунгаан бодож, залбиралтайгаар судалж, бэлтгэлтэй заадаг багш нар маш их зүйлийг суралцах боломжтой байдаг. Энэ нь суралцагсдын хувьд ч ижил байдаг. Тэд сэргээгдсэн сайн мэдээний сургаал ба зарчмуудыг нэг нэгэндээ зааж, сурч байх явцдаа илүү сайн ойлгож, гэрчлэлээ хүчирхэгжүүлдэг.

*Тэмдэглэл*

## Тайлбарлах [2.6.1]

Багш, суралцагсад бие биедээ судруудыг тайлбарлаж өгснөөр судрын тухай ойлголтоо тэлдэг. Судрын хэсгийг эсвэл сургаал ба зарчмыг тодорхой бөгөөд энгийнээр ярихаар бэлтгэх нь багш, суралцагсдыг шүлгүүдийг тунгаан бодож, бодлоо цэгцэлж, Ариун Сүнсээр заалгахад бэлтгэдэг юм.

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл бидэнд заахдаа: "Бид юмсыг хийж байж л сурдаг. Бид сайн мэдээг заахаар судлах аваас мэдлэгийг эзэмшиж, бусдын замыг гэрэлтүүлэх дэнлүүг барьж өөрсдийн замыг гэрэлтүүлдэг юм. Бид хичээлээ бусдад сайн заахын тулд судруудыг судлан, цэгцлэн дүгнэснээр өөрсдийн оюун ухааныг мөн цэгцтэй ойлгомжтой болгодог. Бид мэддэг зүйлсийнхээ тухай тайлбарлах үед урьд нь нээгдээгүй байсан нэмэлт үнэнүүд ирж, шинэ ойлголт, шинэ холбоос бас шинэ зорилго бий болдог" гэжээ (*The Teachings of Spencer W. Kimball* 1982, 530).

Суралцагсдад сургаал ба зарчмыг хэн нэгэнд тайлбарлах боломжийг өгснөөр тэднийг илүү нухацтайгаар бодож, сурсан зүйлсээ бусдад заахын өмнө илүү агуу ойлголтыг эрэлхийлэхэд хөтөлдөг. Багш нар суралцагсдаас итгэлтэй байх, баптисм хийлгэсэн байх эсвэл аравны нэгийн хуулийг дагах нь яагаад чухал вэ хэмээн асууж болно. Суралцагсдыг бүтээлт ба уналт эсвэл Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөнд гэр бүл хамгийн чухал гэдэгт яагаад итгэдэг болохоо хэн нэгэнд ярихыг урьж болно. Үүнийг хийхдээ жижиг бүлгүүдийн дунд ярилцаж, ангидаа жүжигчилсэн тоглолт хийж эсвэл бичих дасгалаар хийж болно. Суралцагсдыг судрын хэсгээс эсвэл сургаал ба зарчмын талаар эцэг эх, ах эгч, дүү, найз нартаа тайлбарлахыг хүсэх нь үр дүнтэй байдаг.



## Хуваалцах [2.6.2]

Багш, суралцагч хоёулаа сургаал ба зарчимтай холбоотой хувийн туршлагаасаа мөн өөрсдийн үзэл бодол, ойлголтоо хуваалцах боломжтой байх ёстой. Тэд зарчим ба сургаалтай холбоотой бусдын амьдралын туршлагыг гэрчилсэн тухайгаа хуваалцаж болно.

Ерөнхийлөгч Бага Ж.Рубен Кларк: "Таны семинар эсвэл институтийн ангид сүнслэг адислалын талаар сайн ойлголтгүй, залбирлын үр дүнг огт мэдэрч байгаагүй, өвчтэй хүнийг эдгээх итгэлийн хүч чадлыг гэрчилж байгаагүй эсвэл энэхүү дэлхийд үл тоомсорлодог сүнслэг бэлгүүдийг харж чадаагүй байгаа гэрэвшиж, болгоомжилсон өсвөр үеийн суралцагч орж ирэх болно" гэж хэлсэн (*The Charted Course of the Church in Education,* хэвлэлт. 1994, 9). Суралцагсдад иймэрхүү туршлагаасаа ангидаа хуваалцах боломжийг олгоорой. Зарим туршлагууд нь ангидаа хуваалцахад дэндүү хувийн, ариун нандин байдаг гэдгийг ойлгоход нь багш нар суралцагсдад туслах хэрэгтэй байж магадгүй; Алма 12:9; С ба Г 63:64-г үзнэ үү.)

Тэмдэглэл

## Гэрчлэх [2.6.3]

Суралцагсад сайн мэдээний зарчмуудыг тайлбарлаж, тэдгээрийг амьдралдаа хэрэгжүүлсэн туршлагаасаа хуваалцах үедээ өөрсдийн итгэдэг болсон зүйлээ гэрчлэхэд илүү сайн бэлтгэгддэг.

Гэрчлэлээ хуваалцсанаар хүлээн авдаг адислалын тухай Ахлагч Боид К.Пакер тайлбарлахдаа: “Энэ адислалын талаар би та нарт тайлбарлаж өгөх юмсан. Гэрчлэлээ *хуваалцсанаар* гэрчлэлийг *олж авдаг* юм шүү! . . .

Уншсан зүйлээсээ эсвэл хэн нэгний хэлсэн үгсээс гэрчлэлийг хүлээн авах нь нэг хэрэг. Энэ бол эхлэх чухал алхам. Харин Сүнс *таны* гэрчилсэн зүйлс үнэн гэдгийг цээжин дотор тань гэрчлэх нь тэс өөр хэрэг юм” гэжээ (“The Candle of the Lord,” 54–55).

Гэрчлэлээ хуваалцах нь гэрчлэлээ хуваалцсан хүнийг адислаад зогсохгүй бусдын итгэл ба гэрчлэлийг хүчирхэгжүүлдэг юм. Гэрчлэл нь Ариун Сүнсэнд сэргээгдсэн сайн мэдээний сургаал ба зарчмыг гэрчлэх боломжийг олгодог. Гэрчлэлийг “би гэрчлэлээ хуваалцмаар байна” гэдэг үгсээр үргэлж эхэлдэггүй. Гэрчлэлийг үнэн гэж мэддэг зүйлсээ чин сэтгэлээсээ, итгэлтэйгээр ярьснаар хуваалцаж болно. Гэрчлэл хуваалцахдаа хувь хүн сайн мэдээний сургаал ба зарчмын тухай юу мэдэрдэг болохоо, энэ нь амьдралд нь ямар өөрчлөлтийг авчирсан тухай энгийнээр батлан хэлж болно. Багш болон бусад суралцагсад нь тухайн зарчмуудын үнэ цэнийн талаар гэрчлэлээ хуваалцахад суралцагсад сайн мэдээний зарчмуудыг хэрхэн хэрэгжүүлж болохыг илүү сайн ойлгож, хэрэгжүүлэхээр сүнслэгээр өдөөгддөг юм.



**“Гэрчлэл--жинхэнэ гэрчлэл бол Сүнснээс төрж, Ариун Сүнсээр баталгаажиж, хүмүүсийн амьдралыг өөрчилдөг.”**

**(М.Рассел Баллард, “Pure Testimony,” *Ensign*, *Лиахона,* 2004 оны 11-р сар, 40)**

Багш нар суралцагсдыг сайн мэдээний үнэнийг гэрчлэхэд нь урамшуулан дэмжихийн тулд тэднээс асуулт асууж мөн тэднийг хувийн туршлага болон итгэлээсээ хуваалцахыг хүсч болно (5.1.3 “*Мэдрэмж ба гэрчлэлийг авчирдаг* асуултууд” хэсгийг үзнэ үү). Суралцагсдад үе тэнгийнхэнтэйгээ гэрчлэлээ хуваалцах боломжийг тэд олгох хэрэгтэй. Багш нар гэрчлэлийн хувийн, нандин чанаруудыг харгалзан үзэх ёстой. Тэд суралцагсдыг гэрчлэлээ хуваалцахад урьж болох ч хэзээ ч шаардаж болохгүй. Багш нар Тэнгэрлэг Эцэг болон Түүний Хүү Есүс Христийг хайрлах хайрынхаа тухай мөн сайн мэдээний сургаал ба зарчмуудын үнэн хийгээд үнэ цэнэтэй талаарх гэрчлэлээ хуваалцах боломжийг үргэлж ашиглаж байх ёстой. Аврагч болон хожмын үеийн бошиглогч, төлөөлөгчдийн хуваалцсан гэрчлэлээс эш татахдаа багш нар анхааралтай байх ёстой.



**“Суралцагсад хичээлд идэвхтэй оролцож, үе тэнгийнхэндээ гэрчлэлээ хуваалцах үед ангид итгэлийг хөхүүлэн дэмжих үйл явц явагдаж байдаг юм.”**

**(Роберт Д.Хейлс, “Teaching by Faith,” 4)**

*Тэмдэглэл*

## Төгс эзэмших судрын хэсгүүд болон үндсэн сургаалууд [2.7]

Хүн мөнхийн үнэнүүдийг оюун ухаан, зүрх сэтгэлдээ нандигнан хадгалах аваас хэрэгтэй үед нь Ариун Сүнс уг үнэнийг сануулж, итгэлтэйгээр үйлдэх хүч зоригийг тэдэнд өгөх болно. Ерөнхийлөгч Ховард В.Хантер заахдаа:

“Би та нарыг заахдаа судруудаас ашиглаж, суралцагсдыг судруудтай нөхөрлөж, тэдгээрийг ашиглаж судлахад нь туслахын тулд бүх хүч чадлаа дайчлаасай хэмээн хүсч байна. Өсвөр үеийнхэн судруудаа итгэж найддаг болохыг би хүсдэг. . . .

Нэгдүгээрт бид суралцагсдыг үнэнд хийгээд судруудын хүч чадалд итгэж найддаг байгаасай хэмээн хүсч байна. Тэд Тэнгэрлэг Эцэг судруудаар дамжуулан тэдэнтэй ярьдаг мөн асуудал тулгарахад, залбирлынхаа хариултыг судруудаас авч чадна гэсэн итгэлтэй болоосой хэмээн бид хүсдэг. . . .

. . .Танай ангийн суралцагсдын хэн нь ч хичээлээ тарахдаа судруудаа хангалттай сайн мэддэггүй учир хэрэгтэй судрын хэсгээ олж чадахгүй ичиж зовон, айж эмээн ангиас гардаггүй гэдэгт бид найдаж байна” гэжээ (“Eternal Investments,” 2).

Суралцагсдыг мөнхийн үнэнүүдийг нандигнаж, судруудад итгэх итгэлээ өсгөхөд зориулж С ба И-ээс судрын төгс эзэмших шүлгүүдийг сонгож, үндсэн сургаалын жагсаалтыг бэлтгэн гаргасан байдаг. Судрын төгс эзэмших шүлгүүд болон үндсэн сургаалуудыг судлахдаа хамтад нь судлах нь зүйтэй. Ингэснээр суралцагсад үндсэн сургаалуудын талаар сэтгэгдлээ өөрийн үгээр илэрхийлж мөн эдгээр үнэнийг тайлбарлаж, гэрчлэхдээ төгс эзэмших судруудыг ашиглаж сурах болно.

### Төгс эзэмших судрууд [2.7.1]

Шашны семинар ба институтээс семинарын дөрвөн хичээл бүрт зориулж төгс эзэмших 25 судрын хэсгийг сонгосон байдаг. Эдгээр хэсэг нь сайн мэдээг ойлгож, хуваалцах мөн итгэлээ батжуулах судрын чухал үндэс болж өгдөг. Семинарын суралцагсдыг доор дүрсэлсэн аргуудаар судрын хэсгүүдийг “төгс эзэмшихийг” уриалдаг. Институтийн суралцагсад төгс эзэмших судрын эдгээр 100 хэсэгт тулгуурлаж, судрын гол хэсгүүдийг ойлгох ойлголтоо гүнзгийрүүлэн хөгжүүлэх ёстой.

Судрын хэсгүүдийг төгс эзэмшихийн тулд:

- Холбогдох судрын эшлэлүүдийг мэддэг болж шүлгээ **олох**.
- Судрын хэсгүүдийн нөхцөл байдал ба утга агуулгыг **ойлгох**.
- Судрын хэсгүүдэд заасан сургаал ба зарчмуудыг **хэрэгжүүлэх**.
- Судрын хэсгүүдийг **цээжлэх** хэрэгтэй.

Цээжлэх нь судрын хэсгийг мэддэг болж, тэдгээрийг хайрлахад туслах гайхамшигтай зэмсэг мөн. Ахлагч Ричард Г.Скотт тайлбарлахдаа: "Их Эзэний цэдэглэсэн тэр байдлаар нь судрыг хэрэглэх нь тэдгээрийг өөрчилж өөрийн үгээр хэлснээс илүү жинхэнэ хүчээ хадгалсаар байдаг" гэсэн ("He Lives," *Ensign,* 1999 оны 11-р сар, 88). Суралцагч бүрт анхаарлаа хандуулах хэрэгтэй боловч тэдний чадавх ба нөхцөл байдлыг харгалзан ажиллах хэрэгтэй. Суралцагсад цээжилж чадахгүй бол ичиж, санаа зовох хэрэггүй.



**"Судруудыг цээжилснээр агуу их хүч чадлыг авч болно. Судрыг цээжлэх нь шинэ найзтай болохтой ижил юм. Энэ нь хэрэгтэй үед тусалж, сүнслэг нөлөө болон тайвшралыг өгөх мөн шаардлагатай өөрчлөлтийг хийх урам зоригийг өгөх шинэ найзыг олохтой ижил буюу."**

(Ричард Г.Скотт, "The Power of Scripture," 6)

Багш нар эдгээр судрын хэсгийг өөрсдөө төгс эзэмшсэн байвал суралцагсдад туслахад илүү дөхөмтэй байна. Багш нар төгс эзэмших судрын хэсгүүдээс тогтмол эш татаж, эдгээрт найдаж, суралцах өөр өөр арга барилыг ашиглавал суралцагсдад судрын хэсгүүдээ төгс эзэмшихэд нь амжилттайгаар тусалж чадна. Төгс эзэмших судрын хэсгүүдийг хичээлийн үеэр холбогдох сургаал ба зарчмуудыг тодорхойлохын тулд ашиглана. Эдгээрийг онцгой цугларалтын уриа болгож эсвэл ангийн хаа нэгтээ байрлуулан ашиглаж болно. Суралцагсдаа эдгээрийг ангиас гадуур сурч, хэрэгжүүлэхийг дэмжих ёстой.

Хэд хэдэн багш нэг байранд үйлчилдэг газар багш нар нь судрын төгс эзэмших үйл ажиллагаанд хамтран оролцох аваас суралцагсдын суралцах үйл явц илүү ахицтай болох болно. Багш нар суралцагсдыг судрын сонгогдсон бүх хэсгийг сайн мэддэг байлгахын тулд заримдаа өнгөрсөн жил үзсэн судрын төгс эзэмших хэсгээс эш татаж болно.

Судраас төгс эзэмших нь сургалтын материалын маш чухал хэсэг ч гэсэн энэ нь туслах зүйл бөгөөд судраас суралцах дэс дараалдыг алдагдуулах ёсгүй. Судрын хэсгийг төгс эзэмших цагийг гаргахдаа багш нар ухаалаг хандах хэрэгтэй. Ялангуяа гэрээр заадаг багш нар хичээлээ судраас төгс эзэмших үйл ажиллагаа болгохгүйн тулд болгоомжтой байх ёстой. Багш нар үйл ажиллагаа, заах арга барил, хөгжим зэргээ зохистой, зорилготой сонгож, аливаа зөрчилдөөн маргалдаанаас зайлсхийх ёстой.

## Үндсэн сургаалууд [2.7.2]

Үндсэн сургаалуудыг семинар ба институтийн хичээлүүд дээр онцлон авч үздэг. Багш нар суралцагсдад сайн мэдээний эдгээр үндсэн сургаалыг таньж мэдэн, ойлгож итгэн, үүнийг тайлбарлаж мөн амьдралдаа хэрэгжүүлэхэд нь туслах ёстой. Ингэснээр тэд суралцагсдад гэрчлэлээ хүчирхэгжүүлж, Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээг үнэлэх үнэлэмжийг нь өсгөж чадна. Үндсэн сургаалуудаас суралцах нь тэднийг бусдад эдгээр чухал үнэнийг заахад илүү сайн бэлтгэхэд тусалдаг.

Хэдийгээр үндсэн сургаалын жагсаалтад ороогүй ч бусад чухал сургаалууд байдаг гэдгийг санах нь маш чухал юм.



*Тэмдэглэл*

Шашны семинар ба институтийн сонгосон үндсэн сургаалуудад:

- Бурхан тэргүүтэн
- Авралын төлөвлөгөө
- Есүс Христийн Цагаатгал
- Эрин үе, урвалт ба сэргээлт
- Бошиглогчид ба илчлэлт
- Санваар ба санваарын түлхүүрүүд
- Ёслол ба гэрээнүүд
- Гэрлэлт ба гэр бүл
- Зарлигууд багтана.

Багш нар үндсэн сургаалыг өөрсдөө судалж ойлгосноор эдгээрийн тухай заахдаа илүү сайн эш татаж, гэрчлэх болно. Гэсэн хэдий ч багш нар эдгээр сургаал дээр төвлөрөн, судрыг дэс дараалалтай заахаас хөндийрч болохгүй. Харин эдгээр сургаал нь судрын бичвэр, судлах хичээлүүд дээр гарч ирвэл анхаарлаа хандуулах нь зөв юм. Ийм аргаар үндсэн сургаалын жагсаалтыг мөнхийн үнэнд төвлөрөх сануулагч болгон ашиглаж, цуврал хичээлийн явцад онцлон тэмдэглэж байх ёстой. Үндсэн сургаалуудыг онцгой цуглаануудын уриа болгон ашиглаж болно.

Тэвчээртэй мөн тууштай байх нь суралцагсдыг үндсэн сургаалыг ойлгоход их тусалдаг гэдгийг ухаалаг багш нар санадаг. Суралцагч нь бүх зүйлсийг нэг дор ойлгоно гэж байдаггүй. Их Эзэн Өөрийн хүүхдүүддээ “шат шатаар, дүрэм дүрмээр” заадаг (С ба Г 98:12). Багш, суралцагсад эдгээр сургаалын талаарх ойлголтыг семинарын дөрвөн жилийн турш мөн институтийн жилүүдэд ч үргэлжлүүлэн авах болно.



*Тэмдэглэл*

# 3

# Шашны семинар ба институтэд судруудаас заах нь

Өсвөр үеийнхэн болон залуу насанд хүрэгсэдэд заасан зүйлс Есүс Христийн Цагаатгалыг ойлгож, үүнд итгэж найдахад нь туслахын тулд семинар, институтийн багш нар сайн мэдээний сургаал ба зарчмуудыг сударт байгаа чигээр нь заах үүрэгтэй байдаг. Энэ үүргийг биелүүлэхийн тулд С ба И-ийн удирдлагаас семинар ба институтийн хичээлд ном болон судрын бүлгүүдээс заахдаа жишиг бүтээлүүдэд байгаа дэс дарааллаар нь заах нь зүйтэй хэмээн үзсэн байна. Энэ нь шүлэг бүр яг дэс дараалларaa заагдах ёстой гэсэн үг биш ч хичээл бүр ерөнхийдөө түүхийн дараалаар эсвэл шүлгийнхээ дараалаар заагдах хэрэгтэй юм. Судраас ийм аргаар судлах нь сүнслэгээр өдөөгдөн бичсэн зохиогчийн санааг бүрэн дүүрэн ойлгох үндэс болж, сайн мэдээний сургаал ба зарчмуудыг судрын бичвэрт дүрсэлсэн байдлаар нь судлах боломжийг олгодог.

Судраас дэс дараалалтайгаар судлах нь:

- Багш, суралцагсад сайн мэдээний үнэнүүдийг судар дахь бусад хэсгээс суралцаж болохоос гадна нэг нэгэнтэйгээ хамтдаа судлах боломжийг олгодог. Энэ нь багш суралцагсдыг судрууд дахь сүнслэг захиасуудыг тодоор харж, ойлгох боломжийг өгдөг.
- Сайн мэдээний сургаал ба зарчмуудыг судрат байгаагаар нь онцлон тэмдэглэх, давтан ашиглах боломжийг өгдөг.
- Багш, суралцагсдыг “шалтгаан-ба-үр дагавар” харилцааг илүү амархан таньж мэдэхэд тусалдаг.
- Хичээл дээр сайн мэдээний олон зарчмыг нэг бүрчлэн ярилцаагүй байсан ч, суралцагсдад тэдгээрийг нээж олон ойлгоход нь туслах. Эдгээр үнэнийг Ариун Сүнсээр илрүүлж болох ба суралцагч тус бүрийн онцлогт тохируулж болно.
- Багш суралцагсад сайн мэдээний сургаал ба зарчмуудыг тухайн нөхцөл байдалд амьдарч байсан хүмүүсийн амьдрал болон туршлага дээр тулгуурлан судалж ярилцах боломжийг олгодог. Энэ нь суралцагсдад сургаал ба зарчмуудыг амьдралынхаа нөхцөл байдалд тохируулан ойлгоход тусална.
- Сүмийн жишиг бүтээл бүрийг зохих түвшинд мэддэг болоход тусалдаг.



Ахлагч Дэвид А.Беднар бидэнд заахдаа судруудыг: "Эхнээс нь дуустал уншиx нь чухал түүх, сайн мэдээний сургаал ба хэзээ ч хуучиршгүй зарчмуудыг тэтгэх амьд усыг бидний амьдралд цутгах мэт юм. Энэ нь бидэнд судрын чухал баатруудын тухай мөн давтамж, болсон цаг үе, үйл явдал, сургаалын нөхцөл байдал, заасан зүйлсийг суралцахад дөхөм болдог. Сударт бичигдсэн үгсийг ингэж унших нь бидэнд судрыг нээж өгдөг. Энэ бол амьд усыг олох хамгийн чухал арга зам юм" гэжээ ("A Reservoir of Living Water" залуу насанд хүрэгчдэд зориулсан СБС-ийн галын дэргэдэх ярилцлага 2007 оны 2-р сарын 4, 2).

Тэмдэглэл

## Сайн мэдээг заах ба судлах үндсийг хэрэгжүүлэх нь [3.1]

Семинар, институтийн судар дээр тулгуурлан явагддаг хичээл бүр нь ямар нэг үзэл баримтлал, сургаал эсвэл зарчим дээр төвлөрөхөөс илүү судрын хэсэгт төвлөрсөн байдаг. Сургалтын материал нь судруудыг эдгээр хэсгүүдэд хуваадаг бөгөөд эдгээр нь нэг бүлэг (буюу нэг хэсэг) эсвэл бүр бүхэл бүтэн нэг судар ч байж болдог. Ихэнх судрын хэсгүүд нь үйл явдал буюу сэдвийг өөрчилдөг тусгаарлагч хэсгүүдтэй байдаг. Эдгээр өөрчлөлтөөс үндэслэн судрын хэсэг нь жижиг хэсгүүд буюу хэсэг шүлгүүдэд хуваагддаг. Бүхэл бүтэн судрыг жижиг хэсгүүд болгон зохион байгуулснаар сүнслэгээр өдөөгдөн бичсэн зохиогчийн захиасыг ойлгох ба заах үндсэн суурь нь болдог.



Багш суралцагсад эдгээр дараалсан судрын хэсгийг судалснаар сайн мэдээг заах ба судлах үндсүүдийг хэрэгжүүлж байдаг. Судрын нөхцөл байдал, агуулгыг ойлгож, сайн мэдээний сургаал ба зарчмуудыг хэрэгжүүлэхийн чухал хийгээд эдгээрийн үнэн болохыг таньж, ойлгон, мэдрэх зэрэг сайн мэдээг заах ба судлах үндсүүд нь арга барил биш харин хүрч болох үр дүн юм. Эдгээр үндсүүд нь бие биетэйгээ харилцан уялддаг бөгөөд багш, суралцагсад сайн мэдээгээр өөрсдийн оюун бодол, зүрх сэтгэлийг дүүргэх үндсэн арга замыг бий болгодог. Энэхүү арга замыг дараах байдлаар дүрсэлсэн байдаг:

1. **Нөхцөл байдал ба агуулгыг ойлгох.** Суралцагсдад судрын хэсгийн нөхцөл байдал ба агуулгыг ойлгоход туслах нь судраас заах үйл явцын хамгийн чухал алхам юм. Түүх болон түүхийн нөхцөл байдлыг ойлгох нь сайн мэдээний зарчим ба сургаалуудыг нээж олох үндсийг тавьж мөн судрын хэсгээс олсон тэдгээр үнэнийг тодотгож, тайлбарлаж өгдөг. Судрын нэг буюу хоёр шүлгийг сонгон авч заах нь энэхүү үндэснээс олж авах тодорхой бөгөөд гүн ойлголтыг үгүй болгодог.

2. **Сургаал ба зарчмуудыг тодорхойлох.** Судруудын агуулгыг ойлгох нь багш болон суралцагсдыг судрын хэсэгт байдаг сургаал ба зарчмуудыг таньж мэдэхэд бэлддэг. Зарим тохиолдолд судрын зохиогч нь өөрийн хүргэх гэж хүссэн сургаал ба зарчмыг шууд илэрхийлсэн байдаг. Харин заримдаа эдгээр үнэнийг судрын бичвэрт далд утгатайгаар бичсэн байдаг. Энэ нь сайн мэдээний сургаалыг энгийн үнэн үгээр илэрхийлэх шаардлагыг бий болгодог.

*Тэмдэглэл*

**3. Тэдгээр сургаал ба зарчмын утга санааг ойлгох нь.** Багш, суралцагсад сургаал ба зарчмуудыг таньж мэдсэнийхээ дараа тэдгээрийн утга санааг хэлэлцэн илүү сайн ойлголт авахын тулд хичээх ёстой. Ихэнхдээ судрын хэсэг нь өөртөө сургаал ба зарчмын утгыг ойлгоход нь суралцагсдад туслах тайлбарыг агуулсан байдаг. Мөн судрын нөхцөл байдлыг орчин цагтай харьцуулах нь суралцагсдад сургаал ба зарчмууд тэдний амьдралд ямар утгатай болохыг илүү сайн ойлгоход тусалдаг. Сургаал эсвэл зарчмыг ойлгох ойлголт өсч хөгжих үед суралцагсад сайн мэдээний үнэний тухай бусдад тайлбарласнаар өөрсдийнхөө ойлголтыг хүчирхэгжүүлдэг юм.

**4. Сургаал буюу зарчмын чухал хийгээд үнэн болохыг Сүнсний нөлөөгөөр дамжуулан мэдрэх нь.** Сургаал буюу зарчмын талаарх тодорхой ойлголт нь суралцагсдыг эдгээрийн үнэн хийгээд чухал гэдгийг мэдрэхэд бэлддэг. Сургаал буюу зарчмын үнэн хийгээд чухал болохыг Сүнсний нөлөөгөөр мэдэрсэн суралцагсад тэрхүү үнэнийг амьдралдаа хэрэгжүүлэх хүсэлтэй болдог. Багш нар суралцагсдынхаа эдгээр Сүнслэг мэдрэмжийг нь тэтгэхийн тулд тэдэнд сайн мэдээний зарчмаар амьдарсан туршлагаасаа хуваалцаж мөн үүний үнэн гэдгийг гэрчлэх боломжийг олгох хэрэгтэй. Багш нар өөрсдийн гэрчлэл болон туршлагаасаа хуваалцаж болно. Судрын олон зохиогч заалгасан сургаал буюу зарчмынхаа талаар гэрчлэлээ хуваалцсан байдаг. Багш, суралцагч нар судрын хэсгээс эдгээр гэрчлэлийг агуулсан шүлгүүдийг эрж хайх ёстой.

**5. Сургаал ба зарчмуудыг хэрэгжүүлэх.** Сургаал буюу зарчмын үнэн хийгээд чухал гэдгийг мэдрэх нь суралцагсдад үүнийг амьдралдаа хэрэгжүүлэх үүд хаалгыг нээдэг. Сайн мэдээний зарчмуудыг хэрэгжүүлэх үйл явц нь ихэвчлэн ангиас гадуур болдог ч үр дүнтэй аргаар сурч байгаа зүйлсээ хэрэгжүүлэх хүсэл ба чадварыг өсгөх чухал үйл явдлууд ангид өрнөж болдог. Багш нар суралцагсдад өөрийн нөхцөл байдлын тухай тунгаан бодож, сургаал буюу зарчмыг хэрэгжүүлэх тодорхой арга замыг олох боломжийг гаргаж өгч болно. Суралцагсдад зарчмыг өөрийн амьдралд тохируулан хэрэгжүүлэх тухай тунгаан бодох цаг гаргаж өгвөл Сүнс тэдний оюун бодолд удирдамж өгч чадна. Тохиромжтой бол багш нар тухайн зарчмыг хэрэгжүүлэх санаануудаас хуваалцахыг суралцагсдаас хүсч болно.

Энэхүү чухал аргыг багш суралцагсад судрын хэсэг дэх хэсэг шүлэг бүрийг судлахдаа хичээлийн туршид эсвэл хичээлийн нэг хэсгийн турш давтан хийдэг.

Судрын хэсгийн зарим хэсгийг хичээлийн дундуур онцлон ярьдаг бөгөөд бусдад нь арай бага анхаарал хандуулдаг. Учир нь тэдгээр хэсэг нь сүнслэгээр өдөөгдсөн зохиогчийн захиаст тийм чухал үүрэгтэй биш байдаг эсвэл суралцагсдын хэрэгцээнд нэг их чухал биш байдаг. Судрын зарим хэсгийн хувьд агуулга ба нөхцөл байдал, сайн мэдээний зарчим сургаалуудыг олж нээх багш нар нь суралцагсдаа зарчмуудыг хэрэгжүүлэхийг эрэлхийлэх ба үүний үнэн бас чухал гэдгийг ойлгож, мэдрэхэд туслах үйл явцыг удирдан чиглүүлэхэд ихэнх цаг болон хүчин чармайлтаа тавих хэрэгтэй байдаг.

Тэмдэглэл

Бусад тохиолдолд судрын хэсгийн дараагийн түүх рүү шилжихийн өмнө зааж буй сайн мэдээний зарчим, сургаалын түүхийн нөхцөл байдал ба агуулгыг хангалттай судалж, ойлгосон байх шаардлагатай байдаг. Багш эсвэл суралцагсад судалж байгаа судрат нь сургаал буюу зарчим гарч ирэхэд нэг их цаг зарцуулалгүй товчхон дурдаад өнгөрөхөд энэ нь Ариун Сүнсэнд сайн мэдээний үнэнийг заах боломжийг олгож, суралцагч бүрт сайн мэдээг өөрийн хэрэгцээнд тохируулах боломжийг олгодог.

Харин зарим түүхийн хувьд багш, суралцагсад хамтдаа агуулга ба нөхцөл байдлыг судалж эсвэл багш уг түүхийг товчлон өгүүлээд дараагийн бүлэг шүлэг рүү шилжиж болно. *Товчлон өгүүлэх* гэдэг нь ангид онцолж ярилцаагүй бүлгүүд эсвэл шүлгүүдийн агуулгыг товч дурдахыг хэлнэ. Товчлон өгүүлэх нь багш нарыг судрын хэсгийг хурдан заахад тусалдаг. Судрын хэсгүүдийг үл тоомсорлон орхигдуулахын оронд товчхон өгүүлэх нь багш, суралцагсдад түүх болон агуулгыг санаж байхад нь тусалж мөн хожим нь судрын хэсэгт гарах сургаал буюу зарчмуудыг олж нээн, ойлгох үндсийг тавьдаг. Товчлон өгүүлэх нь мөн сүнслэгээр өдөөгдөн бичсэн зохиогчийн захиасын үнэнийг хадгалж үлдэхэд тусалдаг юм.

Багш суралцагсад судрын хэсгийн хэсэг бүрийг дэс дараалалтайгаар судалснаар нэг хэсэг шүлэг нь бусадтайгаа хэрхэн холбогдож байгааг илүү сайн ойлгодог. Судрын хэд хэдэн хэсгүүдийн хоорондын харилцаа холбоог харах нь багш суралцагсдад тухайн сургаал ба зарчмуудыг илүү гүн гүнзгий ойлгоход туслаад зогсохгүй судруудад юу заадаг болохыг илүү өргөн цар хүрээтэйгээр харахад тусалдаг юм.



*Тэмдэглэл*

## Лук 5: Жишээ [3.2]

Дараах жишээнд багш нар судрын хэсгийг “сайн мэдээг заах ба судлах үндсүүдтэй” хэрхэн холбон зааж болохыг үзүүлнэ.

Энэхүү жишээнд судрын хэсэг Лук 5-р бүлгийг түүх буюу сэдэв дэх өөрчлөлтийг нь үндэслэн жижиг хэсгүүдэд хуваах болохыг харуулсан байна:

| | |
|---|---|
| Лук 5:1–11 | Гайхамшигтайгаар маш их хэмжээний загас барьсныхаа дараа Петр, Иохан, Иаков нар хүмүүсийг загасчлахаар Их Эзэнээр дуудагдав. |
| Лук 5:12–26 | Есүс хэд хэдэн өвчтэй хүмүүсийг эдгээж, нүглийг нь өршөөв. |
| Лук 5:27–35 | Есүс татвар хураагчид болон нүгэлтнүүдтэй хоолосон нь Фарисайчууд, хуулийн багш нар Түүнээс асуулт асуухад хүргэжээ. |
| Лук 5:36–39 | Есүс хуучин тулман дахь шинэ дарсны тухай сургаалт зүйрлэл хэлэв. |

Энэхүү жишээ болгосон хичээлийн хэсэг бүрийн үйл явцыг дүрслэхэд дараах графикийг ашиглана. Энэ нь багшийн холбохоор төлөвлөж байгаа хэсэг шүлэг бүр дэх “сайн мэдээг заах ба судлах үндсүүдийг” харуулсан болно.



## 1-11-р шүлэг

### Гайхамшигтайгаар маш их хэмжээний загас барьсныхаа дараа Петр, Иохан, Иаков нар хүмүүсийг загасчлахаар Их Эзэнээр дуудагдав.

Тэмдэглэл

Багш **Лук 5:1–11**-н нөхцөл байдал ба агуулгыг ойлгоход нь суралцагсдад тусалснаар эхэлж болох юм. Эдгээр шүлгийг судалж байгаа суралцагсад Есүс Петрт "усны гүн уруу нь очоод тороо хаяад барь" хэмээн хэлснийг унших болно (4-р шүлэг). Тэд мөн Петр шөнөжингөө загас барих гэж зүдрээд "юу ч барьсангүй" (5-р шүлэг) харин Их Эзэний үгийг дагаад маш их хэмжээний загас барьж ихэд гайхширдагийг уншина. Суралцагсад Петрийн туршлагаас "бид учрыг нь сайн ойлгохгүй байсан ч Их Эзэний хүссэн зүйлийг хийх аваас Тэрээр бидний хүлээж байснаас ч илүү их адислалуудыг бидэнд өгөх болно" гэсэн **зарчмыг сурч чадна.** Үүний дараа багш нар суралцагсдыг **энэхүү зарчмыг илүү сайн ойлгоход** нь тусалж мөн Петрт тохиолдсон зүйл тэдний амьдралын ямар нөхцөл байдалтай ижил төстэй байж болох талаар ярилцаж эсвэл үүнтэй холбоотой хожмын үеийн бошиглогч буюу төлөөлөгчийн хэлсэн үгсээс хуваалцаж болно.

Эдгээр шүлгийн хувьд, багшийн хүсэл бол суралцагсдад энэхүү чухал зарчмыг таньж мэдэн, ойлгоход нь туслахаас гадна **үүний үнэн хийгээд чухал болохыг** Сүнсний нөлөөгөөр мэдрэхэд нь туслах юм. Үүнийг хийхийн тулд багш суралцагсдаас шалтгааныг нь сайн ойлгоогүй ч Их Эзэний удирдамжийг дагаснаар адислагдсан тухайгаа хуваалцахыг хүсч болох юм. Багш, суралцагсад энэхүү зарчмын тухай гэрчлэлээ хуваалцах үед Сүнс үүнийг үнэн гэдгийг гэрчилж, тэднийг үйлдэхэд сүнслэгээр өдөөж чадна. Үүний дараа багш суралцагсдад энэхүү зарчмыг хэрхэн **хэрэгжүүлэх** тухай эргэцүүлэн бодож, дэвтэртээ бичих хэдэн хором олгох хэрэгтэй.

График дээр шүлгүүдийн энэ хэсэгт сайн мэдээг заах ба судлах чухам ямар үндсүүдийг хэрэгжүүлснийг харуулсан байна.



*Тэмдэглэл*

## 12-26-р шүлэг

### Есүс хэд хэдэн өвчтэй хүмүүсийг эдгээж, нүглүүдийг нь өршөөв.

Суралцагсдад эдгээр шүлгийн **агуулгыг нь ойлгоход** нь туслахын тулд багш тэднийг эхлээд Их Эзэн уяман болон саа өвчтэй хүмүүсийг эдгээж байгаа тухай түүхийг мэддэг болгох хэрэгтэй. Агуулгыг нь илүү сайн ойлгуулахын тулд багш дээрх хоёр эдгээсэн түүх нь юугаараа ижил төстэй, юугаараа ялгаатайг дүгнэхийг суралцагсдаас хүсч болно. Суралцагсдад дүгнэлт гаргахад нь туслахын тулд багш эдгээр түүхэнд итгэл ямар үүрэгтэй байсныг бодохыг хүсч болно. Хоёр тохиолдолд хоёуланд нь итгэл чухал байсныг олж мэдсэнээр суралцагсад "бид итгэлээ хөгжүүлж, Аврагч руу ирэхэд Тэр биднийг эдгээж чаддаг" гэсэн **зарчмыг сурч чадна.** Хоёр түүхийн ялгаануудыг дүгнэснээр суралцагсад уяман өвчтэй хүн өөрөө Их Эзэн рүү ирж чадсан харин саа өвчтэй хүн Их Эзэн рүү ирэхэд бусдын тусламж хэрэгтэй байсан гэдгийг анзаарах болно. Үүнээс суралцагсад *бид бусдыг Аврагч руу очиж эдгэрэхэд нь тусалж чадна* гэсэн өөр нэгэн зарчмыг сурч болно.

Багш **эдгээр зарчмыг ойлгоход нь** суралцагсдад туслахын тулд "хүний бие махбодоос гадна өөр юуг нь эдгээж болох вэ?" гэж асууж болно. Ингэж ярилцсанаар эдгээр шүлэгт өгүүлсэн бие махбодын эдгээлт нь бидний сүнслэг байдлыг эдгээж чадах Их Эзэний чадварыг мөн дүрсэлж байгаа гэдгийг ойлгоход нь суралцагсдад тусалж чадна. Үүнд мөн бидний нүглийг уучлах, гашуудаж байхад тайвшруулах эсвэл биднийг айж, санаа зовсон үед тайвшруулах зэрэг багтана.

Суралцагсдыг **эдгээр зарчмын үнэн хийгээд чухал гэдгийг мэдрэхэд нь** туслахын тулд багш суралцагсдаас өөрсдийнхөө эсвэл тэдний мэдэх хэн нэгний бие махбодын буюу сүнслэгээр эдгэрсэн туршлагаас хуваалцахыг хүсч болно. Суралцагсдаас хэн нэгнийг Их Эзэнд хүргэж Аврагчийн эдгээх нөлөөг хүлээж авахад нь тусалсан хүнийг харж байсан



тухайгаа хуваалцахыг хүсч болно. (Иймэрхүү жишээ хуваалцахдаа хүмүүсийнх нь нэрийг хэлж болохгүй гэдгийг суралцагсдад сануулах хэрэгтэй.) Багш суралцагсдаас Аврагчийн хайр ба биднийг эдгээх Түүний хүч чадлын тухай гэрчлэхийг хүсч болох юм.

Үүнийг **хэрэгжүүлэхэд нь** дэмжихийн тулд багш итгэлээр эдгээх, уучлах, тайвшруулах аль эсвэл найзаа буюу хэн нэгнийг Аврагч руу авчрах зэрэг өөрийн хийж болох итгэлийн үйлдлийн тухай бодоход нь тэдэнд тусал.

27-35-р шүлгийг зааж эхлэхээсээ өмнө багш үзсэн шүлгүүдээс юу сурч авсан болохыг нь суралцагсдаас асууж болно. Хариултууд нь талархах сэтгэл төрүүлж мөн Аврагчийн өрөвч нинжин сэтгэлийг таньж мэдэхэд тусална.

## 27-35-р шүлэг

### Есүс татвар хураагчид болон нүгэлтнүүдтэй хооллосон нь Фарисайчууд, хуулийн багш нар Түүнээс асуулт асуухад хүргэжээ.

Энэ хэсэгт багш зөвхөн нөхцөл байдал ба агуулгыг нь **ойлгоход суралцагсдад туслахаар төлөвлөнө.** Суралцагсад эдгээр шүлгийг судалснаар татвар хураагч Леви, Матай нарын дуудлагын тухай, Есүс татвар хураагчид ба нүгэлтнүүдтэй хооллосон тухай сурдаг (агуулга). Багш суралцагсдад тухайн үед татвар хураагчдыг Иудейчүүд харийнхан буюу нүгэлтнүүд хэмээн үздэг байсныг (нөхцөл байдал) ойлгоход нь туслах хэрэгтэй. Энэ нөхцөл байдал нь суралцагсдыг Матайн ирээдүйн дуудлага (Их Эзэний шавь) ямар онцгой байсныг ойлгоход нь туслах болно. Энэ нь эдгээр шүлэгт гарч байгаа Фарисайчууд ба Их Эзэний хооронд болсон яриаг илүү гүн гүнзгий утга агуулгатай болгодог. Тэд Түүний “татвар хураагчид болон нүгэлтнүүдийн хамт идэж, ууж” байгааг мөн нүгэлтнүүдийг наманчлахад нь туслах Түүний зорилгын тухай ярилцдаг юм (30–32-р шүлгийг үзнэ үү).




Тэмдэглэл

*Тэмдэглэл*

## 36-39-р шүлэг

### Есүс хуучин тулман дахь шинэ дарсны тухай сургаалт зүйрлэл хэлэв.

Суралцагсдад энэхүү сургаалт зүйрлэлийн **нөхцөл байдал ба агуулгыг** ойлгоход нь туслахын тулд багш 37-р шүлгийн мөрийн тайлбарыг хэлж өгнө (тулам гэдэг нь арьсан уут буюу дарс хийдэг арьсан уут гэдгийг тайлбарласан байгаа). Мөн шинэ арьс нь зөөлөн, сунамтгай харин хуучин арьс нь хатуу бөгөөд урагдах нь амархан байдаг зэрэг ялгааг нь ярилц. Тэгээд багш Есүс Фарисайчуудтай ярилцаж байсан тухай (нөхцөл байдал) мөн энэхүү сургаалт зүйрлэлд “хуучин дээл” ба “хуучин тулам” -аар Христийн сургаалыг хүлээн авдаггүй, өөрчлөгдөх хүсэлгүй Фарисайчуудыг дүрсэлсэн болохыг тайлбарлаж өгнө. Багш “шинэ дээл” ба “шинэ тулам”-аар Аврагч болон Түүний заасан зүйлсийг хүлээн авч, өөрчлөгдөх хүсэлтэй хүмүүсийг дүрсэлсэн гэдгийг онцлон хэлнэ.

Үүний дараа багш суралцагсдаас энэхүү сургаалт зүйрлэлд гарч буй **зарчмыг олохыг** хүсч болно. Суралцагсдын олж болох нэг үнэн бол: *Аврагч болон Түүний сайн мэдээг хүлээн авахын тулд бид даруу төлөв мөн өөрчлөгдөх хүсэлтэй байх ёстой.* Үүний дараа багш суралцагсдыг уг бүлгийг нягтлан үзэж, Аврагч ба Түүний заасан зүйлсийн эсрэг зүрх сэтгэлээ хатууруулж, зөрүүд байсан хүмүүс болон даруу төлөв, өөрчлөгдөх хүсэлтэй байсан хүмүүсийн жишээнүүдийг хайж олохыг хүсч болно. Энэхүү үйл ажиллагаа нь суралцагсдыг **уг зарчмыг илүү сайн ойлгоход** тусална.

Багш хичээлээ төгсгөхдөө суралцагсдаас Лук 5-г судлах явцад төрсөн сэтгэгдлээ эсвэл өөрийнхөө санаа бодлоос хуваалцахыг хүсч болно. Багш заасан зүйлсийнхээ үнэн болохыг гэрчилж мөн олж нээсэн сургаал ба зарчмуудынхаа дагуу үйлдэхэд нь суралцагсдыг урамшуулан дэмжинэ.



# Заахын тулд бэлтгэх нь

4

## Хувийн бэлтгэл [4.1]

Ахлагч Боид К.Пакер: “Зөвхөн нэг хичээлд бэлтгэхэд бус харин өөрийн амьдралыг тэр чигээр нь Сүнстэй нийцүүлэхийн тулд багш чадах бүхнээ хийснээр хүч чадлыг авдаг. Хэрэв тэрээр Сүнсний нөлөөнд найдаж судлах аваас сүнслэгээр зааж чадна гэдэг баттай мэдлэгтэйгээр самбарынхаа өмнө гарах болно” хэмээн хэлсэн (*Teach Ye Diligently,* хэвлэл. [1991], 358–359).

Сайн мэдээний багшийн бэлтгэх хамгийн чухал үндсэн хэсэг бол багш өөрийгөө сүнслэгээр бэлтгэх явдал мөн. Сайн мэдээний дагуу амьдрах, удирдамж ба тусламж авахын төлөө залбирах, итгэлээр үйлдэх ба сургалтанд хамрагдах зэрэг нь бэлтгэлийн чухал хэсэг мөн.

### Сайн мэдээгээр амьдрах [4.1.1]

Багш нар сайн мэдээний дагуу хэр итгэлтэйгээр амьдарч байгаа нь тэднийг хичээлээ заахад бүх талаар нөлөөлдөг. Ариун Сүнсний нөхөрлөлийг олж, бусдыг удирдан чиглүүлэх зохистой амьдралаар амьдрахаас илүү агуу бэлтгэл гэж үгүй (1.2, “Амьдрах” хэсгийг үзнэ үү).

### Тусламж ба удирдамж авахын тулд залбирах [4.1.2]

Заахаар бэлтгэхэд залбирал хамгийн чухал нь юм (С ба Г 42:14; 104:79, 82-г үзнэ үү). Багш сайн мэдээний зарчмууд ба судруудыг ойлгохын тулд, тэдгээр зарчмыг Сүнсээр хэрхэн хамгийн сайн заах мэргэн ухааны төлөө, хичээл бүрийн эхэнд тусламж ба удирдамж хүсч мөн суралцагсад нь Сүнсээр заалгаж, мэдрэх хүсэлтэй байхын тулд Сүнснээс тусламж хүсэн залбирч болно. Багш нар суралцагч бүрээ илүү сайн ойлгохын тулд танин мэдэх бэлгийг хүлээн авч, судлахын төлөө чармайж байгаа суралцагч нэг бүрт хүрч ажиллахын төлөө мөн хайрлахад хэцүү санагддаг суралцагсдаа хайрлах энэрэлтэй байхын төлөө Их Эзэнээс гуйж болно. (Моронай 7:48-г үзнэ үү).

### Итгэлээ хөгжүүлэх [4.1.3]

С ба И-ийн зорилгын “заах” гэдэг хэсэгт сайн багш бол Бурханы үгийн хүчинд итгэж найддаг, Их Эзэн ба Ариун Сүнсэнд итгэдэг мөн суралцагсаддаа итгэдэг гэж тодорхойлсон байдаг. Багшийн амжилттай зааж чаддаггүй шалтгаан нь ихэвчлэн эдгээрийн аль нэг нь дутагдсанаас болсон байдаг.

**Үгийн хүч чадалд итгэх нь.** Багш нар заримдаа суралцагсад судраас судлахдаа тийм дуртай биш байх болов уу эсвэл өдөр бүр судраас сонирхолтойгоор



Тэмдэглэл

заах нь хэцүү гэж бодож байж магадгүй юм. Гэхдээ багш нар судрууд нь “амьдралын үгсийг” агуулдаг (С ба Г 84:85) бөгөөд үг нь хүмүүний оюун ухаанд “илднээс эсвээс юунаас ч илүү хүчтэй” гэдгийг санах ёстой (Алма 31:5).

Ахлагч Хенри Б.Айринг хэлэхдээ: “Би таны бас суралцагсдын тань төлөө тэднийг судруудаа унших хүсэлтэй байна гэдэгт нь итгэлтэй байхыг гуйж байна. Та тэднийг судрууд руу хөтлөх бус харин судрууд тэднийг татах ёстой. . . . Их Эзэн ном бичсэн. Тэрээр Нифайд та нарыг татах аргаар яаж ном бичихийг заасан. Энэ нь та нарын суралцагсдыг татах болно” гэсэн (“The Book of Mormon Will Change Your Life” Мормоны Номын талаарх СБС-н симпозиум, 1990 оны 8-сарын 17, 2).

**Их Эзэн ба Сүнсэнд итгэх итгэл.** Өсвөр үеийнхэн болон залуу насанд хүрэгсдэд сайн мэдээний зарчмуудыг заах үүрэг хариуцлага нь хэцүү бас даах давшгүй мэт санагдаж болох юм. Гэхдээ энэ бол Их Эзэний ажил бөгөөд Түүнд итгэлтэйгээр хандсан тэдгээрт Тэрээр туслах болно. “Мөн Христ хэлдэг: “Хэрэв та нар надад итгэлтэй байх аваас та нар миний хувьд шаардлагатай болох аливаа зүйлийг хийх хүчтэй байх болно” (Моронай 7:33) гэж Моронай заасан байдаг.

Их Эзэн суралцагч бүрийн хэрэгцээг мэддэг бөгөөд тэднийг адислахыг хүсдэг гэдэгт багш нар итгэх ёстой. Багш нар Ариун Сүнс сайн мэдээний захиасыг суралцагч бүрт хүргэж мөн тэдний нөхцөл байдал, хэрэгцээний дагуу сайн мэдээг хэрэгжүүлэхэд нь өдөөх болно гэдэгт итгэх хэрэгтэй. Сүнс бол “үнэнийг заахаар урагш илгээгдсэн Тайтгаруулагч” гэдгийг багш нар санаж байх ёстой (С ба Г 50:14).



**Суралцагсаддаа итгэх нь.** Багш нар зөв удирдамж, дэмжлэгээр суралцагсад нь судруудыг ойлгож, сургаал ба зарчмуудыг ялган таньж, бусдад сайн мэдээг тайлбарлаж, амьдралдаа хэрэгжүүлж чадна гэдэгт нь итгэх ёстой. Ерөнхийлөгч Бага Ж.Рубен Кларк семинар ба институтийн суралцагсдын зан чанаруудыг ийн тодорхойлсон байдаг:

“Сүмийн өсвөр үеийнхэн Сүнслэг зүйлсийг судлахад бэлэн байдаг бөгөөд тэд сайн мэдээг судлах хүсэлтэй, цэвэр бас хүч чадлаар дүүрэн байдаг. . . .

. . .Та сүнслэг байдлыг мэдэрсэн энэ суралцагчийн араас гэтэн очиж шашны тухай чихэнд нь шивнэх шаардлагагүй харин урдаас нь чиглэн очоод, нүүр нүүрээрээ хараад түүнтэй ярилц. Танд шашны үнэнүүдийг дэлхийн зүйлсээр нууж хаах шаардлага байхгүй; та эдгээр үнэнийг түүнд нээлттэйгээр хүргэж болно” (*The Charted Course of the Church in Education,* хэвлэлт. 1994, 9).

Заримдаа сайн мэдээнээс суралцаж байгаа суралцагсдын байгаа байдал, зан авир, хариулт зэрэг нь “Сүнслэг зүйлсийн төлөө цангаж” байгаа мэт санагдахгүй байж болно. Ийм үед ялангуяа Ерөнхийлөгч Кларкийн заасан зүйлд итгэлтэй байх нь багш нарын хувьд маш чухал юм. Ахлагч Хенри Б.Айринг дараах амлалтыг өгсөн: “Манай суралцагсад өөрсдийгөө өлсгөлөнгөөс аврагдаж байгаагаа мэдэхгүй байж магадгүй юм. Гэхдээ Бурханы үг тэдний өөрсдөө ч мэдээгүй байгаа тэрхүү цангааг нь тайлж, Ариун Сүнс тэр усыг нь тэдний зүрх сэтгэлд аваачих болно”

("We Must Raise Our Sights" Мормоны Номын талаарх СБС-ийн чуулган, 2001 оны 8-р сарын 14, 3).

Үгсийн хүч чадалд, Их Эзэн ба Ариун Сүнсэнд мөн суралцагсаддаа итгэх итгэлээ хөгжүүлэн С ба И-ийн зорилгыг биелүүлэхийг эрэлхийлж байгаа багш нар өөрсдөөсөө үргэлж ийн асууж байх ёстой:

Миний заах арга барил:

1. Бурханы үгийг ойлгох ойлголтыг мөн үүнийг хайрлах хайрыг ихэсгэх хүслийг өдөөж байна уу?
2. Ариун Сүнсийг урьж мөн сэнхрүүлж байна уу?
3. Суралцагч бүрийг бие даан судлахад мөн сайн мэдээнд итгэж амьдрахад нь дэмжиж байна уу?
4. Есүс Христийг илүү сайн мэдэж, хайрлаж, дагахад нь суралцагсдад маань тусалж байна уу?

Тэмдэглэл

### Сургалтанд хамрагдах [4.1.4]

Семинар ба институтээс бүх багш, удирдагч нартаа зориулж сургалт явуулдаг. Энэхүү сургалт нь ерөнхийдөө заах арга барилыг сайжруулж, сайн мэдээний мэдлэгийг тэлж мөн багш нарт семинар ба институтийг хэрхэн удирдахыг судлахад нь туслах зорилготой байдаг.

Энэхүү сургалтын нэг хэсэг нь албан ёсны хурал байдаг. Сургалтын хурлууд нь тогтмол явагддаг бөгөөд үүнд багш, удирдагчид оролцох үүрэгтэй. Эдгээр хурлаар оролцогч нар судраас сурч, ярилцан судрын тухай ойлголтоо гүнзгийрүүлдэг юм. Тэд заах сүнслэг арга барилуудыг сурч, дадлага хийдэг. Тэд суралцагсдын бүртгэл, оролцоо болон төгсөлтийн тухай санал бодлоо солилцож, одоогийн хэрэгцээ шаардлагын талаар хамтдаа зөвлөлдөж мөн удирдах үүрэг хариуцлагыг хэрхэн гүйцэтгэх талаар суралцдаг.

Ангиудаар зочилж, ажиглалт хийх нь сургалтын бас нэг хэсэг юм. Багш нар зохицуулагч, удирдагч болон бусад багш нарыг хичээлдээ урьснаар тустай санал зөвлөгөөг тэднээс хүлээн авч чадна. Ажиглагчаас багш өөрийн судлахаар хичээж буй арга барилынхаа талаар санал зөвлөгөө өгөхийг хүсдэг. Бусад багш нарыг ажиглаж хичээлд нь суух нь багш нарт тустай байдаг.

Сургалтанд суухдаа итгэлтэй мөн сурч, өсч хөгжих чинхүү хүсэлтэйгээр ирдэг тэдгээр нь өсч хөгжин, сайжирдаг.

## Суралцагчийн бэлтгэл [4.2]

Судруудад бэлэн байдал буюу зүрх сэтгэл, оюун бодолдоо сүнслэгээр суралцахыг эрэлхийлэх тэдгээрийн бэлэн байдлын тухай өгүүлдэг. Жишээлбэл Хуучин Гэрээнд гардаг тахилч, гүүш Езра "Эзэний хуулийг сурч, түүнийг хэрэгжүүлэхэд зүрхээ зориулсан" байлаа (Езра 7:10). Үйлс номонд итгэлтэй Гэгээнтнүүдийг "тэд үгийг дуртайяа хүлээн авсан" хэмээн дүрсэлсэн байдаг (Үйлс 17:11). Аврагч Нифайчууд дээр айлчлахдаа



Тэмдэглэл

"маргаашийн төлөө оюун санаагаа бэлтгэ, би та нарт дахин ирэх болно" хэмээн тэдэнд урам зориг өгчээ (3 Нифай 17:3).

Суралцаж байх үедээ суралцагсад Ариун Сүнсний мэдлэг олгох нөлөөг мэдрэхийн тулд "үгийг сонсоход бэлтгэгдсэн байх" хэрэгтэй юм (Алма 32:6). Суралцагсад ангид байхдаа оюун санаагаа нээлттэй, анхаарлаа судлах үйл ажиллагаанд төвлөрүүлж мөн Сүнсээр заалгах хүсэлтэй байх аваас тэд судлахад бэлэн байна гэсэн үг юм. Суралцагсаддаа сайн мэдээг судлахдаа зүрх сэтгэл, оюун бодлоо бэлтгэхэд нь тусалж болох олон арга байдаг. Үүний заримаас нь доор өгөв:

**Суралцагсдынхаа төлөө залбирах.** Багш нар Их Эзэнээс суралцагсад дээрээ Сүнсийг асгаж "тэд үгийг баяртайгаар . . . хүлээн авахад тэдний зүрх сэтгэлийг бэлтгэхийг" гуйж болно (Алма 16:16–17).

**Хайр ба хүндлэлийн уур амьсгалыг бүрдүүлэх.** Багш болон бусад суралцагсдынхаа хайр, итгэлийг мэдэрдэг мөн түүнийг үнэлдэг гэдгийг мэддэг суралцагч ангидаа Сүнсний нөлөөнд илүү нээлттэй, хичээлд оролцох дүүрэн эрмэлзэлтэй ирдэг байна.

**Зорилготой байхад нь туслах.** Багш нар суралцагсдаа хичээлд ирэхдээ Тэнгэрлэг Эцэг болон Түүний Хүү Есүс Христийг таньж мэдэн, Түүний сайн мэдээг судраас мөн бошиглогчдын үгсээс байгаа чигээр нь судалж мөнхийн амьдралын төлөө урагшлахаар ирдэг гэдгээ ойлгоход нь тэдэнд туслах хэрэгтэй.

**Хичээлээ сонирхолтой, зохимжтой бас мэдлэг олгох аргаар заах.** Багш нар хичээлээ тогтмол мэдлэг олгохуйцаар заахад суралцагсад хичээлдээ ирэхдээ үнэ цэнэтэй ямар нэгэн зүйл сурна гэж хүсэн хүлээдэг болдог. Ахлагч Боид К.Пакер: "Та хичээл заахдаа ямар нэгэн зүйл заагаагүй бол суралцагсад дахин ирэхдээ сэтгэл нь хөдөлж ирэхгүй. Тэд хичээл дээр ямар нэгэн зүйл сурч байж эргэж ирэх хүсэлтэй болдог. Тэд шинэ зүйлс сурдаг хичээлд ирэхдээ хүсэлтэйгээр бүр маш их хүсэлтэйгээр ирэх болно" хэмээн заасан (*Teach Ye Diligently,* 182).

**Хичээл эхлэх үедээ Ариун Сүнсийг урь.** Сайн бэлтгэлтэй байж мөн залбирал, сүмийн дуулал, судраас хуваалцах зэрэг зүйлсийг багтаасан сүнслэг хэсгийг суралцагсдаар удирдуулан явуулж хичээлээ эхлэх нь Сүнсийг урьж, суралцагсдыг нэгдмэл болгож, тэдний оюун санаа, зүрх сэтгэлийг сүнслэг зүйл судлахад бэлддэг юм.

**Суралцагсдын анхаарлыг татах.** Багш нар хичээлээ эхлэхдээ суралцагсдынхаа анхаарлыг татаж мөн судруудаас зорилготойгоор эрж хайхад нь удирдан чиглүүлэх арга замаар хичээлээ эхлэх аваас тэдний оюун бодлыг сурах үйл явцад төвлөрүүлж чадна. Жишээлбэл багш самбар эсвэл үзүүлэн дээр ямар нэгэн зүйл тавих юм уу зураг өлгөх аргаар суралцагсдыг ангид орж ирэхэд нь анхаарлыг нь татаж болно.

Суралцагсдын анхаарлаа хандуулах хугацаа нь хязгаартай байдаг тул ухаалаг багш хичээлийн үед тэдний сонирхол, судлах хүслийг хэд хэдэн удаа өдөөж өгдөг юм. Үүнийг хийхдээ суралцагсдын анхаарлыг судруудыг судлахад төвлөрүүлэх аргаар хийдэг.

**Суралцагсдыг амжилттай суралцагч болоход бэлтгэ.** Суралцагсдыг хичээлд оролцохыг урихынхаа өмнө багш нар тэднээс юу хүсч байгаагаа тодорхой тайлбарлаж, жишээ өгч, тэдэнд бэлдэж, дадлага хийх цаг өгөн мөн сурах идэвх зүтгэлийг нь үнэлж, урам өгөх хэрэгтэй. Суралцагсдыг

сурах үүрэг хариуцлагаа биелүүлэхэд нь бэлтгэдэг багш нар семинар, институтийн зорилгыг илүү сайн биелүүлж чаддаг.

Тэмдэглэл

## Хичээлийн бэлтгэл [4.3]

### Хичээлд бэлтгэх эх сурвалжууд [4.3.1]



#### *Судрууд*

Семинарын дөрвөн хичээл дөрвүүлээ мөн институтийн батлагдсан хичээлүүд нь жишиг бүтээлүүдээс судалдаг. Энэхүү цуврал хичээлд заах зүйлсийн гол эх сурвалж нь судрууд юм. Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон семинар ба институтийн багш нарт хандан хэлсэн үгэндээ: "Судруудыг мөн амьд бошиглогчдын хэлсэн үсгийг орлох зүйл гэж үгүй. Эдгээр нь таны хичээлийн гол эх сурвалж байх ёстой" гэж хэлсэн ("The Gospel Teacher and His Message" СБС-ийн багш нарт хандаж хэлсэн үг, 1976 оны 9-р сарын 17, 3).

Институтийн зарим цуврал хичээлүүд жишиг бүтээлээс илүүтэй сайн мэдээний сэдвүүдэд төвлөрсөн байдаг. Эдгээр цуврал хичээлийн багш нар институтийн сургалтын материалд санал болгосон материалуудыг (мөн судруудыг) хичээлээ бэлтгэхдээ голлон ашиглана. Багш нар эдгээр цуврал хичээлд заадаг сургаал ба зарчмуудыг тодотгож, батлахдаа судрууд болон бошиглогчдын үгсээс ашиглах боломжийг үргэлж эрэлхийлэх ёстой.

#### *Семинар ба институтийн сургалтын материал*

Семинар ба институтийн сургалтын материалуудыг багш нарт хичээлээ үр дүнтэй заахад нь туслах гол эх сурвалж болгон гаргасан юм. Сургалтын материал нь судруудын тухай мэдээлэл болон судрын нөхцөл байдал, хэцүү үг, хэллэгийн тайлбар, судартзаасан сургаал ба зарчмуудын талаар Тэргүүн Зөвлөлөөс хэлсэн үгс мөн ямар сургаал, зарчмуудыг заахыг зөвлөсөн зөвлөмж зэргийг багтаасан байдаг. Энд мөн заах аргуудыг санал болгосон байдаг. Багш нар сургалтын материалыг судрын хэсгүүдтэй хамт ашиглавал Ариун Сүнс тэдний хичээлээ суралцагсдынхаа хэрэгцээнд тохируулан заахад нөлөөлж чаддаг.

Ахлагч Хенри Б.Айринг сургалтын материалыг бэлтгэх ба заахтай холбоотой тайлбарыг өгсөн: "Сүмд заадаг сургаалын үнэнийг батлахаар бошиглогчдоор дуудагдсан тэдгээр нь хүлээн авсан сургалтын материалынхаа үг бүрийг, зураг, график бүрийг нягтлан үздэг. Бид зөвхөн итгэлтэйгээр үйлдсэнээр л сургалтын материалын хүч чадлыг нээж чаддаг юм. . . .

Сургалтын материалын агуулга болон дэс дарааллыг мөрдсөнөөр бид заах онцгой бэлгийн цоожийг нээх болно" ("The Lord Will Multiply the Harvest" Ахлагч Хенри Б.Айрингтай хийсэн уулзалт, 1998 оны 2-р сарын 4, 4–5).

#### *Нэмэлт материалууд*

Багш нар судрын хэсгийг илүү сайн ойлгоход нь туслахын тулд нэмэлт материалууд буюу Сүмийн сэтгүүлүүд ялангуяа ерөнхий чуулганы хэлсэн үгсээс ашиглаж болно. Сүмээс хэвлэж гаргаагүй заах санаануудыг агуулсан бусад материалуудыг дэврүүлэн ярих, шуугиан дэгдээх зэргээр

*Тэмдэглэл*

ашиглаж болохгүй. Урьд нь батлагдаж эсвэл хэвлэгдэж байсан материалуудыг ч хичээлд ашиглахад зохимжгүй байж болно. Хичээл нь суралцагсдад итгэл ба гэрчлэлийг олгодог байх ёстой.

## Юуг, хэрхэн заахаа шийдэх нь [4.3.2]

Хичээлд бэлдэж байхдаа багш "юу заах вэ?", "хэрхэн заах вэ" гэдгээ шийдэх ёстой байдаг. *Юу заах* гэдэгт нөхцөл байдал (үйл явдал болсон газар, соёл ба орчин тойрон зэрэг багтана), агуулга (түүх, хүмүүс, үйл явдал, ёслолууд ба сүнслэгээр өдөөгдсөн тайлбарууд гэх мэт) ба судрын хэсэгт орших сайн мэдээний чухал үнэнүүд орно. *Хэрхэн заах* гэдэгт арга барил, хандлага ба багш нар суралцагсаддаа туслахын тулд явуулдаг үйл ажиллагаанууд багтдаг (ангиараа хэлэлцэх, бичгийн дасгал болон жижиг хэсэг болгох гэх мэт). Багш нар *хэрхэн заахаа* шийдэхээс өмнө *юу заахаа* шийднэ. Ингэснээр гол анхаарлаа заах арга барилд төвлөрүүлэх бус харин судруудад төвлөрүүлэх боломжтой болдог.

Хичээлд бэлтгэх явцдаа багш нар *юуг, хэрхэн заах вэ гэдгээ шийдэхийн тулд хангалттай цаг, хүч чармайлт гаргах ёстой.* Багш хичээлдээ бэлтгэхдээ *юу заах* дээр ихэнх цагаа зарцуулвал суралцагсдаа хичээлд хэрхэн идэвхтэй оруулцуулах вэ гэдэгт анхаарал хандуулах цаггүй болж мэднэ. Үүний үр дүнд хичээл багш-төвтэй болж, уйтгартай байдаг. Харин багш *хэрхэн заах* тал дээр дэндүү их анхаарлаа хандуулвал хичээл зохион байгуулалтгүй, зорилгогүй, тааруухан болох хандлагатай байдаг.

## Юу заахаа шийдэх нь [4.3.3]

Багш заах зүйлсээ бэлтгэхэд дөрвөн үндсэн үе шаттай байдаг: Нэгдүгээрт, тэд судрын хэсгийн агуулга ба нөхцөл байдлыг ойлгохыг эрэлхийлнэ. Хоёрдугаарт, тэд судрын хэсэг дэх сургаал ба зарчмуудыг таньж мэдэн, ойлгоно. Гуравдугаарт, тэд суралцагсдад ямар зарчим ба сургаалуудыг сурч хэрэгжүүлэх нь хамгийн чухал гэдгийг шийднэ. Дөрөвдүгээрт тэд судрын хэсгийн жижиг хэсэг бүр дээр аль зэрэг их анхаарал хандуулахаа шийднэ.

### *1. Зааж буй судрын хэсгийн нөхцөл байдал ба агуулгыг ойлгох*

Багш судрын хэсгийн нөхцөл байдал буюу үйл явдал болсон газрын тухай ойлгохыг эрэлхийлж, агуулгыг нь ойлгохын тулд судрын хэсэгт бүх анхаарлаа төвлөрүүлнэ. Судрат бүх анхаарлаа төвлөрүүлнэ гэдэг нь уншиж, судалж, тунгаан бодож, уншсан зүйлээ ойлгохын тулд залбирна гэсэн үг юм.

Судрын агуулгыг ойлгохын тулд багш хийж болох хамгийн тустай зүйлсийн нэг бол сэдэв эсвэл үйл явц өөрчлөгдөж байгаа тусгаарлагч хэсгийг судрын хэсгээс олж харах явдал мөн. Сургалтын материал болон өөрсдийн ойлголтыг ашиглаж багш нар судрын хэсгийг эдгээр тусгаарлагч хэсгийг ашиглан хэд хэдэн жижиг хэсэгт хуваах болно. Эдгээр жижиг хэсгүүд нь багш нар өөрсдийн хичээлийн явцыг дэс дараалалтай болгон бэлтгэхэд мөн судрын хэсгийн бүх агуулгад ямар нэгэн хэмжээгээр анхаарал хандуулах боломжийг олгодог.

Багш нар ийн бэлдэж байх явцдаа чухал гэж санагдсан хүмүүсийн тухай, газар нутаг, үйл явдал "үйлдэл-ба-үр дагавар" харилцаа зэргийн талаар мөн хэцүү үг, хэллэгийн утгыг ойлгох ойлголтоо хөгжүүлэхийг эрэлхийлэх ёстой. Агуулгыг хангалттай сайн ойлгохын тулд судрын хэсгийг нэг бус удаа унших шаардлагатай болдог.

Тэмдэглэл

### *2. Сургаал ба зарчмуудыг таньж мэдэн, ойлгох*

Багш агуулга ба нөхцөл байдлыг ойлгохоос гадна судрын хэсэг дэх сургаал ба зарчмуудыг таньж мэдэн, ойлгож мөн сургалтын материалд санал болгосон тэдгээрийг нягталж үзэх ёстой. Сургалтын материал дээр байхгүй бол багш өөрөө сургаал ба зарчмуудыг тодорхой, цөөн үгээр илэрхийлэн бичих ёстой. Ингэж бичиж тэмдэглэх нь багшид зарчмууд ба тэдгээрийн утга санааг нэгтгэн холбоход тусалдаг. Энэ нь хичээлийн үеэр суралцах үйл ажиллагаануудыг явуулахад суралцагсдыг илүү сайн ойлгож, анхаарлаа төвлөрүүлэхэд нь тусалдаг.

### *3. Суралцагсдад ямар зарчим ба сургаалуудыг сурч, хэрэгжүүлэх нь хамгийн чухал вэ гэдгийг шийд*

Ихэвчлэн судрын хэсэгт хичээлийн цагийн хүрээнд утга агуулга бүхий ярилцаж болохуйц материал шаардлагатайгаас илүү их байдаг. Багш судрууд ба сургалтын материалыг судалж дуусаад суралцагсдад нь ямар зарчим ба сургаалуудыг сурч, хэрэгжүүлэх нь хамгийн чухал вэ гэдгээ шийдэх хэрэгтэй байдаг. Энэхүү шийдвэрийг гаргахад багш дараах зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай:

**Ариун Сүнсний өдөөлт.** Хичээл дээр ямар сургаал ба зарчмуудыг онцлон ярихаа шийдэхийн тулд багш нар Ариун Сүнсний удирдамжийг үргэлж эрэлхийлж байх ёстой.

**Сүнслэгээр өдөөгдөн бичсэн зохиогчийн зорилго.** Багш нар бошиглолоор бичсэн зохиогчийн хэлэх гэсэн санааг олж тогтоохыг эрэлхийлэх ёстой. Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон хэлэхдээ: "Хэрэв тэдгээр зохиогчид бидний үеийг харсан мөн бидэнд хамгийн үнэ цэнэтэй зүйлсийн тухай сонгон бичсэн юм бол бид Мормоны Номыг мөн тэгж үнэлж судлах ёстой биш гэж үү? 'Их Эзэн юуны учир үүнийг цэдэгтээ оруулахаар Мормонд (эсвэл Моронайд, Алмад) сүнслэгээр нөлөөлсөн юм бол? Энэ номноос би яг одоо юу сурч чадах вэ? гэж бид өөрсдөөсөө үргэлж асуух ёстой" гэжээ ("The Book of Mormon—Keystone of Our Religion," *Ensign,* 1986 оны 11-р сар, 6). Судрын цуврал хичээлүүдийг заадаг багш нар хичээлдээ бэлдэхдээ үүнтэй ижил асуултуудыг өөртөө тавьж байх хэрэгтэй.

Судрууд дахь бошиглогчдын хамгийн чухал зорилго нь Есүс Христийг гэрчлэх байсан гэдгийг багш нар үргэлж санаж байх ёстой. "Учир нь, миний бүхий л зорилго бол Абрахамын Бурхан, мөн Исаакийн Бурхан, мөн Иаковын Бурханд ирж, аврагд хэмээн хүмүүнд ятгах нь болой" хэмээн Нифай хэлсэн билээ (1 Нифай 6:4). Иймд учраас багш нар "Түүний сургаал ба Цагаатгалыг ойлгож, үүнд найдахад нь суралцагсдад маань туслах Есүс Христийн тухай юуг судрын энэ хэсэгт заасан бэ?" гэдгийг өөрсдөөсөө асуух хэрэгтэй.

Багш нар сүнслэгээр өдөөгдөн бичсэн зохиогчийн зорилгыг тодруулахаар эрэлхийлэх үедээ түүхэнд өгүүлээгүй илүү зүйлс рүү анхаарлаа хандуулахаас зайлсхийх хэрэгтэй. Ахлагч Хенри Б.Айринг анхааруулан хэлэхдээ: "Бид зохиогчдын бүх санааг эсвэл тэдний илэрхийлээгүй санааг мэддэг юм шиг харагдахыг оролдох ёсгүй" гэжээ ("'And Thus We See:' Helping a Student in a Moment of Doubt" Ахлагч Хенри Б.Айрингтай хийсэн уулзалт, 1993 оны 2-с сарын 5, 6).



*Тэмдэглэл*

**Хөрвүүлэх зарчмууд ба үндсэн сургаалууд.** Багш юу заахаа *шийдэхдээ* "судрын энэ хэсгийг заахдаа онцлон ярих бүх үнэнүүд суралцагсдыг маань Тэнгэрлэг Эцэг болон Аврагч руу ойртуулж, аврал руу хөтлөх үү?" гэдгийг анхааран үзэх хэрэгтэй. Ахлагч Хенри Б.Айринг бидэнд зөвлөн ийн хэлжээ: "Та хичээл заахаар бэлдэхдээ хөрвүүлэх зарчмуудыг нь хайгаарай. . . . Хөрвүүлэх зарчим нь Бурханы хүслийг дуулгавартай дагахад чиглүүлдэг зарчим юм" гэжээ ("Converting Principles" Ахлагч Том Перритэй хийсэн уулзалт дээр хэлсэн мэдэгдэл, 1996 оны 2-р сарын 2, 1).



**"Сайн мэдээний талаарх хоёр үзэл байдаг бөгөөд хоёулаа үнэн юм. Эдгээр нь таны заах хүч чадалд агуу өөрчлөлтийг өгч чадна. Нэгдэх үзэл нь сайн мэдээ бол бүгд үнэн гэсэн үзэл. Энэ бол үнэн юм. Сайн мэдээ бол үнэн. Ийм үзэл бодолтойгоор би ангид ямарч үнэнийг маш сайн заах ба сайн мэдээг зааж чадах болно. Хоёр дахь үзэл нь сайн мэдээ бол зарчим, тушаал ба ёслолууд бөгөөд хэрэв эдгээрийг хадгалж, дагаж, хүлээн зөвшөөрөх аваас мөнхийн амьдрал руу хөтлөх болно. Энэ үзэл бас үнэн юм.**

**"Энэ хоёр үзлийн алийг нь хичээл заахдаа илүү баримтлах вэ гэдгээ шийдэхдээ би агуу алхам хийдэг. Хэрэв би сайн мэдээ бол бүгд үнэн гэдэг үзлийг сайн мэдээ бол зарчим, тушаал ба ёслолууд бөгөөд хэрэв эдгээрийг хадгалж, дагаж, хүлээн зөвшөөрөх аваас мөнхийн амьдрал руу хөтлөх болно гэдэг үзлээс илүүд тавих юм бол ёс суртахуунгүй байдлын далайг сөрөн зогсоход нь суралцагсаддаа туслах уралдаанаас өөрийгөө гаргасан гэсэн үг юм."**

**(Хенри Б.Айринг, "Eyes to See, Ears to Hear" Шинэ Гэрээний тухай СБС-ийн симпозиум. 1984 оны 8-р сарын 16, 6)**

Багш нар заахаар шийдэж буй судрын хэсэгт С ба И-ийн үндсэн сургаалууд байгаа бол үүнийг тодотгож гаргаж ирэх ёстой. Эдгээр сургаал нь суралцагсдад Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөө ба Сүмийн үндсэн итгэдэг зүйлсийг ойлгоход тусалдаг. (2.7.2, "Үндсэн сургаалууд" хэсгийг үзнэ үү).

**Суралцагсдын хэрэгцээ ба чадвар.** Багш нь суралцагсдаа сайн мэддэг бас ойлгодог байвал тэдэнд хэрэгтэй, хэрэгжүүлэхэд нь хялбар зарчмуудыг олж, онцлон ярихад илүү дөхөмтэй байдаг. Багш нар судрын хэсгийг судлах явцдаа өөрт нь маш чухал, хэрэгцээтэй санагдах санаа буюу үзэл бодлыг олж болох ч энэ нь суралцагсдад ойлгоход хэцүү, тэдний сүнслэг байдлаас хэтэрсэн байж болно (жишээ нь Паулын мах ба сүүний тухай зөвлөгөөг 1 Коринт 3:2-ээс үзнэ үү). Багш нарт тийм ч сонирхолтой шинэ бус мэт санагдах зарим зарчим нь суралцагсдын хувьд маш чухал байж болно. Багш нар зүгээр нэг хичээл зааж байгаа биш харин суралцагсдад зааж байгаа гэдгээ санаж байх хэрэгтэй. Тэд зөвхөн хичээл заахад бэлтгэж байгаа бус харин суралцагсдад судлахад тусалж байгаа билээ. Багш аль зарчим ба сургаал суралцагсдад хамгийн хэрэгтэй байгааг шийдэхэд сургалтын материал их тустай байдаг.

Ахлагч Ричард Г.Скотт: "Юу хамгийн чухал вэ гэдгээ суралцагсдынхаа хэрэгцээ ба чадварт тохируулан шийд. Хэрэв түлхүүр зарчмыг ойлгуулж, хэрэгжүүлж, суралцагсдын амьдралын удирдамжийн нэг хэсэг болгосон бол хамгийн чухал зорилго биелсэн гэсэн үг юм" хэмээн хэлсэн ("To Understand and Live Truth" Ахлагч Ричард Г. Скоттой хийсэн уулзалт, 2005 оны 2-р сарын 4, 2–3).

Багш ямар нэг үнэнийг онцлон ярихаар шийдэхдээ нэг их анхаарал хандуулахгүй сургаал, зарчмуудын талаар товчхон дурдаад өнгөрөх тухай төлөвлөж болно. Эдгээрийг дурдаад өнгөрөх нь зарим нэг суралцагсдад чухал байж болох бөгөөд Ариун Сүнс тэдэнд уг зарчмыг хувьдаа ойлгож, хэрэгжүүлэхэд нь туслах болно. Багшийн анзааралгүй эсвэл ярихаар төлөвлөөгүй сайн мэдээний зарим үнэнийг суралцагсад олж мөн тэдгээрийн тухай ярилцах хүсэлтэй байж болно гэдгийг багш нар санаж байх хэрэгтэй.

Энэ бүхнийг шийдэхдээ багш Сүнснээс баталгаа эрэлхийлэх ёстой. Сүнс тэдэнд сүнслэгээр өдөөгдөн бичсэн судрын зохиогчдын санааг илүү сайн ойлгож, суралцагсдынхаа хэрэгцээг болон сайн мэдээний ямар үнэнүүд суралцагсдыг Тэнгэрлэг Эцэг ба Аврагч руу ойртуулахад туслах вэ гэдгийг мэдэхэд нь тусалж чадна.

Тэмдэглэл

### *4. Судрын хэсгийн жижиг хэсэг бүр дээр хэрхэн ярилцахаа шийдэх*

Судрын хэсгийн нөхцөл байдал ба агуулгыг ойлгож, үүнийг хоорондоо холбоотой жижиг хэсгүүдэд хувааж, суралцагсдын сурч, хэрэгжүүлэх сайн мэдээний чухал үнэнүүдийг олж тогтоосон багш судрын хэсгийн жижиг хэсэг бүр дээр хэрхэн ярилцахаа шийдэхэд бэлэн болсон байдаг. Ерөнхийдөө багшийн онцлон тэмдэглэхээр шийдсэн сургаал ба зарчмыг агуулсан тэдгээр хэсэгт хичээл дээр илүү анхаарлаа төвлөрүүлдэг. Энэ нь багш эдгээр шүлгийн нөхцөл байдал ба агуулгыг ойлгож, эдгээрт өгүүлсэн чухал сургаал ба зарчмуудыг олж, ойлгоход нь суралцагсдад тусална гэсэн үг юм. Мөн эдгээр сургаал ба зарчмын үнэн хийгээд чухал гэдгийг зүрх сэтгэлдээ мэдэрч мөн эдгээр үнэнийг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлж болохыг олж харахад нь суралцагсдад тусална гэсэн үг мөн.

Судрын хэсгийн зарим хэсгүүд нь хичээл дээр онцлон заасан үнэнүүд дээр төвлөрөөгүй байж болох ч эдгээр хэсгийг алгасах буюу тоохгүй өнгөрөөж болохгүй. Багш нар адаглаад эдгээр хэсгийг нэгтгэн товч ярихаар төлөвлөх ёстой.

*Анхааруулга:* Хичээлд бэлтгэх хязгааргүй их цагтай байна гэдэг ховорхон юм. Багш нарын гаргадаг нийтлэг алдаа бол хичээлд бэлдэхдээ унших, судлах түүнчлэн *юу заах вэ* гэдэгт дэндүү их цаг зарцуулаад харин *хэрхэн заах вэ* гэдэгт хангалттай цаг гаргадаггүйд байдаг. Багш нарт “би *заах зүйлээ хангалттай сайн ойлголоо” гэж бодох үе тохиолддог. Багш нар* харин одоо би үүнийгээ *хэрхэн* үр дүнтэйгээр заах вэ гэдгээ шийдэх хэрэгтэй байна” гэж хэлэх ёстой.

## **Хэрхэн заахаа шийдэх** [4.3.4]

Багш нар судрын хэсэг болон өөрийн нээж олсон үнэнүүдийн талаар заах гээд догдлох нь элбэг тохиолддог. Багш нар судалж, ойлгож мөн Сүнсээр заалгахаар тууштай мэрийснээр мэдлэгийг хүлээн авч мөн хичээлд бэлдэх явцдаа сурсан зүйлээ хуваалцах хүслийг мэдэрдэг. Сурч мэдсэн зүйлсээ хуваалцах нь зүйтэй боловч аливаа хичээлийн зорилго бол *суралцагсад* судруудыг ойлгож, Ариун Сүнсээр заалгаж мөн *өөрсдийн* сурсан зүйлсээ хэрэгжүүлэхэд дэмжих гэдгийг санаж байх ёстой. Хичээлийн зорилгыг биелүүлэх нь багш судраас суралцах явцдаа юу сурч мэдсэн мөн үүнийг чухал гэж бодож байгаагаа суралцагсдад хэлэхээс илүү зүйлийг шаарддаг юм. Энэ нь багш зүгээр шүлгийг уншаад, тайлбар хийгээд дараагийн шүлгийг уншихаас илүү их зүйлийг шаардана.

Багш хичээлд бэлдэх явцдаа мэдэрсэн мэдрэмжийг суралцагсад судлах явцдаа мэдэрсэнээр тэд мэдлэг хүлээн авдаг. Суралцагсдыг сайн мэдээний үнэнүүдийг ойлгож, олж нээхээр хайхад нь дэмжих ёстой. Тэдэнд сайн мэдээг өөрийн үгээр тайлбарлах мөн өөрийн мэддэг хийгээд мэдэрч байгаа зүйлсээ гэрчилж, хуваалцах боломжийг олгох хэрэгтэй. Энэ нь тэднийг сайн мэдээний талаарх ойлголтоо зүрхэндээ шингээхэд тусална.

Суралцагсад сайн мэдээг ийм арга замаар сурснаар судраас бие даан судлах мөн Сүнсээр судлах чадвартаа итгэх итгэлтэй болдог. Тэд сурч буй зүйлсээ амьдралдаа хэрэгжүүлэх хүсэлтэй болдог. Тэд мөн юунд итгэдэг болохоо бусдад тайлбарлаж, сайн мэдээний сургаал ба зарчмуудын талаар гэрчлэлээ хуваалцахад бэлтгэгддэг юм.

Ангид судраас хамтдаа суралцаж байх үедээ судлах энэхүү үйл явцыг мэдрэхэд нь суралцагсдад туслах арга барилыг багш нар төлөвлөх ёстой.

*Тэмдэглэл*

Багш нар хичээлийн төлөвлөгөө гаргахдаа дараах асуултуудад хариулж *хэрхэн заахаа* шийднэ:

1. Тэдний мэдвэл зохих нөхцөл байдал ба агуулгыг ойлгоход нь туслахын тулд ямар арга барил эсвэл судлах үйл ажиллагааг сонгох вэ?
2. Ямар арга барил суралцагсдад маань гол сургаал ба зарчмуудыг таньж, тэдгээрийг өөрийн үгээр тайлбарлах, бусад сургаал ба зарчмуудыг нээж олох боломжийг олгох вэ?
3. Эдгээр сургаал ба зарчмуудыг ойлгоход нь суралцагсаддаа туслахын тулд ямар аргаар заах нь хамгийн үр дүнтэй вэ?
4. Суралцагсад маань эдгээр зарчмын үнэн хийгээд чухал болохыг мэдэрч, тэдгээрийн тухай бусадтай хуваалцан, гэрчлэхэд нь туслахын тулд ямар аргаар заах вэ?
5. Эдгээр зарчмыг хэрхэн хэрэгжүүлэхээ ойлгоход нь мөн тэднийг хэрэгжүүлэхэд нь туслах ямар үр дүнтэй арга байна вэ?

Хэрхэн заахаа шийдэхэд туслах зарим санаануудыг доор өгөв.

**Заах арга барил нь заах гэж буй захиастай нийцэж мөн Сүнсний нөлөөг дэмжиж байхад анхаар.** Заримдаа багш нар суралцагсдыг хөгжөөж буюу тэдний сонирхлыг татахын тулд ойлголт, мэдлэг олгох боломжгүй арга барилыг сонгодог. Багш нар заах арга барилаа сонгохдоо уг арга барил нь суралцагсдад ойлгоход нь туслах зорилгыг дэмжиж байна уу эсвэл үүнийг бууруулж байна уу гэдгийг анхаарч үзэх ёстой. Жишээлбэл заавар өгөх тоглоом нь зугаатай бас мэдээлэл өгөх (Ариун Библийн номуудын дэс дараалал) үр дүнтэй арга мөн хэдий ч үүгээр дамжуулан сүнслэг мэдрэмжийг урих боломжгүй юм. Жижиг бүлгүүд болгон ажиллах нь үр дүнтэй байдаг ч энэ нь их цаг шаарддаг тул энгийн зарчмуудыг таньж мэдэхийн тулд энэхүү аргыг ашиглах нь тийм ч үр дүнтэй бус юм.

Багш заах арга барил ба үйл ажиллагаа нь сайн мэдээг судлахад тохиромжтой, хэн нэгнийг гомдоох буюу гэмтээхгүй, Сүнсний нөлөөг дэмждэг байхад анхаарах ёстой.

**“Сайн мэдээний агуу багш бол цуврал хичээлийн санал болгосон материалуудаас Есүс Христийн сайн мэдээний сургаал, зарчим, гэрээнүүдэд онцгой анхаарал хандуулан заадаг юм.”**



(Даллин Х.Өүкс “Gospel Teaching,” *Ensign,* 1999 оны 11-р сар, 79)

**Сургалтын материалыг ашигла.** Семинар ба институтийн сургалтын материал нь сайн мэдээг заах ба судлах үндсүүдийг хэрэгжүүлэхийг *хэрхэн заах* талаарх зөвлөмжүүдийг санал болгодог. Багш нар хичээл бүрийг бэлтгэхдээ сургалтын материалыг нухацтайгаар судалж, судрын хэсгийг заахдаа аль мэдээлэл ба арга барилыг ашиглахаа сонгох хэрэгтэй. Багш сургалтын материал дахь судрын хэсгийг заах бүх зөвлөмжийг ашиглахаар эсвэл ангийнхаа нөхцөл байдал, хэрэгцээнд уг санаануудыг тохируулан ажиллахаар сонгож болно.

**Амьдралтай уялдах холбоо ба зорилгыг бий болгох.** Судалж буй судрын хэсэг нь тэдний нөхцөл байдалтай хэрхэн холбогдож байгааг суралцагсад харснаар сайн мэдээний сургаалыг сурч, хэрэгжүүлэх илүү их хүсэлтэй болдог. Тэд судрууд амьдралын асуудлуудад хариулт өгч мөн тэднийг чиглүүлдэг болохыг харах боломжтой болдог.

Тийм учраас багш нар *хэрхэн заахаа* шийдэхдээ судрын хэсэгт агуулсан мөнхийн үнэнүүдийг санаж, тэдгээр нь суралцагсдын амьдралд ямар тустай, утга учиртай болохыг тунгаах нь зүйтэй. Үүнийг ойлгосон багш нар хичээлээ эхлэхдээ ихэвчлэн тохирох асуулт, нөхцөл байдал эсвэл

асуудал тавьж суралцагсдыг удирдамж, чиглүүлэл өгөх сайн мэдээний сургаал, зарчмыг судруудаас хайхад хөтөлдөг. Багш нар хичээлд бэлтгэх үедээ суралцагсдын анхаарлыг татаж, идэвхтэй оролцуулах аргуудыг төлөвлөх ёстой.

Тэмдэглэл



**Хэр зэрэг хурдтай заахаа шийдэх.** Багш нар судрын хэсгийг бүхэлд нь заахын тулд хичээх ёстой. Гэхдээ хичээлийн хэсэг бүрт хэчнээн цаг зарцуулахаа шийдэхдээ багш хичээлээ цагт нь багтаан заах нь чухал бус харин суралцагсдад хэрэгтэй зүйлсийг заах ёстойгоо санах нь зүйтэй. Багш нар хичээлээ зааж байхдаа өөрийн төлөвлөгөөнд захирагдан хичээлийн дундуур хүлээн авах илчлэлт эсвэл суралцагсдын оролцоонд тохируулан хичээлээ өөрчлөхгүй байж болохгүй.

Багш нарын гаргадаг нийтлэг нэг алдаа бол хичээлийн эхний хэсэгт ихэнх цагаа зарцуулаад сүүлийн хэсгийг нь хурдхан заагаад өнгөрөх явдал юм. Багш хичээлд бэлдэхдээ сонгосон арга барилаа ашиглан хичээлийн хэсэг тус бүрт хэчнээн цаг зарцуулахаа тооцоолон гаргах хэрэгтэй. Багш нарт цаг нь үргэлж хангалтгүй байдаг учраас судрын хэсгийн аль хэсгийг онцлон анхаарч харин аль хэсгийг нь дурдаад өнгөрөх хэрэгтэйг шийдэх хэрэгтэй болдог.

Бүтэн цуврал хичээл ба хичээл тус бүрийг хэр зэрэг хурдтай заахаа тогтоох хэрэгтэй байдаг. Жишээлбэл Шинэ Гэрээний цуврал хичээлийн багш дөрвөн сайн мэдээнд хамаг цагаа зарцуулах юм бол дараа дараачийн номнуудад өгүүлсэн сайн мэдээний чухал үнэнүүдийг заахад төвөгтэй болно.

Семинар ба институтийн ихэнх сургалтын материалд цуврал хичээлийг хэр зэрэг хурдтай заах зөвлөмжийг өгсөн байдаг.

**Суралцагсдыг үүргээ биелүүлэхэд нь туслахад анхаарах.** Багш нар заахаар бэлдэхдээ ганцхан юу хийх дээрээ бус харин суралцагчдад анхаарлаа хандуулах ёстой. “Өнөөдөр хичээл дээр би юу хийх вэ?” эсвэл “Би суралцагсаддаа юу заах вэ?” гэж асуухын оронд багш хичээлд бэлдэхдээ “Өнөөдөр суралцагсад маань хичээл дээр юу хийх вэ?”, “Суралцагсад мэдэх ёстой зүйлсээ олж нээхэд нь би хэрхэн тэдэнд туслах вэ?” гэж бодох нь зүйтэй юм.

**Төрөл бүрийн арга барил ашиглах нь.** Үргэлж ашиглах юм бол сайн арга барил ч үр дүнгүй эсвэл уйтгартай мэт болдог. Багш нар зөвхөн олон янзаар заахын тулд арга барилуудыг сонгох ёсгүй ч үр дүнтэй заадаг олон багш хичээл бүрийн дундуур мөн өдөр бүр янз бүрийн аргыг сонгодог. Хэрэв суралцагсдын сонирхол буурсан эсвэл хийж байгаа зүйлс нь суралцагсдыг хүсч буй зорилгодоо хүрэхэд нь туслахгүй байгаа мэт санагдвал багш заах арга барилаа хичээлийн дундуур өөрчлөх бэлтгэлтэй байх ёстой.

Олон төрлийн заах аргыг ашиглах нь өөр арга барилаар сурдаг суралцагсдад нөлөөлөхөд тустай. Суралцагсдыг харах, сонсох, хүрэх зэрэг олон төрлийн мэдрэхүйгээ ашиглах боломжийг олгодог заах арга барил буюу судлах үйл ажиллагаанууд нь суралцагсдын оролцоог өсгөж, юу заалгаснаа хожим нь санахад тустай байдаг.

Багш ерөнхийдөө өөрт нь заахад тааламжтай, сайн мэддэг арга барилаа сонгох нь зүйтэй боловч өөрсдийг нь илүү сайн багш болгох шинэ арга барилуудыг туршиж үзэх хүсэлтэй байх ёстой.

Энэхүү гарын авлагын дараагийн бүлэгт багш нар *хэрхэн заахаа* шийдэх үедээ анхааран үзэх төрөл бүрийн заах арга барилын тухай авч үзэх болно.

# 5

# Заах арга барил ба ур чадвар

Заах гэдэг нь олон хэсгээс бүрддэг олон талт үйл ажиллагаа юм. Заах арга барил буюу техникийн жагсаалтанд олон санаа, жишээ мөн тэдгээрийн тухай ярилцлагууд багтдаг. Гэхдээ эдгээрийг үр дүнтэй заахад зайлшгүй шаардлагатай заах арга барил, ур чадвар зэрэг зарим ерөнхий хэсгүүдэд хувааж болно. Энэхүү бүлэгт эдгээр чухал хэсгүүдийн тухай авч үзэх болно.

Ямар арга барилаар заахаа шийдэх явцдаа багш нар арга барил ба ур чадвар нь зорилгодоо хүрэх алхмууд гэдгийг санах хэрэгтэй. Багш нар суралцагсдад нь тухайн судрын хэсгийн агуулга, сургаал ба зарчмуудыг ойлгоход тусалж мөн мэдлэгийг олж, түүнийгээ хэрэгжүүлэхэд нь дэмжих хамгийн сайн арга барилыг сонгоно. Тодорхой арга барил буюу техникийг сонгох нь багш нарт түүнийг илүү үр дүнтэй арга замаар хэрэгжүүлэхэд туслах болно гэдгийг санах хэрэгтэй. Сүнсгүй бол ямар ч үр дүнтэй заах арга барил амжилтанд хүрэхгүй гэдгийг санах нь чухал.

## Асуултууд [5.1]

Сайн асуулт асууж сурах нь багш нарын хөгжүүлэх ёстой хамгийн чухал ур чадварын нэг юм. Асуултууд нь суралцагсдыг судруудыг ойлгох үйл явцад идэвхтэй оролцож, сайн мэдээний чухал үнэнүүдийг ойлгож, таньж мэдэхэд тусалдаг. Асуултууд нь суралцагсдыг сайн мэдээ тэдний амьдралд хэрхэн нөлөөлсөн болохыг санаж мөн тэд сайн мэдээний зарчмуудыг одоо болон ирээдүйд хэрхэн хэрэгжүүлж болохыг тунгаан бодоход тусалдаг юм. Үр дүнтэй асуултууд асуусанаар суралцагсдыг сонголтоо ашиглан мөн судлах үүргээ биелүүлэн суралцахдаа Ариун Сүнсийг урихад нь тусалдаг.

**“Асуулт асууж, хариулах нь судлах ба заахын үндэс юм.”**

(Хенри Б.Айринг “The Lord Will Multiply the Harvest” Ахлагч Хенри Б.Айрингтай хийсэн уулзалт, 1998 оны 2-р сарын 6, 5–6)



Хичээлд бэлтгэхдээ суралцагсдын зүрх сэтгэлийг нээж, тэднийг ойлгоход нь туслах үр дүнтэй асуултуудыг бэлтгэх нь их хүчин чармайлтыг шаарддаг. Багш нар асуултууд бэлтгэхдээ юуны түрүүнд ямар зорилгоор тухайн асуултыг асууж байгаагаа тогтоох хэрэгтэй (жишээ нь багш суралцагсдыг судрын хэсгээс мэдээллээ өөрсдөө олж авахыг, судрын хэсгийн утга санааг бодохыг эсвэл зарчмын үнэн болохыг гэрчлэхийг хүсч болох юм). Багш энэхүү зорилгынхоо дагуу асуултаа анхааралтайгаар зохиох хэрэгтэй. Үгээ анхааралтайгаар сонгох нь тухайн асуултыг үр дүнтэй болоход маш их нөлөөлдөг.

Багш нар тунгаан бодож, мэдрэх асуултуудыг асуухын тулд бэлтгэж, хичээх ёстой. Тэд хариултууд нь зүгээр нэг “тийм” эсвэл “үгүй” гэж хариулах мөн суралцагсдыг бодож тунгаахад өдөөхгүй, илт ойлгомжтой асуулт асуухаас зайлсхийх ёстой. Багш нар зөрчилдүүлэх асуулт асуухаас зайлсхийх хэрэгтэй. Энэ нь суралцагчдын сэтгэлийг гонсойлгож, ангийн уур амьсгалыг эвдэж, Сүнсийг гомдоодог юм (3 Нифай 11:29-г үзнэ үү).

Багш асуулт асуугаад суралцагсдад энэ талаар бодож тунгаах цаг гаргаж өгөх нь чухал байдаг. Заримдаа багш нар асуулт асуугаад нэг хоёр хором өнгөрөхөд хэн ч хариулахгүй бол сандарч өөрсдөө хариулдаг. Харин үр дүнтэй асуулт нь үргэлж тунгаан бодох хугацаа шаарддаг бөгөөд суралцагсад хариултаа судраас олох эсвэл сайн хариулт бодохын тулд тэдэнд хугацаа шаардлагатай. Зарим тохиолдолд суралцагсдад хариулахаас нь өмнө хариултаа бичих хугацаа өгөх нь тустай байдаг.

Агуу Багш Есүс Христ Өөрийн заасан зарчмуудын тухай тунгаан бодож, амьдралдаа хэрэгжүүлэхэд нь дэмжих олон янзын асуулт тавьдаг байсан. Түүний асуултууд нь Тэрээр заасан хүмүүсийнхээ амьдралд юу өгөхийг эрэлхийлэхээс шалтгаалан янз бүр байв. Түүний зарим асуулт нь сонсогч нарыг бодож, судраас эш татан хариулахад дэмждэг байсан. Жишээлбэл Тэрээр: "Хуульд юу гэж бичигдсэн байдаг билээ? Чи хэрхэн уншдаг вэ?" хэмээн асуусан байдаг. (Лук 10:26). Түүний зарим асуулт нь амлалт авахыг урьдаг байсан. Жишээлбэл Тэрээр "ямархуу маягийн хүмүүс байвал зохих билээ?" гэж асуусан (3 Нифай 27:27).

Тэмдэглэл

Багш нар асууж болох олон янзын асуулт байдаг ч сайн мэдээг заах ба судлахад чухал дөрвөн төрлийн асуулт байдаг байна.

1. Суралцагсдын *мэдээлэл цуглуулах* асуултууд
2. Суралцагсдыг *ойлгохын тулд дүгнэлт хийхэд* хүргэдэг асуултууд
3. *Мэдрэмж ба гэрчлэлийг авчирдаг* асуултууд
4. Зарчмуудыг *амьдралдаа хэрэгжүүлэхэд* урамшуулан дэмждэг асуултууд



## Суралцагсдын *мэдээлэл цуглуулах* асуултууд [5.1.1]

*Мэдээлэл цуглуулах* асуултууд нь суралцагсдад тухайн судартай холбоотой чухал хэсгүүдийг эрж хайн судрын агуулгын талаар үндсэн ойлголттой болоход тусалдаг. Мэдээлэл цуглуулах асуултууд нь суралцагсдыг мэдээллээ судруудаас хайхыг дэмждэг учраас судраас хариултуудыг нь уншихаас өмнө асуух нь зүйтэй. Энэ нь суралцагсдын анхаарлыг татаж, судрын түүхээс хариултаа олох боломжийг олгодог.

*Мэдээлэл цуглуулах* асуултуудад *хэн, юу, хэзээ, яаж* мөн *ямар зорилгоор гэдэг үгсийг агуулж болно.* Суралцагсдын *мэдээлэл цуглуулах* асуултуудын зарим нэг жишээ:

- Матай 19:22-т баян залуу *ямар учраас* гунигтайгаар буцсан бэ?
- 1 Самуел 17:24 дээр Израилын хөвгүүд Голиатыг хараад *яасан* бэ? Давид *26-р шүлэг* дээр хэрхэн хариулсан бэ?
- *Алма 38-р бүлгийн 5-15-р шүлэгт* Алма хүү Шиблондоо ямар зөвлөгөө өгсөн бэ?

*Тэмдэглэл*



Мэдээлэл цуглуулах асуултуудын хариултууд нь ойлголтын үндсийг тавьж өгдөг. Харин бусад төрлийн асуултууд нь хүмүүнд илүү агуу мэдлэг олгож, амьдралдаа хэрэгжүүлэхэд хөтөлдөг. Аврагчийн тавьсан "Хүмүүс Хүний Хүүг хэн гэж ярьж байна? (Матай 16:13) гэсэн асуулт нь мэдээллийн үндсийг агуулсан байна. Түүний шавь нарын өгсөн хариулт тэднийг илүү гүн утгатай, илүү хүчтэй "Харин та нар Намайг хэн гэж хэлэх вэ?" хэмээх асуултад бэлтгэсэн. (Матай 16:15).

## Суралцагсдыг *ойлгохын тулд дүгнэлт хийхэд* хүргэдэг асуултууд [5.1.2]

Дүгнэлтийн асуултуудыг суралцагсдыг судалж байгаа шүлгүүдээ мэддэг болсны дараа асуудаг. Эдгээр нь суралцагсдыг судрыг илүү өргөн цар хүрээтэйгээр, гүн гүнзгий ойлгохыг эрэлхийлэхэд хөтөлдөг. Эдгээр асуулт нь суралцагсдыг харилцаа ба жишээнүүдийг судлахад буюу судруудын ялгааг олж мэдэхэд тусалдаг. Дүгнэлтийн асуултуудад ихэнхдээ нэгээс илүү хариултууд байдаг.

Дүгнэлтийн асуултуудыг гурван зорилгын дагуу ашигладаг. Эдгээр нь суралцагсдад доорх арга замуудаар тусалдаг.

- Судрын утга ба агуулгыг илүү сайн ойлгоход.
- Сайн мэдээний сургаал ба зарчмуудыг таньж мэдэхэд.
- Тэдгээр сургаал ба зарчмуудын талаар илүү гүнзгий ойлголтыг хөгжүүлэхэд.

**Судрын утга ба агуулгыг илүү сайн ойлгоход суралцагсдад туслах.** Дүгнэлтийн асуултууд нь суралцагсдад судрын бичвэрүүд болон үйл явдлуудын түүх ба соёлыг судалж, судрын бусад хэсгүүдтэй хэрхэн холбогдож байгааг ойлгож өөрсдийн ойлголтыг тэлэхэд тусалдаг юм. Ийм төрлийн асуултууд нь суралцагсдыг үгсийн буюу өгүүлбэрийн утгыг ойлгож, сэдвийн гол чиг хандлагыг нарийвчлан дүгнэхэд тусалдаг. Энэхүү үйл явц нь суралцагсдыг сургаал ба зарчмуудыг таньж мэдэхэд бэлтгэдэг.

Иймэрхүү төрлийн асуултуудын жишээнээс доор өгөв:

- 3-8-р шүлэгт байгаа Түүний заасан зүйлсийг ойлгоход Матай 13:18–23-т байдаг Есүсийн тайлбар бидэнд хэрхэн туслах вэ?
- Тэнгэр элч удирдамж өгөхөд Нифай, Лемен, Лемүел нар хэрхэн хариулсан бэ? Та нар ямар ялгааг эндээс харж байна вэ? 1 Нифай 3:31; 4:1–7-г үзнэ үү).
- Юунаас болж 116 хуудас алдагдаж , Их Эзэн Иосеф Смитэд "чи Бурханаас илүүгээр хүмүүнээс айх ёсгүй" хэмээн хэлэхэд хүргэсэн бэ? (С ба Г 122: 7–8).

**Суралцагсдад сайн мэдээний сургаал ба зарчмуудыг таньж мэдэхэд туслах.** Суралцагсад судрын утга, агуулгыг ойлгох ойлголтоо хөгжүүлэх аваас судар дахь сургаал ба зарчмуудыг илүү сайн таньж мэдэж чадна. Асуултуудыг судлан шинжлэх нь суралцагсдыг судрын хэсэг дэх зарчим ба сургаалуудыг ойлгож, дүгнэлт хийхэд хүргэдэг ( 2.5.1, "Сургаал ба зарчмуудыг тодорхойлох" хэсгийг үзнэ үү).

Эдгээр асуултын зарим жишээг доор өгөв:

- Маш хэцүү байсан ч гуулин ялтсуудыг олж авсан Нифайн амжилтаар ямар зарчмуудыг дүрсэлсэн бэ? (1 Нифай 3–4-г үзнэ үү).

- Анхны үзэгдлээс бид Бурханы мөн чанарын талаар ямар зарчмуудыг сурч чадах вэ? (ИС—Т 1:15–20-г үзнэ үү).
- Цус алддаг өвчтэй эмэгтэй Аврагчид хүрэхийн тулд хэрхэн хичээсэн ба Аврагч түүнд хэрхэн хандсан тухай түүхээс бид юу сурч болох вэ? (Марк 5:24–34-г үзнэ үү).

**Сургаал ба зарчмуудын тухай гүн гүнзгий ойлголттой болоход нь суралцагсдад туслах.** *Суралцагсад сургаал ба зарчмуудыг таньж мэддэг* байхаас гадна, эдгээрийг амьдралдаа хэрэгжүүлэхээс өмнө *ойлгодог* байх нь чухал. Суралцагсдыг аливаа нэг сургаал ба зарчмын утгыг сайтар ойлгоход хөтөлж, зарчмуудыг орчин үед нийцүүлэн бодоход дэмждэг буюу зарчмуудын талаарх өөрсдийн ойлголтоо тайлбарлахад урьдаг асуултууд нь онцгой ач холбогдолтой юм. Зарим жишээг доор өгөв:

- Бид Бурханыг бүх “хүч, оюун, мөн чадлаараа” хайрладаг гэдгээ хэрхэн илэрхийлж чадах вэ?” (Моронай 10:32).
- Бусадтай найрсаг бусаар ярих эсвэл Сүнсийг гомдоох зугаа цэнгээнд оролцох уруу таталтыг даван туулах сүнслэг хүчийг олж авахад хэрхэн залбирал үргэлж тусалж чадах вэ? (С ба Г 115:5-ыг үзнэ үү.)
- Христийн суурь дээр амьдралаа барьж байгаа хүнээс та ямар зан чанаруудыг хардаг вэ? (Хиламан 5:1–14-г үзнэ үү).
- Алма 40-өөс сурсан зүйлээ ашиглан манай сүмд явдаггүй найздаа дахин амилалтын зарчмыг та нар хэрхэн тайлбарлаж өгөх вэ?

## *Мэдрэмж ба гэрчлэлийг авчирдаг* асуултууд [5.1.3]

Зарим асуултууд суралцагсдыг сайн мэдээний зарчим ба сургаалуудын тухай *бодож* мөн үүнийг *ойлгоход* тусалдаг бол харин зарим асуултууд тэднийг сүнслэг туршлагуудын талаар тунгаан бодож, амьдралд нь сайн мэдээний зарчим ба сургаал ямар чухал болохыг *мэдрэхэд* тусалдаг. Тэдгээр мэдрэмж нь суралцагсдын зүрх сэтгэлд сайн мэдээний зарчмын дагуу илүү итгэлтэй амьдрах хүслийг төрүүлэх нь олонтоо. СБС-ийн шашны багш нарт хандан хэлсэн үгэндээ Ахлагч Хенри Б.Айринг иймэрхүү асуултуудын тухай хэлэхдээ:

“Зарим асуултууд сүнслэг өдөөлтийг авчирдаг. Агуу багш хүн тийм асуултуудыг асуудаг юм. . . . Сүнслэг өдөөлтийг авчирдаггүй асуулт: “Жинхэнэ бошиглогчийг хэрхэн таньж болох вэ?” Энэ асуулт нь тэднийг судрууд ба амьд бошиглогчдын хэлсэн үгсийг санахад хөтөлдөг. Олон суралцагч хариулт өгч, ихэнх нь дажгүй санаануудыг гаргаж ирж, тэдний оюун санаа өдөөгдөх болно.

Гэвч бид энэ асуултыг жаахан өөрчлөөд “Та хэзээ бошиглогчийн хажууд байгаагаа мэдэрч байсан бэ?” гэж асуух аваас энэ нь тэднийг хэрхэн мэдэрч байснаа санахад хүргэдэг. Асуулт асуусныхаа дараа бид хэн нэгнийг нэр цохолгүй харин хүлээх хэрэгтэй. Асуултанд хариулдаггүй суралцагсад хүртэл сүнслэг туршлагуудынхаа талаар тунгаан бодох болно. Энэ нь Ариун Сүнсийг урьдаг юм” (“The Lord Will Multiply the Harvest,” 6).

Иймэрхүү асуултууд нь суралцагсдыг өнгөрснөө санаж, хэрхэн мэдэрч байснаа санахад хүргэдэг бөгөөд ярилцаж буй сайн мэдээний сургаал ба зарчимтай холбогдолтой сүнслэг туршлагынхаа талаар бодоход хүргэдэг. Эдгээр асуулт нь суралцагсдыг тэдгээр мэдрэмжийнхээ тухай хуваалцаж,

Тэмдэглэл



*Тэмдэглэл*

сургаал ба зарчмын талаарх гэрчлэлээ хуваалцахад хөтөлдөг. Эдгээр асуулт нь суралцагсдад тархинд байгаа сайн мэдээг зүрх сэтгэлдээ авчрахад тусалдаг. Тэд сайн мэдээний зарчим ба сургаалын үнэн хийгээд чухал болохыг зүрх сэтгэлдээ *мэдрэх* аваас үүнийг амьдралдаа хэрэгжүүлэх илүү боломжтой болдог.

Мэдэрч бас гэрчлэлээ хуваалцах урам зоригийг өгдөг асуултуудын зарим жишээ:

- Та хэзээ хэн нэгнийг уучилснаас ирэх амар амгалан ба баяр баясгаланг мэдэрсэн бэ?
- Өөрийн ойлголтондоо түшиглэхийн оронд Их Эзэнд итгэсэн учраас Тэрээр таныг шийдвэр гаргахад чиглүүлсэн үеийг сана (Сургаалт үгс 3:5–6-г үзнэ үү). Үүнийг хийснээр та хэрхэн адислагдсан бэ?
- Аврагчид хандан өөрийн биеэр Түүний золиослолд талархах боломж олдвол та Түүнд юу гэж хэлэх вэ?
- Ариун ойн цоорхойд болсон үйл явдал таны амьдралыг хэрхэн өөрчилсөн бэ?
- Бусад хүмүүс сорилтуудыг итгэлтэйгээр хүлээн авч байгааг та харж байсан уу? Энэ нь танд хэрхэн нөлөөлсөн бэ?

*Анхааруулах үгс:* Иймэрхүү төрлийн асуултуудын хариулт нь заримдаа дэндүү хувийн бас эмзэг байж болно. Суралцагсад асуултанд заавал хариулж, мэдрэмж, туршлага, гэрчлэлээ хуваалцах ёсгүйг багш нар анхаарна. Суралцагсад хувийн сүнслэг туршлага нь ариун нандин гэдгийг ойлгож, эдгээр туршлагыг зохистойгоор хуваалцахад нь багш нар дэмжин туслах ёстой (С ба Г 63:64-г үзнэ үү).

### *Амьдралдаа хэрэгжүүлэхийг урамшуулан дэмждэг* асуултууд [5.1.4]

Сайн мэдээг заах хамгийн гол зорилго бол суралцагсдыг судар дахь сургаал, зарчмуудыг амьдралдаа хэрэгжүүлж мөн дуулгавартай бөгөөд итгэлтэй хүмүүст амлагдсан адислалуудыг хүлээн авахад тэнцэхүйц болоход нь туслах юм. Сайн мэдээний зарчмуудын дагуу амьдарснаар хэрхэн адислагдаж байгаагаа харж чаддаг суралцагсад эдгээрийг ирээдүйд илүү амжилттай хэрэгжүүлэх илүү их хүсэлтэй мөн бэлтгэгдсэн байдаг. Суралцагсад эдгээр зарчмыг одоогийн нөхцөл байдалд болон ирээдүйд хэрхэн хэрэгжүүлэх талаар бодоход асуултууд маш чухал үүрэгтэй байдаг.

Суралцагсдад сургаал ба зарчмуудыг амьдралдаа хэрэгжүүлэх зарим нэг аргуудын тухай бодоход нь туслах зарим жишээг доор өгөв:

- Дэлхийгээс бүрэн дүүрэн толбогүй байж болохын тулд Ариун өдрийг илүү сайн сахихын тулд та ямар өөрчлөлтүүдийг хийх хэрэгтэй байна вэ? (С ба Г 59:9, 13, 15–17 -г үзнэ үү.)
- Та нар юуг чанд дагаж болно гэж бошиглогчид зөвлөсөн бэ? (Алма 57:1–27-г үзнэ үү).
- Та нарт дараагийн хоёр гурван жилийнхээ зорилт буюу үйл ажиллагаагаа төлөвлөхөд *"Бурханы хаант улсыг эрэлхийлвэл бидний амьдрал адислагдах болно"* гэдэг зарчим хэрхэн тусалж чадах вэ? (Матай 24:32–33-г үзнэ үү).

## Ангийн ярилцлага [5.2]




Сайн мэдээг заах ба судлахад ангиараа ярилцах нь маш чухал байдаг. Багш суралцагчидтай, суралцагч бусадтайгаа харилцан ярилцаж, суралцах үед ангийн ярилцлага явагддаг юм. Сайн харилцан яриа нь суралцагсдыг асуултуудад хариулт эрэлхийлэхийн чухлыг ойлгоход тусалдаг. Мөн бусдын санал, сэтгэгдэл болон туршлагаас сонсож суралцахад тусалдаг. Энэ нь суралцагсдыг ярилцаж буй сайн мэдээний сургаал ба зарчмуудыг сайн ойлгоход түүнчлэн сурч, мэдэрсэн зүйлсээ хэрэгжүүлэх чин хүсэлтэй байхад нь туслах хичээлдээ анхаарлаа хандуулж, идэвхтэй оролцоход нөлөөлдөг.

Сүнслэг бөгөөд сонирхолтой ярилцлага удирдан явуулах зарим аргыг доор өглөө:

**Ярилцлага төлөвлөх нь.** Ярилцлагыг заах бусад арга барилын нэгэн адил анхааралтайгаар бэлдэж, Сүнслэг байдлаар удирдан явуулах хэрэгтэй. Багш нар суралцагсдад юу судлах хэрэгтэйгээ ойлгоход нь ярилцлага хэрхэн туслах, тэрхүү зорилго руу нь ямар цуврал асуултууд хөтлөх, тэдгээр асуултыг хэрхэн хамгийн зөвөөр тавих болон суралцагчийн хариулт өөр тийшээ чиглэвэл хэрхэн хариулах зэргийг бодож төлөвлөсөн байх ёстой.

**Багш дэндүү их тайлбар хийхээс зайлсхий.** Ярилцаж буй сэдэв дээр багш дэндүү их тайлбар хийх нь суралцагчдын оролцоог бууруулдаг. Учир нь багш өөрөө үргэлж хариулах гэж хүсч байгааг тэд анзаардаг. Багш дэндүү их тайлбар хийснээр суралцагсад тэдний оролцоо тийм чухал биш хэмээн санаж, сонирхол нь буурдаг.

**Бүх суралцагсдыг оролцохыг урих.** Багш нар ярилцлагандаа суралцагсдыг урьж оруулах аргуудыг олохын тулд хичээх ёстой. Тэд янз бүрийн шалтгаанаар ярилцлаганд оролцдоггүй суралцагсдыг ч урих хэрэгтэй. Суралцагч асуултанд хариулахад бэлэн бус байгааг мэдэж байгаа бол түүний нэрийг дуудаж бусдын өмнө эвгүй байдалд оруулж болохгүй.

Зарим ярилцлагын үеэр нэг буюу хэсэгхэн суралцагсад ярилцлагад давамгайлан оролцдог. Багш нар тийм суралцагсад дээр ганцаарчлан очиж уулзан, хичээлд идэвхтэй оролцох хүсэлтэй байгаад нь талархахын зэрэгцээ ангийн бүх гишүүдийг оролцуулахыг дэмжих нь хэчнээн чухал хийгээд асуултанд хариулах хүсэлтэй үед нь яагаад түүнийг үргэлж дууддаггүй болохоо тайлбарлах хэрэгтэй байж болно.

**Суралцагсдыг нэрээр нь дуудах.** Асуултанд хариулахад, санал сэтгэгдлээ хэлэхэд нь суралцагсдыг нэрээр нь дуудах нь судлах орчинд хайр ба хүндлэлийг бий болгодог.

**Ангид нам жим болоход сандрах хэрэггүй.** Заримдаа үр дүнтэй сайн асуулт асуухад суралцагсад тэр дор нь хариулт хэлдэггүй. Энэ нам жим байдал нь дэндүү удаан үргэлжлэхгүй л бол багш сандрах хэрэггүй. Хааяа суралцагсдад асуусан зүйлийн тухай болон хэрхэн хариулахаа тунгаан бодох хэрэгтэй байдаг. Энэ нь Ариун Сүнсээр удирдуулахад дөхөмтэй болгодог.

Тэмдэглэл

**Асуултыг давтан хэлэх.** Заримдаа асуулт нь тодорхой бус учраас суралцагсдад уг асуултанд хариулахад хэцүү байдаг. Энэ үед багш асуултыг дахин асуух эсвэл суралцагсдаас асуултыг ойлгосон эсэхийг нь лавлах хэрэгтэй. Багш нар суралцагсдад асуултын тухай сайтар бодож, зөв хариултыг олох цаг өгөлгүйгээр баахан асуулт цувруулан асууж болохгүй.

**Анхааралтай сонсож мөн хөтлөн чиглүүлэх асуултыг асуу.** Багш нар заримдаа юу хэлэх, дараа нь юу хийх вэ гэдэгт хэт их санаа тавин суралцагсдын хэлж байгаа зүйлсийг анхаарахгүй өнгөрөх байдал гардаг. Суралцагсдыг ажиглан, тэднийг сонссоноор багш тэдний хэрэгцээг таньж мөн ярилцлагаа Ариун Сүнсний удирдамж дор явуулж чадна. Багш суралцагчийн өгсөн хариултыг зөв ойлгосон эсэхээ магадлахын тулд "чиний хэлсэн зүйлийг сайн ойлгоход маань туслаач" эсвэл "хэлсэн зүйл дээрээ жишээ гаргаж болох уу?" гэх мэтээр асууж болно. Иймэрхүү баталгаажуулах асуултыг тавих нь суралцагсдыг бодож, мэдэрч байгаа зүйлсээ болон гэрчлэлээ хуваалцах сүнсийг урьдаг юм. Нэг нэгнээ сонсож, хэн нэгнийг ярьж байхад зэрэгцэн ярьж болохгүй гэдгийг багш нар суралцагсдад сануулах ёстой.

> **"Өөрсдийнхөө дунд багшийг томил, мөн бүгдээрээ нэг зэрэг яригчид бүү байг; бүгдээрээ ярихад бүгдээрээ бүхнээс сэнхэрсэн байж болохын тулд, нэг нь хэсэг хугацаанд ярьж, мөн бүгдээрээ түүний хэлэхийг сонсог."**
>
> **(Сургаал ба Гэрээ 88:122)**



**Суралцагчийн санал сэтгэгдэл буюу асуултыг бусад суралцагсдад нь хандан тавих.** Ихэнх үед ангийн ярилцлага нь багш асуулт асууж, суралцагч хариулж, дараа нь суралцагчийн өгсөн хариултанд багш өөрийн дүгнэлтийг нэмж дараагийн асуулт руу орох маягаар явагддаг. Багш суралцагчийн өгсөн хариулт эсвэл санааг бусад суралцагсдад хандан тавих нь ярилцлагыг илүү утга учиртай, бодит, үр дүнтэй болгодог. "Үүн дээр чи юу нэмж хэлмээр байна?" эсвэл "Энэ санааг чи юу гэж бодож байна вэ?" гэх мэтийн энгийн асуултууд нь суралцагч суралцагчийнхаа асуултанд хариулах боломжийг олгодог. Энэ нь судлах үйл явцыг маш үр дүнтэй болгодог. Хангалттай цаг байвал санал сэтгэгдлээ хуваалцах хүсэлтэй суралцагч бүрт тэрхүү боломжийг олгох нь зүйтэй.

**Хариултыг эерэгээр хүлээн авах аргууд.** Суралцагч хариулт өгсөн үед багш үүнийг нь ямар нэг байдлаар хүлээн авах хэрэгтэй байдаг. Үүнийг зүгээр "баярлалаа" гэж хэлэх эсвэл хариултанд нь саналаа хэлэх зэргээр хийж болно. Хэрэв суралцагч буруу хариулвал багш уг суралцагчийг эвгүй байдалд оруулахаас сэрэмжлэх хэрэгтэй. Сайн багш бол суралцагчийн зөв санааг өлгөн авч ярилцаг ба тэрхүү санааг суралцагсад нь тунгаан бодоход туслах баталгаажуулах асуултыг асуудаг.

## Ангид судраас хамтдаа унших [5.3]

Ангид судраас хамтдаа унших нь суралцагсдыг судалж буй шүлгүүдийг мэддэг болж, илүү сайн ойлгоход тусалдаг. Мөн тэдэнд бие даан судар унших чадвартаа илүү итгэлтэй болоход тусалдаг. Багш нар сайн уншиж чаддаггүй буюу маш ичимхий бүрэг суралцагсдыг эвгүй байдалд оруулахаас сэрэмжлэх ёстой. Чанга унших дургүй суралцагсдыг хүчээр чанга уншуулах ёсгүй. Гэхдээ тэднийг өөрсдийнх нь хүссэн арга замаар хичээлд оролцохыг багш нар дэмжих хэрэгтэй. Жишээлбэл судрын хэсгийн богинохон хэсгийг унших даалгаврыг урьдчилан өгч түүнд дадлага хийх боломжийг олгох нь суралцагчийг хичээлд оролцуулах зөв арга байж болно.

*Тэмдэглэл*

Ангид судраас хамтдаа унших хэд хэдэн арга байдаг:

- Суралцагсдыг нэг нэгээр нь эсвэл хамтад нь чангаар уншуулах.
- Суралцагсдыг нэг нэгэнд нь уншуулах.
- Судрын хэсгийг суралцагсдаар дуугүй уншуулах.
- Судалж буй түүх дээр гардаг янз бүрийн хүмүүсийн хэлсэн үгсийг өөр өөр суралцагсдаар уншуул.
- Багш чангаар уншиж, суралцагсад судраа дагаж харна.

## Багшийн хичээлийн танилцуулга [5.4]

Судруудыг ойлгож, хэрэгжүүлэхэд суралцагсад идэвхтэй оролцох нь чухал байдаг ч багш мэдээллийг зөв зохистойгоор танилцуулах нь хамгийн чухал юм. Энэхүү гарын авлагын зорилгын дагуу багш ярьж, суралцагсад сонсох тэрхүү цагийг “багшийн хичээлийн танилцуулга” хэмээн нэрлэх болно. Багшийн хичээлийн танилцуулгыг зөв явуулахад заах бусад аргууд сайжирдаг. Хэрэв багш дээр төвлөрсөн энэхүү үйл ажиллагааг хэтрүүлэн заах аваас үр дүн багасч, суралцагчийн судалж, итгэлтэйгээр судлах боломжийг хязгаарладаг юм.

Их хэмжээний материалуудыг нэгтгэн дүгнэх, суралцагсдад шинэ мэдээллийг танилцуулах, хичээлийн өөр өөр хэсэгт шилжих эсвэл дүгнэлт хийх зэрэгт багшийн хичээлийн танилцуулгыг ашиглах нь маш үр дүнтэй байж болно. Багш судрын хэсгийн нөхцөл байдлыг илүү сайн ойлгуулахын тулд тайлбарлаж, тодотгож өгөх шаардлагатай байж болно. Багш гол сургаал ба зарчмуудыг онцлон тэмдэглэж, тэдгээрийг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь суралцагсдыг дэмжих хэрэгтэй. Багш нар сайн мэдээний үнэнүүдийг болон Тэнгэрлэг Эцэг ба Түүний Хүүг хайрладаг хайраа үргэлж илэрхийлж байх нь хамгийн чухал байдаг.

Багш танилцуулах аргыг ашиглан заахдаа суралцагсад хэр сайн ойлгож, хичээлдээ идэвхтэй оролцож байгааг тогтоохын тулд “Суралцагсад маань хичээлээ сонирхож, анхаарлаа хандуулж байна уу?”, “Танилцуулж байгаа зүйлийг тэд ойлгож байна уу?” гэж өөрсдөөсөө асууж байх хэрэгтэй. Эцэст нь аливаа заах аргыг сонгохдоо энэ нь суралцагсад Сүнсээр сурч, судруудыг ойлгож, сурсан зүйлээ хэрэгжүүлэх хүслийг өдөөж байгаа эсэхийг тодорхойлсны үндсэн дээр шийднэ.



Багш энэхүү аргыг илүү үр дүнтэй ашиглахад дараах санаанууд тусална:

**Багш хичээлийн танилцуулах хэсгийг төлөвлөх нь.** Багш нар хичээлийн бусад хэсгийг сайн бэлдсэн ч өөрөө голлон ярьж байх үед тэдгээр хэсэгт хангалттай сайн анхаарлаа хандуулж чадахгүй болох нь олонтоо тохиолддог. Багш хичээлийн танилцуулгаа хийх явцад суралцагсад идэвхгүй сонсогч болох хандлагатай байдаг. Тийм учраас багшийн танилцуулга нь хичээлээ хэрхэн эхэлж, ямар дэс дараалльг баримтлан заах зэргийг сайн төлөвлөж, бэлтгэхийг шаарддаг.

*Тэмдэглэл*



Багшийн танилцуулгыг бэлтгэхдээ суралцагсад ямар үед идэвхтэй үүрэг гүйцэтгэх хэрэгтэйг анхааралтайгаар харгалзан үзэх ёстой. Хичээлийн үйл явц нь ерөнхийдөө судрын хэсгийн нөхцөл байдал ба агуулгыг ойлголтоос нээлт, харилцан яриа, сургаал ба зарчмын хэрэгжүүлэлт зэрэг рүү шилжихэд суралцагсдын идэвхтэй оролцох үүрэг нэмэгддэг.

**Багшийн танилцуулгыг бусад заах аргуудтай хослуулах.** Ангид багш хичээлээ үр дүнтэй болгохын тулд бэлдсэн хичээлийн төлөвлөгөөний нэг хэсэгт нь зааварт өгүүлсэн бусад заах аргуудтай хослуулан багшийн танилцуулгыг хийх ёстой. Багшийн танилцуулгын хэсгийн үед суралцагсад уйдсан эсвэл эргэлзсэн байдалтай байвал багш заах арга барилаа өөрчилж уян хатан байх ёстой. Ийм учраас багш танилцуулах явцдаа суралцагсад болон судлах үйл явцад анхаарлаа хандуулж, хэрэгтэй өөрчлөлтүүдийг хийж болно. Нэг хүн багшийн танилцуулгын хэсгийг сувдан хүзүүний зүүлтний утастай зүйрлэсэн байдаг. Сувднууд нь багшийн ашигладаг олон төрлийн заах аргуудтай адил бөгөөд (асуулт, ярилцлага, бүлгээр хийх ажил, видео үзүүлэн гэх мэт) эдгээр нь багшийн зааварчилгаа ба тайлбараар хоорондоо холбогддог. Утас дангаараа гоё хүзүүний зүүлт болж чадахгүй.

**Тохирох олон аргуудыг ашигла.** Багш хичээлээ танилцуулах олон арга байдаг. Багш хичээлээ танилцуулах явцдаа дуу хоолойныхоо өнгийг өндөрсөх юмуу намсган өөрчилж, ангид алхах зэрэг үйлдэл хийж болно. Хичээлийн материалыг танилцуулах олон аргууд ч бас байдаг. Жишээлбэл багш түүх ярих, тохирох хошин зүйл хэлэх, зураг болон бусад үзүүлэн үзүүлэх, эшлэл унших, самбар буюу видео танилцуулгыг ашиглах, гэрчлэлээ хуваалцах гэх мэт. Зохимжтой олон төрлийн танилцуулгыг ашиглах нь суралцагсдын судрыг ойлгох болон амьдралдаа хэрэгжүүлэх чадварыг нэмэгдүүлэх учиртай.

## Түүх [5.5]

Түүхүүд нь Есүс Христийн сайн мэдээнд итгэх суралцагсдын итгэлийг хөгжүүлж чадна. Түүхүүд нь суралцагсдын сонирхлыг өдөөж мөн сайн мэдээг ойлгоход нь янз бүрийн туршлагуудаар дамжуулан тусалдаг. Судрын хэсгүүдэд уг түүхүүд нь орсон байвал сайн мэдээний зарчмуудыг ойлгоход суралцагсдад хялбар байдаг. Сайн мэдээний зарчмыг судруудын нөхцөл байдлаас гадна өнөөгийн нөхцөл байдал дээр тайлбарлах нь суралцагсдад сайн мэдээний зарчим тэдний амьдралтай хэрхэн холбогдож байгааг ойлгоход мөн үүнийг хэрэгжүүлэх хүсэлтэй болоход тусалдаг.

Ахлагч Брюс Р.МкКонки заахдаа: “Мэдээж хэрэг бидний эрин үед тохиолдсон итгэл өдөөх түүхийг ярихад буруу зүйл байхгүй. . . . Харин ч үүнийг бүрэн дэмжих ёстой. Эртний итгэлтэй хүмүүст тохиолдсон зүйлс энэ үеийн Гэгээнтнүүдийн амьдралд одоо ч тохиолддог гэдгийг харуулахын тулд бид бололцоотой бүхнээ хийх хэрэгтэй. . . .

Магадгүй, итгэл өдөөх түүхүүдийг заах төгс арга зам бол судар дээр байгааг заах тэгээд бидний эрин үед, бидэн шиг хүмүүст тохиолдсон ижил төстэй түүхүүдээс хуваалцах байж болно” (“The How and Why of Faith-Promoting Stories,” *New Era,* July 1978 оны 7-р сар, 4–5).

Багш нар бошиглогчдын амьдрал, Сүмийн түүх, Сүмийн сэтгүүлүүд болон ерөнхий чуулган дээр хэлсэн үгсээс хуваалцах ёстой. Тэд өөрсдөд нь тохиолдсон түүхээс хуваалцаж болно. Багш суралцагсдаас сайн мэдээний дагуу амьдарснаар хэрхэн адислагдсан тухай туршлагаасаа хуваалцахыг хүсэх нь судлах үйл явцад маш тустай бөгөөд сайн үр нөлөө үзүүлдэг.

*Тэмдэглэл*

Түүхүүдийг ашиглах үед зарим нэг анхаарвал зохих зүйлс байдаг.

- Хичээл заахдаа түүх ярихыг хамгийн гол заах арга буюу арга барилаа болговол түүх нь хичээлийн хамгийн чухал хэсэг болж, судруудад зарцуулах цагийг багасгаж, зааж буй зарчим ба сургаалаас түүх нь илүү чухал мэт санагдуулах болно.
- Багш өөрт тохиолдсон түүхүүдээс дэндүү их ярих аваас өөрийгөө хэт дөвийлгөсөн байдалд орж “өөрсдийгөө хорвоогийн гэрэл” мэт болгодог (2 Нифай 26:29).
- Түүхүүд нь судрын сургаалуудыг ойлгуулж, бодит амьдралтай холбож өгч мөн суралцагсдыг Сүнсний хүчийг мэдрэхэд нь тусалдаг хэдий ч үүнийг хэзээ ч сэтгэлийн хөдөлгөөнд нөлөөлөх зорилгоор ашиглаж болохгүй.
- Багш нар түүхийг ярихдаа илүү сэтгэл хөдөлгөсөн эсвэл илүү гүн гүнзгий утгатай болгохыг хичээн бодит байдлаас нь дэврүүлэн ярихаас сэрэмжлэх хэрэгтэй.
- Хэрэв ярих гэж буй түүх чинь бодит бус зохиомол түүх бол үүнийг ярихаасаа өмнө заавал тодотгон хэлж өгөх хэрэгтэй.

## Жижиг бүлгийн ярилцлага ба даалгавар [5.6]



Заримдаа суралцагсдыг хосоор нь эсвэл жижиг бүлэг болгон хуваах нь тэднийг судлах үйл ажиллагаанд оролцоход, хамтдаа ярилцан зөвлөхөд тустай байдаг. Жижиг бүлгийн үйл ажиллагаанд олон тооны суралцагч хамрагдах боломжтой байдаг ба энэ нь суралцагсдыг санаа бодол, мэдрэмж болон гэрчлэлээ бие биендээ хуваалцах орчныг бий болгодог. Эдгээр үйл ажиллагаа нь суралцагсдад сайн мэдээг бусдад заах боломжийг олгож, ирээдүйд сайн мэдээг заахад нь бэлтгэдэг юм. Жижиг бүлгийн ярилцлага нь сонирхол болон анхаарал нь суларсан суралцагсдыг идэвхтэй оролцуулахад мөн тэднийг харилцааны чадвараа хөгжүүлэхэд тусалдаг. Энэ нь суралцагсдыг нийгмийн ба сүнслэг харилцаагаа өсгөхөд тусалдаг. Энэ нь бүрэг ичимхий суралцагсдыг өөртөө итгэлтэй, илүү идэвхтэй болгодог.

Суралцагсдыг хос хосоор нь эсвэл жижиг бүлгүүд болгохдоо дараах зүйлсийг анхаараарай:

- Суралцагсдыг жижиг бүлгүүдэд хуваахаасаа өмнө багш нар үйл ажиллагааны үеэр тэднээс юу хийхийг хүсч байгаагаа тодорхой зааварчилна. Эдгээр зааварчилгааг самбар дээр бичиж эсвэл цаасан дээр бичээд тарааж өгснөөр суралцагсад үйл ажиллагааны дундуур эдгээр заавраа харж, дагахад тусалдаг.
- Суралцагсдад тохирсон бүлгээрээ судлах үйл ажиллагааг явуулах нь тэдний сонирхол ба оролцоог илүү өсгөдөг.

*Тэмдэглэл*

- Бүлэг бүрд удирдагч томилон, цаг тогтоож өгөх нь бүлгүүдийг даалгавраа биелүүлэхэд тусалдаг. Дэндүү удаан үргэлжлэх бүлгийн үйл ажиллагаа нь бүлгүүд өөр өөр цагт дуусч, ангид эмх замбараагүй байдал үүсэхэд хүргэдэг.
- Суралцагсдыг судлах үйл ажиллагааныхаа үеэр сурсан зүйлээ хуваалцах эсвэл заах хэрэгтэй хэмээн багш урьдчилан хэлбэл суралцагсад уг үйл ажиллагаанд илүү чармайн оролцох хандлагатай байдаг. Энэ нь суралцагсдад сайн мэдээг бусдад заах дадлага болдог.
- Суралцагсад бүлэг болон ажиллахаасаа өмнө эшлэлийг уншсан эсвэл өөр ямар нэг даалгаврыг бие даан гүйцэтгэсэн байвал бүлгээрээ ажиллахад илүү үр дүнтэй байдаг.
- Бүлэг нь таваас дээш хүнтэй байвал хүн бүрийн оролцох идэвх буурдаг. Мөн их хүнтэй бүлгүүд даалгавраа биелүүлэхэд илүү төвөгтэй болдог.
- Суралцагсдыг бүлгүүдэд хуваахад цаг шаардагддаг учраас энгийн асуултанд хариулах зэрэг үйл ажиллагаанд жижиг бүлгүүд болгох арга тохиромжгүй байх болно.
- Бүлгээр ажиллах үйл ажиллагааг дэндүү их хэрэглэвэл үр дүн буурна.

Жижиг бүлгийн ярилцлага буюу даалгавар биелүүлэх үйл ажиллагааны үеэр суралцагсад зорилгоосоо хазайн, хувийн зүйлсээ хийх эсвэл тэдний судлах чармайлт нь суларч болох юм. Багш үйл ажиллагааны үеэр бүлгүүдийн дундуур явж, тэднийг хянаж байх нь суралцагсдыг үйл ажиллагаандаа идэвхтэй оролцож, хэрэгтэй бүхнээ судлахад нь тусалдаг.



## Бичих дасгал [5.7]

Багш нар суралцагсдыг тэмдэглэл хийх, өдрийн тэмдэглэл хөтлөх, хүснэгт гаргах, санал бодлоо бичих болон зохион бичлэг хийх зэрэг бичих дасгалуудыг хийхийг хүсэх хэрэгтэй. Эргэцүүлэн бодоход хөтөлдөг асуултыг бичиж тэмдэглэх нь бодол санаагаа гүнзгийрүүлэн, цэгцлэхэд тусалдаг. Асуултанд хариулахаасаа өмнө өөрсдийн бодлоо бичиж тэмдэглэхийг суралцагсдаас хүсэх нь тэдэнд бодол санаагаа цэгцэлж, Ариун Сүнсний нөлөөг хүлээн авах боломжийг олгодог. Асуултын талаар бичиж тэмдэглэсэн үедээ суралцагсад бодол санаагаа хуваалцах илүү хүсэлтэй болж, үүнийгээ илүү үр дүнтэйгээр хуваалцдаг. Даалгавруудыг бичиж тэмдэглэх нь суралцагсдад идэвхтэй оролцох, сүнслэг нөлөөг хүлээн авах, бусдад заах болон тэдэнтэй сэтгэгдлээ хуваалцах, Их Эзэний нөлөөг таньж мэдэх, гэрчлэлээ хуваалцах зэрэг боломжийг олгодог. Багш нар бичих дасгалыг хичээлд ашиглахаар сонгохдоо Ахлагч Дэвид А.Беднарын хуваалцсан зарчмыг санах нь зүйтэй. Тэрээр хэлэхдээ: "Судраас судалж байхдаа сурч, бодож, мэдэрсэн зүйлсээ бичиж тэмдэглэж авах нь тунгаан бодох, Ариун Сүнсний зааврыг үргэлжлүүлэн хүлээн авах үр дүнтэй арга мөн" гэжээ ("Because We Have Them before Our Eyes, *New Era,* 2006 оны 4-р сар, 6–7).

Хүүхдүүд эсвэл сайн бичиж чаддаггүй хүмүүст зориулан бичих дасгалыг арай хөнгөн хэлбэрээр хийх хэрэгтэй. Жишээлбэл багш ихэнх мэдээллийг агуулсан бөгөөд суралцагсдаас цөөхөн зүйл асуусан маягт бөглөх

*Тэмдэглэл*

дасгал хийлгэж болно. Багш нар эдгээр суралцагсдад судрын богинохон хэсэг эсвэл тодорхой нэг асуултан дээр төвлөрсөн бичих даалгавар өгөх ба тэдэнд үүнийг гүйцэтгэх хангалттай цагийг өгөх ёстой.

Бичих үйл ажиллагааг дараах байдлаар хийвэл илүү үр дүнтэй байдаг:

- Багш зааврuudыг тодорхой бичиж өгвөл суралцагсад даалгавраа гүйцэтгэхдээ эдгээрийг эргэн харах боломжтой байдаг.
- Үйл ажиллагаа нь нөхцөл байдалтай нь холбогдсон сайн мэдээний үнэний талаарх тэдний бодолд тулгуурласан байх ёстой.
- Үйл ажиллагаа нь тэднийг сурсан үнэнүүдээ хэрэгжүүлэхэд туслах ёстой.
- Бичих дасгалыг хийж байхдаа багш нь суралцагсдыг дэмжиж, туслах шаардлагатай.
- Бичих дасгал хийх цаг нь даалгавартайгаа уялдсан байх ёстой.
- Үйл ажиллагааны үеэр сурсан зүйлээ тайлбарлаж, хуваалцаж эсвэл гэрчлэхийг суралцагсдаас хүс.
- Бичих дасгалын үеэр бичсэн хувийн бодол буюу амлалтуудыг нь өөр хэн нэгэн (үүний дотор багш) түүний зөвшөөрөлгүйгээр уншихгүй гэдэгт суралцагч итгэлтэй байх ёстой.
- Бичих дасгал нь хичээлийн чухал хэсэг бөгөөд үүнийг суралцагсдыг “завгүй байлгах” эсвэл тэднийг шийтгэх арга болгон хэрэглэх ёсгүй.
- Сайн бичиж чаддаггүй хүмүүст зориулсан “бодол санаагаа тэмдэглэх” өөр аргууд байдаг. Үүнд, өөр нэг суралцагчийг бичээч болгох, дуу бичлэг хийх гэх мэт олон аргууд багтдаг.
